



# НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

---

2005 оны жилийн тайлан

---

---

Жамьян гүний гудамж-5/1, Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар-48, Монгол Улс  
Утас: (976-11) 313207,  
Факс: (976-11) 324857  
Веб сайт: <http://www.forum.mn>

---

## Гарчиг

3	ӨМНӨТГӨЛ
4	ФОРУМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ: ЗАСАГЛАЛ
5	Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө
9	Нээлтэй ил тод төсөв
11	Сонгуулийн кампанит ажлын санхүүжилт
13	Төрийн үйлчилгээний мониторинг
15	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
16	Мэдээллийн эрх чөлөө ба иргэдийн оролцоо
18	Нутгийн болон төвлөрсөн удирдлага
20	Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж
22	Эрхзүйн туслалцаа
25	Төрийн бус байгууллагын эрхзүйн зохицуулалт
	ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО
27	Эдийн засгийн эрх чөлөөний индекс
29	Сүүдэр эдийн засгийн үүрэг, роль
31	Уул уурхайн салбарын бодлогын асуудал
32	Газрын шинэтгэлийн хэрэгжилт
36	Хувийн хөрөнгө оруулалтын сан
39	Хөгжлийн бодлогын яриа хэлэлцүүлэг
	БУСАД
41	Албадан ажил хийлгэх ялыг хэвшүүлэх төсөл
42	Дорно дорно хөтөлбөр
	ФОРУМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ:
43	Хөгжлийн мэдээллийн төв
45	Телевизийн хөтөлбөр
49	Портал сайт
52	Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр
53	Хэвлэн нийтлэл
	ХАВСРАЛТ
55	Санхүүгийн тайлан
60	Ажилтнууд

## ӨМНӨТГӨЛ

2005 он Монголын хувьд нийгэм, улстөр, эдийн засгийн төдийгүй нийгмийг доргиосон иргэдийн хөдөлгөөний идэвхжлийг өдөөсөн олон чухал үйл явдлаар дүүрэн жил байлаа.

Юуны өмнө дурдахад энэ онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль боллоо. Хэдийгээр Монгол Улс парламентын засаглалтай улс боловч ард түмний бүх нийтийн сонгуулиар Ерөнхийлөгчөө сонгодог учраас энэ сонгууль манай улсын улстөрийн амьдралд тун чухал үйл явдал болсон нь дамжиггүй юм.

2004 оны парламентын сонгуулиар Монголд анх удаа улстөрийн томоохон хүчнүүд тэнцвэртэй суудал авснаар их Эвслийн Засгийн газрыг байгуулсан билээ. Эвслийн Засгийн газар эрх барьсан жил гаруйн хугацаанд Монголын нийгэмд тулгарч ужгирсан олон чухал асуудлыг ил болгож, нээлттэй ярьж шийдэх түүхэн боломж бий болсныг тэмдэглэх хэрэгтэй юм. Тухайлбал, авилгал, хээл хахууль Монгол Улсын эдийн засгийн өсөлт, хөгжилтөд ноцтой хохирол учруулж байгааг төр, засгийн удирдах дээд төвшинд бодитой хүлээн зөвшөөрч авилгын эсрэг НҮБ-ын конвенцид нэгдэж Авилгатай тэмцэх хуулийг хэлэлцэж эхэлжээ.

АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Буш манай улсад анх удаа айлчилж, Монголын ардчиллыг өндрөөр үнэлэв. Чухам энэ онд арваад жилийн тэртээх ардчилсан хувьсгалыг санагдуулахуйц үйл явцын гараа нэгэнтээ эхэлжээ. Улаанбаатарын төв талбайд иргэний нийгмийн хөдөлгөөний төлөөлөгчид жагсаж, шар, нил ягаан, гүн ногоон өнгөөр тууз зүүн Монголд хувьсгал, өөрчлөлт шинэчлэлтийн шинэ давалгаа, түүнийг тээгч ард олны сэтгэлзүй бэлэн болсныг зарлав. Ардчилал олон нийтийн оролцоо, иргэний хөдөлгөөний идэвхжлээр дамжин гүнзгийрч байна.

Эрхзүйн шинэчлэлийн хоёр дахь давалгаа хүчээ авав. Өөрчлөгдөн байгаа Монголын нийгэмд өмнө цагт батлан мөрдүүлсэн олон хууль, эрхзүйн баримт бичгүүд шаардлага хангахаа больсныг харуулж эхэллээ. Ашигт малтмал, татвар болон авилгалын зэрэг чухал хуулиудын шинэ төслүүд өргөн баригдаж, олон нийт, хөдөлгөөн, улстөрийн хүчнүүд нэг ширээнд хамтран хэлэлцэх анхны боломж бүрджээ.

Эдийн засгийн шинэтгэлийн үр дүнгүүд мэдрэгдэж, Монголын эдийн засгийн өсөлт 2004 онд 10-иас илүү хувийг давсан бол 2005 онд 6,2 хувьд хүрлээ. Эдийн засгийн өсөлтийн шалтгааныг олборлох болон үйлчилгээний салбарын түлхүү хөгжил, өрсөлдөх чадварын шинэ нөхцөл байдалтай холбон дүгнэж буй бол бууралтыг тариалангийн ургац алдалт, нэхмэл оёмол бүтээгдэхүүнийг АНУ, Европын холбооны зах зээлд нийлүүлж байсан хөнгөлөлтийн нөхцөл цуцлагдсан зэрэгтэй эдүгээ холбон авч үзэж байгаа юм.

Монголын уул уурхайн салбар гадаадын хөрөнгө оруулалтыг эрчимтэй татаж эхлэв. Үүний хэрээр олон нийт, орон нутгийн ард иргэдийн зүгээс

байгаль орчин, татвар, улс орны хөгжлийн асуудлаар ярих, хэлэлцэх нь идэвхжиж ирлээ.

Хэвлэл, мэдээллийн салбарт шинэлэг үйл явдал элбэг тохиолоо. Нэн түрүүнд Монголын Үндэсний Радио, Телевизийг олон нийтийн болгох үйл явцыг энд дурдах хэрэгтэй юм. Олон арван жил төрийн мэдэлд байж олон нийтэд гэхээс илүү засаг, төрд илүүтэй үйлчилж байсан энэ байгууллагыг жинхэнэ олон нийтийн болгох шийдвэртэй алхмыг 2005 онд хийж чадлаа.

Энэ мэтчилэнгээр 2005 онд Монгол Улсад тохиосон олон чухал үйл явлууд, нэн чухал, суурь шинж чанартай шинэчлэлийн үйл явцад “Нээлттэй Нийгэм Форум” идэвхтэй байр суурьтай байж, тодорхой хувь нэмрийг оруулахыг зорьж ажиллалаа. Монголын нийгэмд өрнөсөн түүхэн үйл явцын дэлгэц дээр Нээлттэй Нийгэм Форумаас авч хэрэгжүүлсэн, санаачилсан, санхүүжүүлсэн, иргэний нийгмийн бусад байгууллагатай хамтран гүйцэтгэсэн арга хэмжээ, үйл ажиллагааны тайланг Та бүхэнд толилуулж буйдаа таатай байна.

**Нээлттэй Нийгэм Форумын  
Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал**

## ЗАСАГЛАЛ

### ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

Монгол Улс ардчилсан шинэтгэл эхлээд 15 жил болж байна. Энэ хугацаанд ардчилсан нийгмийн нэг гол үнэт зүйл болох чөлөөт хэвлэл, мэдээллийн үндэс суурь тавигдаж, хөгжлийн тодорхой шатанд хүрлээ. 1990 онд Монголд үндэсний ганц телевиз, радио, нэг намын харьяаллын өдөр тутмын нэг сонин, залуучууд, үйлдвэрчний эвлэл, зохиолчдын байгууллагын гэх тодотголтой долоо хоног тутмын цөөн хэвлэлтэй байсан бол эдүгээ Монголд өдөр тутмын долоон сонин /үүний нэг нь намын харьяалалтай/, 155 орчим чөлөөт сонин, 22 телевиз үйл ажиллагаа явуулж байна.



Хэдий тийм ч ард түмнийг тэнцвэртэй, шударга мэдээ мэдээллээр хангах хэвлэл мэдээллийн үндсэн үүрэг хангалтгүй биелж буйд Монголын олон нийт болон сэтгүүлчид өөрсдөө төдийлөн сэтгэл ханамжтай бус байгаа юм. Үүнд улстөр, нийгэм, эдийн засаг, бизнесийн олон хүчин зүйл нөлөөлж байдаг ч хамгийн гол шалтгааныг нь хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай ойлголт бүрэн төлөвшиж, түүний өөрийн зохицуулалтын механизмууд төгс хөгжиж чадахгүй байгаатай холбон авч үзэх нь түгээмэл байна. Иймээс Нээлттэй Нийгэм Форум байгуулагдсан цагаасаа эхлэн хэвлэл, мэдээллийн эрх чөлөөг дэмжих үйл явцад өөрийн анхаарлаа байнга чиглүүлэн ажиллаж эхэлсэн юм.

ННФ-ыг үндэслэгч Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн /Соросын сан/-гийн хэвлэл, мэдээллийн хөтөлбөрүүд энэ чиглэлд тодорхой үйл ажиллагаа явуулж байсныг дурдахгүй өнгөрч болохгүй. 2004 онд Монголын хувьд улстөрийн хоёр ч сонгууль болсонтой холбогдуулан ННФ "Сонгуулийн үеэр хэвлэл, мэдээллийн хэрэгслийн гүйцэтгэх үүрэг" төслийг хэрэгжүүлсэн бөгөөд улмаар 2005 оны гуравдугаар сараас эхлэн "Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө" төслийг хэрэгжүүлж эхлээд байна. ННФ энэ төслийн хүрээнд иргэний нийгмийн бусад байгууллагатай хамтран нөлөөллийн тодорхой үйл ажиллагааг тасралтгүй явуулж, Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл, Монголын Хэвлэлийн Хүрээлэн, Глоб Интернейшнл ТББ, АНУ-ын Бодлогын Хэлэлцүүлгийг Дэмжих Санаачилга, Лондон дахь Хэвлэл, Мэдээллийн Сүлжээ Хөтөлбөр зэрэг байгууллага болон хэвлэл, мэдээллийн бусад хэрэгсэлтэй хамтран ажиллалаа.

### Олон нийтийн радио, телевизийг дэмжих үйл явц

2005 оны нэгдүгээр сард Монголын парламент Олон нийтийн радио, телевизийн (ОНРТ) тухай хуулийг батлан гаргасан. Энэ бол Монголын ууган телевизийг төрийн өмчөөс олон нийтийн мэдэлд шилжүүлэх, Үндэсний радио, телевизийг олон нийтийнх болгох үндсийг тавьсан эрхзүйн чухал акт болсон юм. Энэхүү хуулийг батлуулахад ННФ багагүй хүчин чармайлт тавьж, анхнаас нь дэмжин ажилласан бөгөөд хуулийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүднээс ННФ нь төр, засгийн болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллалаа.

Юуны өмнө ОНРТ-ийн удирдах дээд байгууллага болох Үндэсний Зөвлөлийн 15 гишүүнд ТББ-уудын төлөөллийг нэр дэвшүүлэх үйл явцыг шударга, ил тод, өргөн хүрээнд явуулах үүднээс шат дараалсан арга хэмжээг Хэвлэлийн Хүрээлэн, бусад ТББ-тай хамтран зохион байгууллаа. Хуулийн дагуу шинээр зохион байгуулагдсан ОНРТ-ийн сэтгүүлчид, мэргэжилтнүүд, Үндэсний Зөвлөлийн гишүүд, иргэний нийгмийн төлөөлөгчдөд зориулан шинэ чиг үүргийн нь талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, олон улсын туршлагаас суралцах боломж олгох зорилгоор “Олон Нийтийн Радио, Телевизийн шилжилтийн үеийн тулгамдсан асуудлууд” сэдэвт олон улсын дугуй ширээний уулзалт ярилцлагыг ННХ-ийн Хэвлэл, Мэдээллийн Сүлжээ хөтөлбөртэй хамтран зохион байгуулав. Уулзалтад Польш, Эстони, АНУ, Румын, Английн экспертүүд оролцож, Монголын радио, телевизийн нэвтрүүлгийн бодлого, санхүүжилт, өөрийн удирдлага, бүтэц, зохион байгуулалтын талаар Монголын мэргэжилтнүүдийн тавьсан илтгэлүүдийг сонсч, харилцан ярилцаж тулгамдсан асуудлуудаар зөвлөгөө өгөв. Дугуй ширээний ярилцлагын үр дүнд ОНРТ-д шилжих цаашдын бодлого, үйл ажиллагааны тухай санал зөвлөмж гаргаж Үндэсний Зөвлөлд өргөн барьсан нь үйл ажиллагаагаа эхлэхэд нь тулгуурлах анхны суурь баримт бичиг болсон юм. ОНРТ-ийн шилжилтийн үйл явцыг дэмжих үйл ажиллагааг бид цаашид үргэлжлүүлэн явуулах болно.

#### “Олон нийтийн радио, телевиз. Шилжилтийн үеийн тулгамдсан асуудлууд” олон улсын дугуй ширээний ярилцлагад оролцогсдын зөвлөмжөөс

1. Үндэсний зөвлөл нь ОНРТ-ийн стратегийн баримт бичиг, журам дүрмийг үйл ажиллагааны төлөвлөгөөний хамт боловсруулах,
2. Зөвлөлийн хурлын тэмдэглэл болон бусад бүх бичиг баримт олон нийтэд ил тод байх бөгөөд өөрийн нөхцөлд тохирсон ёсзүйн зарчим батлах,
3. Санхүү, менежмент, хөтөлбөрийн асуудал эрхэлсэн дэд хороо байгуулах,
4. Засгийн газартай санхүүжилтийн удаан хугацааны гэрээ хийх, бизнес төлөвлөгөө боловсруулах,
5. ОНРТ-ийн ерөнхий захирал, дэд захирал болон бусад удирдах албан тушаалтныг томилохдоо нээлттэй, ил тод зарчим баримтлан сонгон шалгаруулах нь зүйтэй.

### **Хэвлэл, мэдээллийн өөрийн зохицуулалт**

Хэвлэл, мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийг бичиж нийтлүүлсэн зүйлийнхээ төлөө шүүхэд очихоос нь өмнө сэргийлэх, нөгөөтэйгүүр олон нийтийн санал гомдлыг барагдуулахад чиглэсэн бүтэц буюу өөрөө өөрийгөө зохицуулах механизм олон улсын пратикт маш өргөн хэрэглэгддэг. Монголд чөлөөт хэвлэл хөгжсөн 15 орчим жилийн туршлагаас харахад энэхүү бүтцийг бий болгох хэрэгцээ шаардлага улам өссөөр байна. 2004 онд 200 сэтгүүлчдийг хамарсан судалгаагаар 81 хувь нь Хэвлэлийн Зөвлөл хэрэгтэй гэж үзсэн бөгөөд ННФ ийм хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг тандах зорилгоор туршилтын төсөл



хэрэгжүүлээ. Сэтгүүлчдийн баримтлах ёсзүйн дүрмийн хэрэгжилтийг хянахад чиглэсэн Хэвлэлийн Зөвлөл байгуулах боломж, нөхцлүүдийг судлах ажлыг 2005 онд үргэлжлүүлж, олон улсын туршлагаас суралцах зэргээр Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлтэй хамтран ажиллалаа.

### **Сэтгүүлчдийн ур чадварыг дээшлүүлэх нь**

Хараат бус хэвлэл, мэдээллийг дэмжих нэг арга зам нь мэргэжлийн сэтгүүлчдийн ур чадварыг хөгжүүлэх явдал юм. 2005 онд эдийн засаг болон хөгжлийн асуудлуудын талаар бичдэг сэтгүүлчдийн дадлага, туршлагыг өргөжүүлэхэд түлхүү анхаарлаа. АНУ-ын Бодлогын Хэлэлцүүлгийг Дэмжих Санаачилга (БХДС буюу IPD) байгууллагатай хамтран сургалт семинар зохион байгуулав. Энэ сургалт нь хөгжлийн асуудлаарх мэдлэг, мэдээллийг түгээдэг олон улсын туршлагатай эдийн засагчид, сэтгүүлчидтэй Монголын сэтгүүлчдийг уулзуулан туршлага судлуулах, мэдээ, мэдээлэл, нийтлэлийн стратеги тоймлон гаргахад нь тус дөхөм болох зорилготой байв. Тэрчлэн Форум БХДС-тай хамтран эдийн засаг болон хөгжлийн асуудлаарх шилдэг цуврал нийтлэлийн уралдааныг сэтгүүлчдийн дунд зарлан явууллаа. Мөн эдийн засаг, бизнесийн чиглэлээр хэрхэн бичих талаар цуврал гарын авлагыг хэвлэн нийтлүүлэв. Энэ төсөл үргэлжлэн хэрэгжих юм.

### **Сэтгүүлчдийн эрх ашгийг хамгаалах нь**

Монголын сэтгүүлчид мэргэжлийн үүргээ гүйцэтгэх явцдаа олон саад бэрхшээлтэй учрахын сацуу үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхэд нь

элдэв хорио хязгаар тулгарсаар байна. 2004 онд улстөрийн сэдвээр мэдээ материал бэлтгэдэг 200 сэтгүүлчийн дунд явуулсан судалгаагаар “Монголд цагдан хяналт бодитой байдаг”, мөн “өөрийгөө хянадаг” гэж оролцогсад нь 100 хувь хүлээн зөвшөөрчээ. Хамгийн их буюу 29 хувь нь “миний эрх ашгийг хамгаалах байгууллага байхгүй”, 27,5 хувь нь “хууль, эрхзүйн орчин таатай бус учир шоронд орохоос айдаг”, 15,5 хувь нь “цагдаа, хүчний байгууллага, шүүхэд дуудагдахаас айдаг” гэжээ. Есөн хувь нь шийтгүүлэх, цалингаа хасуулах, ажлаас халагдахаас, долоон хувь нь эх сурвалжаа нотолж чадахгүйгээс айдаг гэж хариулсан байдаг. Freedom House-ийн судалгаагаар Монгол Улс 2005 онд хэвлэлийн бүрэн эрх чөлөөтэйгээс хагас эрх чөлөөтэй гэсэн ангилалд оржээ. Иймд цаашид сэтгүүлчдэд эрхийг нь таниулах, хуулийн мэдлэг олгож зөвлөгөө өгөх, эрх ашгийг нь хамгаалахын төлөө ажиллах зайлшгүй шаардлагатай байна. Энэ ажилд бодит хувь нэмэр үзүүлэх зорилгоор ННФ “Глоб Интернэшнл” ТББ-ын хэрэгжүүлж буй “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлийн мониторинг ба хараат бус хэвлэл, мэдээллийг дэмжих нь” төслийг Лондон дахь Хэвлэл, Мэдээллийн Сүлжээ Хөтөлбөртэй хамтран санхүүжүүлж байна.

12 сар үргэлжлэх энэ төслөөр Олон Улсын Үзэл Бодлоо Илэрхийлэх Эрх Чөлөөний Солилцоо (IFEX) болон Москвад төвтэй Хүнд Нөхцөл Байдалд буй Сэтгүүлчдийн Төв зэрэг байгууллагатай хамтран Монгол дахь үзэл бодлын чөлөөт илэрхийллийн хяналтын чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн харилцан уялдаатай хоёр үйл ажиллагаа явуулах юм. Одоогоор эрхзүйн туслалцааны асуудлаар сургалт явуулж эхлээд буй бөгөөд үзэл бодлын чөлөөт илэрхийллийн байдлын тухай мэдээг үндэсний болон олон улсын хэмжээнд түгээж байна. Мөн үзэл бодлын эрх чөлөөний зөрчлийг илрүүлж мэдээлдэг мониторингийн баг буюу Үндэсний сүлжээг байгуулан ажиллуулж байна.



## НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД ТӨСӨВ

Төсвийн үйл явцад иргэдийн оролцоо хангалтгүй байгаа нь тэдний төрд итгэх итгэлийг бууруулж, төрийн байгууллагуудын хариуцлага хүлээх явдлыг сулруулж байна. Нээлттэй Нийгэм Форум улсын болон орон нутгийн төсвийг нээлттэй, ил тод болгоход чиглэсэн үйл ажиллагааг 2005 онд хэрэгжүүлэхдээ төсвийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг иргэдэд хүргэхийн зэрэгцээ улсын төсвийн бүрдүүлэлт, зарцуулалтад төрийн бус байгууллагууд мониторинг хийх ажлыг дэмжихэд түлхүү анхаарч ажиллалаа.

Төсвийн мэдээллийг ил тод болгох үүднээс Засгийн газраас УИХ-д өргөн барьсан, эдийн засгийн салбар, төсөв ерөнхийлөн захиран зарцуулагч нэг бүрээр ангилсан 2006 оны төсвийн төсөл, 2006 оны төсвийн хүрээний мэдэгдлийг бүрэн эхээр нь вэб порталд тавин анх удаагаа өргөн олон нийтэд хүргэснээр төсөв төлөвлөлт, түүний нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх чиглэлтэй уялдсан байдалд иргэд өөрсдөө дүгнэлт хийх боломжийг бүрдүүллээ. Тэрчлэн төсвийн мэдээллийг ойлгох, төсвийн үйл явцад иргэд оролцоог хангах зорилгоор улсын болон орон нутгийн төсвийн төсвийн талаарх гарын авлагыг тус тусад нь боловсруулан гаргалаа.

Төсвийн үйл явцыг ил тод болгох эрмэлзэл бүхий дотоод, гадаадын байгууллагуудтай хамтран ажиллах үүднээс Казахстан улсад болсон төсвийн ил тод, нээлттэй байдлыг дэмжих бүсийн олон улсын уулзалтад УИХ-ын Төсвийн байнгын хорооны гишүүн, Сангийн яамны ажилтан, төрийн бус байгууллагын төлөөлөгчдөөс бүрдсэн баг оролцож, цаашдын хамтын ажиллагааны үндсийг тавив. Мөн АНУ-ын Олон Улсын Төсвийн Төсөл байгууллагатай хамтран ажиллаж, 2005-2006 онд дэлхийн 60 гаруй оронд хийгдэж буй "Нээлттэй төсвийн асуулга" судалгааны Монголын талаарх хэсгийг ННФ гүйцэтгэв. Энэхүү судалгааны 2004 оны асуулгаар Монгол Улс төсвийн ил тод, нээлттэй байдлын хувьд хамгийн доогуур байрт орж байсан бол одоо энэ үзүүлэлт бага зэрэг ахисан байдалтай байна. Судалгааны эцсийн дүн 2006 оны хоёрдугаар улиралд гарах юм.

Эдгээр үйл ажиллагааны дүнд иргэд төсвийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг авч ашиглах, төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавихад шаардлагатай суурь мэдээллээр тодорхой хэмжээгээр хангагдсан хэдий ч төрийн байгууллагууд мэдээллийг олон нийт ашиглаж болохуйц байдлаар тогтмол, дэлгэрэнгүй өгөх тал дээр ихээхэн чармайлт гаргах хэрэгтэй байна. Ялангуяа орон нутгийн болон төсвийн санхүүжилттэй агентлаг, аж ахуйн нэгжүүдийн хувьд дэлгэрэнгүй мэдээлэл тэр бүр байхгүй байгаа юм.

Иргэний нийгмийн байгууллагууд төсвийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих явдалд түлхэц өгөх үүднээс Нээлттэй Нийгэм Форум 2004 онд эхлүүлсэн "Боловсролын салбар дахь төсвийн зарцуулалтын судалгаа"-г энэ онд үргэлжлүүлэн гүйцэтгэлээ. Энэ нь иргэний нийгмийн

зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих, дүн шинжилгээ хийх хамгийн анхны иж бүрэн оролдлого болсон юм. Улсын нийт төсвөөс Монголын боловсролын салбарт зарцуулж буй хувь хэмжээ нь бусад улс оронтой харьцуулахад ихээхэн өндөр байгаа атал энэ салбарын төсөв хөрөнгийн зарцуулалтын үр ашгийн талаар өнөөг хүртэл нарийвчлан авч үзээгүй, мөн салбарын төсвийг зохицуулах хууль өөрчлөгдсөн нь уг судалгааг хийх зайлшгүй шаардлага болсон юм. Сургууль, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн болон төрийн төв байгууллага зэрэг тодорхой төвшнийг харьцуулан судалснаар бодлого боловсруулах үйл явцыг бодит баримт мэдээллээр хангахын зэрэгцээ боловсролын салбарын төсвийн төлөвлөлт, зарцуулалтад хяналт тавих олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилтыг тавьсан болно.

Төрийн үйл ажиллагаанд төрийн бус байгууллагын зүгээс хяналт тавих, мониторинг хийх явдлыг дэмжих үүднээс төсөл сонгон шалгаруулах уралдаан зарлаж төсвийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт хийх дөрвөн төслийг шалгаруулав. Үүнд, “Нийгмийн Дэвшил, Эмэгтэйчүүд” хөдөлгөөн төсвийн хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлтэд, уг хөдөлгөөний Өвөрхангай аймаг дахь салбар зөвлөл хоёр сумын төсвийн үйл явц, сахилга хариуцлагыг олон нийтийн оролцоотойгоор хянах, “Төмөр Сан” нийгмийн халамжийн үйлчилгээнд, “Тул Хамгаалах Нийгэмлэг” байгаль хамгаалах сангийн зарцуулалтад тус тус мониторинг хийхээр боллоо.

Дээрх үйл ажиллагааны үр дүнд төсвийн үйл явц дахь иргэдийн оролцоо болон энэ сэдвээр сонин хэвлэлээр ярилцах явдал нэмэгдэж байна. Гэхдээ иргэдийн оролцоог илүү үр дүнд хүргэхийн тулд цаашид төсвийн дүн шинжилгээ хийдэг судлаачдыг бэлтгэх, нарийн судалгаанд тулгуурласан ярилцлага, мэтгэлцээнийг өрнүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

## **БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ТӨСВИЙН СУДАЛГАА**

Нээлттэй Нийгэм Форум Дэлхийн Банктай хамтран энэ судалгааны аргазүйг боловсруулж сургуулийн байршил хэмжээг харгалзан 118 сургуулийг тохиолдлын түүврийн аргаар сонгож, мэдээллийг хоёр үе шаттайгаар цуглуулав.

Эхний үе шатанд сургуулийн захирал, сургалтын менежер, багш, эцэг эх, сурагч, нягтлан бодогч нарын 1500 хүнээс асуулга авсны үндсэн дээр 2004 оны санхүүгийн жилийн төсвийн зарцуулалтыг сургууль, аймаг, төвийн төвшинд харьцуулалт хийх зорилгоор тоон мэдээлэл цуглуулав. Хоёр дахь үе буюу 2005 оны 8 дугаар сард Булган, Говь-Алтай аймгийн сургууль, Боловсрол, соёлын газар, Төрийн сангийн төсвийн мэргэжилтнүүдтэй уулзаж, чанарын мэдээллийг нэгтгэлээ.

Мэдээлэлд анализ, шинжилгээ хийсний үндсэн дээр нийт найман бүлэг тайлан боловсруулж, Монголын боловсролын салбарын статистик, төсөв, санхүүгийн хүрээний шинэчлэлийн тойм, төсвийн төлөвлөлт ба удирдлага, сургуулийн зардал, багш нарын цалин, орлогын асуудал зэрэгт дүгнэлт хийж, бодлогын зөвлөмж боловсруулав. Дүгнэлтийг 2005 оны есдүгээр сард боловсролын салбарын мэргэжилтнүүд, бодлого боловсруулагчид болон тус салбарын мастер төлөвлөгөөг боловсруулж байгаа ажлын хэсэгт танилцуулав.

## СОНГУУЛИЙН КАМПАНИТ АЖЛЫН САНХҮҮЖИЛТ

Сонгуулийн кампанийн санхүүжилтийн авилгалыг бууруулах, тэгш нөхцөл бүхий шударга сонгуулийг дэмжих, эрхзүйн орчин, зохицуулалтын хүрээг боловсронгуй болгох замаар сонгуулийн ил тод байдлыг бий болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор Нээлттэй Нийгэм Форум сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн асуудалд онцгой анхаарал хандуулан ажиллаж байна. 2003 оноос эхлэн нөхцөл байдлын судалгаа хийж улмаар олон нийтийн болон ТВ-ийн хэлэлцүүлэг хийсэн бөгөөд 2004 оны УИХ-ын сонгуулийн үеэр “Сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн мониторинг”-ийг Сонгогчдын Боловсрол Төв болон “Глоб Интернэшнл” ТББ-тай хамтран Будапештэд төвтэй Нээлттэй Нийгмийн Эрхзүйн Санаачилга байгууллагын аргачлал, техникийн туслалцаатайгаар хэрэгжүүлсэн юм.

Монголын парламент 2005 онд УИХ-ын сонгуулийн хуулийг шинэчлэх асуудлыг хөндөж хуулийн төслийг боловсруулах шинэ ажлын хэсгийг байгуулсантай холбогдуулан ННФ өмнөх онуудад хийсэн судалгаа, мониторингийн үр дүн, зөвлөмжийг ажил хэрэг болгоход түлхүү анхаарч ажиллалаа. Нэн ялангуяа сонгуулийн кампанийн санхүүжилтийг зохицуулах асуудлыг УИХ-ын сонгуулийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах, тэрчлэн уг хууль нь ардчиллын баталгааны суурь болдгийн хувьд олон улсын стандарт туршлагаас хуваалцах, тусгайлан олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахад үйл ажиллагаагаа төвлөрүүлэв. Энэ зорилгоор Будапештэд төвтэй Нээлттэй Нийгмийн Эрхзүйн Санаачилга байгууллага болон Олон Улсын Ардчилал болон Сонгуулийн туслалцаа /IDEA/ зэрэг байгууллагатай хамтран ажиллалаа. Эдгээр байгууллагаас хуулийн төсөл дээр дэлгэрэнгүй санал зөвлөмж ирүүлснийг УИХ-ын гишүүдэд хүргэсний зэрэгцээ энэ байгууллагын зөвлөхүүд Сонгуулийн хуулийг боловсруулах УИХ-ын ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, УИХ-ын гишүүдэд зориулан хэлэлцүүлэг уулзалт зохион байгуулав.

Нээлттэй Нийгэм Форум УИХ-ын ажлын хэсэгтэй хамтран УИХ-ын сонгуулийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийг олон нийтэд танилцуулах, санал авах зорилгоор цуврал хэлэлцүүлгийг “УИХ-ын сонгуулийн тогтолцоо”, “УИХ-ын сонгуулийн жендерийн тэгш байдал”, “Сонгуулийн санхүүжилт, сурталчилгаа, хуульзүйн баталгаа”, “Сонгуулийн төв байгууллага” зэрэг сэдвээр зохион байгууллаа. Цуврал хэлэлцүүлэгт төрийн болон төрийн бус байгууллага, улстөрийн нам, судлаачид, хэвлэл мэдээллийн байгууллагын 150 гаруй төлөөлөгч оролцож, санал, бодлоо илэрхийлжээ. Санал зөвлөмжийг олон нийтэд болон бодлого боловсруулагчдад хүргэх үүднээс өдөр тутмын сонинд хэвлүүлж, УИХ-ын гишүүдэд албан ёсоор хүргүүлжээ. Түүнчлэн УИХ-ын сонгуулийн тухай хуулийн төслөөр цахим хэлэлцүүлэг зохион байгуулан [www.forum.mn](http://www.forum.mn) вебсайт дээрээ байрлуулав.

Улмаар УИХ-ын сонгуулийн хуулийг парламент 2005 оны 12 дугаар сард шинэчлэн батлав. Энэхүү хуулинд ННФ-аас 2004 онд хийлгэсэн мониторингийн гол дүгнэлт, зөвлөмжид тусгасан зарим асуудал шийдэгдсэн юм. Тухайлбал, сонгуулийн хандив болон зарцуулалтын дээд хязгаарыг тогтоосон бөгөөд сонгуулийн кампанит ажлын үеэр төрийн эх үүсвэрийг ашиглах зарим хэлбэрийг хориглосон байна. Төрийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн өмч хөрөнгийг сонгуулийн сурталчилгаанд аливаа хэлбэрээр ашиглах, төрийн жинхэнэ албан хаагчийг татан оролцуулах, сонгогчдын саналыг татах зорилгоор хүлээн авалт, цайллага зэрэг сонгуулийн бус олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахыг



хориглосон болно. Мониторингийн үеэр ажиглагдсан гол зөрчил болох намуудын төлбөртэй сурталчилгааг ОНРТ-ээр явуулахыг хориглож, арилжааны телевизээр явуулах төлбөртэй сурталчилгаа нь тухайн радио, телевизийн нэвтрүүлгийн нийт хугацааны 10 хувиас хэтрэхгүй байхаар хуульчилсан байна. Сурталчилгаа нь Сонгуулийн ерөнхий хорооноос батлагдсан эрх тэгш хуваарийн дагуу явагдахаар заажээ. Энэхүү хуулиас гадна Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийг мөн баталсан бөгөөд түүнд санхүүжилтийг зохицуулах холбогдох заалтууд орсон юм.

2005 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль боллоо. Энэ сонгуулийн үеэр ННФ сонгуулийн тухай мэдээллийг олон нийтэд хүргэх зорилгоор портал сайт дээрээ ажиглалт явуулсны зэрэгцээ сонгуулийн орой өөрийн байран дээр студи ажиллуулан сонгуулийн дүнг шууд олон нийтэд хүргэлээ. Энэ студийг "Транспаренси Интернэншл" байгууллагын Монголын салбартай хамтран ажиллуулж, Ийгл ТВ-ээр шууд нэвтрүүлэн хэвлэл мэдээлэл, ТББ-ын төлөөлөгчдөд танилцуулга, мэдээлэл хийсэн. Дээрхтэй ижил сонгуулийн студийг 2004 оны УИХ-ын сонгуулийн үеэр явуулж байлаа.

## ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МОНИТОРИНГ

Сүүлийн жилүүдэд Монголд авилгал улам бүр газар авч буй тухай ойлголт нийгмийн бүхий л төвшинд бүрдсэн байгаа нь судалгаагаар тод томруун харагдах боллоо. 1996 онд батлагдсан Авилгалын эсрэг хууль, 2002 онд батлагдсан Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт туйлын хангалтгүй байгаагийн зэрэгцээ авилгалын эсрэг болон хууль эрхзүйн орчныг сайжруулах талаар ихэвчлэн олон улсын байгууллагын дэмжлэг, нөлөөний үр дүнд Засгийн газар зарим нэг арга хэмжээг авч байгаа ч дорвитой үр дүн гарахгүй байна.

Нөгөөтэйгүүр Монголд иргэний нийгмийн чухал бүрэлдэхүүн хэсэг болох төрийн бус байгууллагуудын /ТББ/ тоо нэмэгдсэн хэдий ч тэдгээрийн үйл ажиллагаа голчлон иргэдийн боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгаанд чиглэж байна. ТББ-уудын нэг гол үүрэг болох төр, засгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих асуудал эхлэл төдий байна. Энэ нь ТББ-уудын энэ чиглэлийн чадавхи, нөөц бололцоо хязгаардлагдмал, төр, засгийн үйл ажиллагааны ил тод байдал хангалтгүй байгаатай холбоотой юм.

Иймээс ННФ төрөөс иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний ил тод байдлыг хангах, төрийн бус байгууллагуудын хөндлөнгийн хяналт тавих чадавхийг бэхжүүлэх зорилгоор 2005 онд төрийн үйлчилгээний мониторингийн тэтгэлэгт хөтөлбөрийг ТББ-уудын дунд зарлалаа. Төрийн үйлчилгээний мониторинг нь төрөөс үзүүлж байгаа тодорхой үйлчилгээний ил тод байдал, иргэдийн эрх зөрчигдөж буй байдал, хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар баримт мэдээлэл цуглуулах, хуулийн цоорхой бий эсэх талаар эрхзүйн орчинд анализ хийх, өөрчлөн сайжруулах талаар санал зөвлөмж боловсруулах нөлөөллийн цогц үйл ажиллагаа юм.

Тэтгэлэгт хөтөлбөрийг нээлттэй зарлаж сонгон шалгаруулахад нийтдээ 37 байгууллага төслийн саналаа ирүүлснээс тодорхой шалгуурт үндэслэн 15 төрийн бус байгууллагыг сонгож мониторингийн үйл ажиллагаанд тэтгэлэг олгов. Тухайлбал, Хуульч Эмэгтэйчүүдийн Холбоо аж ахуйн зориулалтаар барилга байгууламж барих иргэн, аж ахуйн нэгжид газар олгох төрийн үйлчилгээнд, Нийгмийн Судалгааны Байгууллагуудын Хамтын Ажиллагааг Дэмжих Төв иргэдэд газар өмчлүүлэх, эзэмшүүлэх төрийн үйлчилгээнд, Монголын Худалдаа, Эд Хэрэглэгчийн Хоршооны Төв Холбоо нийтийн орон сууцны дэргэдэх хүүхдийн тоглоомын талбайн газар олголтод, Зориг Сан нь гаалийн албадын үйл ажиллагаанд, Эмэгтэйчүүдийн Холбоо тусгай зөвшөөрөл олголтод, Монголын Эм Найруулагчдын Холбоо эм барих лиценз олголтод, Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүдийн Хөдөлгөөн төсвийн хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлтэд, Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүдийн Хөдөлгөөний Өвөрхангайн салбар нь орон нутгийн төсөвт, Бэр Цэцэг Холбоо цэргийн дүрэмт хувцасны хангалтад, Төмөр Сан нийгмийн халамж үйлчилгээнд, Монголын Тул Хамгаалах Нийгэмлэг байгаль хамгаалах санд, Хүний

Эрх, Шударга Ёс Хөдөлгөөн эрүүгийн анхан шатны шүүх хуралдааны үйл ажиллагаанд, Хүний Эрх, Хөгжил Төв орон нутгийн шүүхийн үйл ажиллагаанд тус тус мониторинг хийхээр болсон байна.

Энэхүү тэтгэлэгт хөтөлбөрийн өөр нэг гол зорилго нь ТББ-уудын мониторингийн чадавхийг дээшлүүлэх, аргачлалын ур чадварыг бэхжүүлэх явдал юм. ННФ мониторингийн удирдамж, сургалт, ашиглах эх сурвалж бүхий аргачлалыг боловсруулж цуврал сургалт зохион байгууллаа. Анхан шатны мониторингийн сургалтыг Чехийн “Транспаренси Интернэшнл” байгууллагын зөвлөх, хоёр дахь шатны сэдэвчилсэн аргачлалын сургалтыг Латвийн Провидус төвийн сургагч



багш нар явууллаа. Зөвлөх багш нар нь сургалтаас гадна байгууллага бүртэй ганцаарчилан уулзаж, мониторинг хийхэд тулгарч буй бэрхшээлийг хэрхэн шийдэх талаар практик зөвлөмж өгөв.

Мониторингийн тайлангууд 2006 онд гарч, нөлөөллийн үйл ажиллагаа хийгдэх юм. Цаашдаа ННФ энэхүү тэтгэлэгт хөтөлбөрийг жил бүр зарлан явуулах бөгөөд хамрах чиглэл, хүрээг улам өргөжүүлэн, тодорхой хуулийн хэрэгжилтэд мониторинг хийх болно.

Авилгалтай тэмцэх бодлогын шинэчлэл хийгдэх гэж буйтай холбогдуулан ННФ “Монгол дахь авилгалын асуудалд холбогдох номзүй”- г Зориг сантай хамтран боловсруулж хэвлэлээ. Энэ бол Монгол дахь авилгалын асуудалд холбогдох бүх эх сурвалжийг багтаасан анхны номзүй бөгөөд тухайн сэдвээр судалгаа хийдэг гадаад, дотоодын эрдэмтэн судлаачид, төрийн болоод төрийн бус байгууллагын ажилтнууд, бодлого боловсруулагчид, хандивлагчдад зориулагдсан юм.

## **ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГА**

Эдүгээ Монгол Улс нөөц баялаг ихтэй улс орны тоонд нэгэнтээ оржээ. Энэ хэрээр уул уурхайн салбарын Монголын эдийн засагт гүйцэтгэх үүрэг улам бүр өсөн нэмэгдэж байна. Гэхдээ нөөц баялаг ихтэй хөгжиж буй олон улс орон тухайн салбараас хэт хамааралтай болж, цөөн тооны эрх мэдэлтнүүд орлогыг өөрсдийн мэдэлд төвлөрүүлж авилга, хээл хахууль цэцэглэж, зүй зохисгүй зарцуулсан жишээ их бий. Улмаар “голланд өвчин” тусах буюу боловсруулах салбар уналтад орж, цаашлаад ардчилал, эдийн засаг нь хямралд орсон улс цөөнгүй. Ийм нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, уг салбарын тогтвортой өсөн дэвжих нөхцлийг хангах зайлшгүй чухал нэг хүчин зүйл бол олборлох салбарын орлогын ил тод байдлыг хангах явдал юм.

Монголд уул уурхайн үйлдвэрлэл хурдацтай өсөхийн хэрээр лицензийн наймаа, авилгал газар авсан тухай мэдээлэл нийгэмд хүчтэй тархаж буй нөхцөлд уг салбарын ил тод байдлыг сайжруулах нь онцгой ач холбогдолтой хэмээн үзэж ННФ энэ чиглэлд түлхүү анхаарал хандууллаа. Их Британийн Засгийн газраас санаачлан хэрэгжүүлж буй Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай санаачилгад (ОҮИТБС) Монгол Улс нэгдэн орох боломжийг судалж бэлтгэл ажлыг хангахад Форум тодорхой хүчин чармайлт гаргав.

Энэ зорилгоор “Төлснөө нийтэл” ТББ-уудын эвсэл, Орлогын Ажиглагч хөтөлбөр, Дэлхийн банк, ОҮИТБС-ын нарийн бичгийн дарга нарын газар зэрэг байгууллагатай хамтран уг санаачилгын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэсний зэрэгцээ төрийн бус байгууллагуудыг уг санаачилгад идэвхтэй оролцуулах эхлэлийг тавьсан болно. Түүнчлэн ОҮИТБС-ын сурвалж бичиг, “Сайхан ярианы цаана” судалгааг орчуулж хэвлүүлээ.

Уг санаачилга бусад улс оронд хэрхэн хэрэгжиж буй талаарх тодорхой мэдээллээр бодлого боловсруулагчдыг хангахын хамт Засгийн газрын холбогдох албадын төлөөлөл бүхий багийг Киргизстан Улсад туршлага судлахад дэмжлэг үзүүлэв.

Түүнчлэн олборлох салбарын орлогыг ил тод, оновчтой захиран зарцуулах боломжийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой Байгалийн нөөцийн менежментийн тухай хууль боловсруулах хэрэгцээ шаардлагыг судлах зорилгоор, тогтворжилт хөгжлийн сангийн талаар төрийн байгууллагын төлөөлөгчдөд зориулсан семинарыг Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газартай хамтран зохион байгууллаа.

## МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Сайн засаглал, төрийн ил тод, хариуцлагатай байдлын гол үндэс суурь нь иргэдийн мэдээлэл олж авах, хүртэх эрхийн баталгаа, түүний хэрэгжилт байдаг. Монгол Улсын Үндсэн Хуулинд мэдээлэл авах эрхийг хуульчлан заасан боловч баталгаажуулж зохицуулсан тусгай хууль байдаггүйгээс иргэдийн төр, засгийн мэдэлд буй мэдээллийг олж авах, хүртэх боломжийг хязгаарлаж байна. Иймээс ННФ 2003 оноос Мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулах талаар идэвхтэй ажиллаж, бусад улс орны туршлагаас суралцан холбогдох мэдлэг, мэдээлэл түгээж, харьцуулсан судалгаа хийлээ. “Мэдээллийн эрх чөлөөний тухай”



хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг 2005 онд Хууль зүй, Дотоод Хэргийн сайдын тушаалаар байгуулж, ХЗДХЯ болон бусад агентлагийн мэргэжилтнүүд, “Глоб Интернэшнл” ТББ, Нээлттэй Нийгэм Форум оролцон ажиллаж байна. Ажлын хэсэг ННФ болон “Глоб Интернэшнл” ТББ-аас боловсруулсан “Мэдээллийн эрх чөлөөний тухай” хуулийн төслийг улам боловсронгуй болгох талаар ажиллаж байна.

Хуулийн төсөлд иргэд бүх шатны төрийн захиргааны байгууллага болон нийтэд үйлчилдэг хувийн өмчийн хуулийн этгээдээс аливаа мэдээллийг бичгээр эсхүл амаар биечлэн хүсэлт гаргаж хүлээн авах эрхтэй. Уг хүсэлтэд төрийн байгууллага шууд хариу өгөх боломжтой бол зохих хариуг өгөх, боломжгүй бол хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногт багтаан заавал хариу өгөх тухай тусгаад байна. Түүнчлэн хүний амь нас, эрүүл мэнд, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах үндэслэл байвал хариуг 48 цагийн дотор өгөх, хэрвээ хариу өгөхгүй бол иргэд Хүний Эрхийн Комисс болон шүүхэд гомдол гаргах эрхтэй байхаар тусгасан юм. Төрийн байгууллага бүр иргэдийг мэдээллээр хангах үүрэг бүхий ажилтантай байх, мэдээллийн сан байгуулах, тухайн төрийн байгууллагаас авч болох мэдээллийн жагсаалтыг нийтэд мэдээлэх, гаргасан шийдвэр, мэдээллийг хэвлэн нийтэлж байх үүргийг нарийвчлан тусгажээ.

Хуулийн төслийг олон улсын нийтлэг жишигт нийцүүлэн боловсруулах зорилгоор олон улсын байгууллагуудтай нягт хамтран ажиллаж байна. Нью-Йоркт байрладаг Нээлттэй Нийгэм Хүрээлэн, “19-р зүйл” байгууллага болон “Access Europe” зэрэг байгууллагаас хуулийн төсөл



дээр дүн шинжилгээ хийлгэн, санал зөвлөмж авлаа. Эдгээр зөвлөмжид мэдээллийн нууцлалын хязгаарлалтыг бууруулах, мэдээллийн эрх чөлөөний талаарх гомдлыг шийдвэрлэх болон иргэдийн гэгээрэл, төрийн ажилтнуудын сургалт зэрэг чиг үүргийг хариуцсан Мэдээллийн комиссар бий болгох талаар судлан авч үзэхийг санал болгожээ. Мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулан хангахын нэг гол ач холбогдол нь хөгжлийн асуудалд, ялангуяа бодлого боловсруулах шатанд иргэдийн идэвхтэй оролцоог бий болгох явдал юм. Энэ асуудлыг ННФ 2005 оны бодлогын тэтгэлэгт хөтөлбөртөө тусгасны үндсэн дээр “Шийдвэр гаргах явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь: Эрхзүйн орчин болон институтчилэл” сэдвээр МУИС-ийн Социологийн тэнхмийн багш Ч.Тамир бодлогын судалгаа хийлээ. Иргэдийн оролцоог ерөнхийд нь ихээхэн ярьж, бичиж, тунхаглаж байгаа ч яг тухайлсан, нарийвчилсан судалгаа төдийлөн хийгдээгүй байгаа өнөөгийн нөхцөлд энэ судалгаа нь иргэдийн оролцооны байдал, эрхзүйн орчинг үнэлэхэд дүн шинжилгээ хийснээрээ чухал ач холбогдолтой боллоо. Тэрчлэн шийдвэр гаргах үйл явцыг улам бүр нээлттэй, ил тод, иргэдийн оролцоотой болгоход чиглэсэн эрхзүйн таатай орчин бүрэлдүүлэх, түүнийг хэрэгжүүлэх тодорхой арга зам, механизмыг бий болгох бодлогын зөвлөмжийг боловсруулан гаргасан юм. Энэхүү бодлогын судалгааны тайланг бодлого боловсруулагчид болон иргэний нийгмийн байгууллагуудад үйл ажилаагаанд нь мэдээллийн эх сурвалж болох үүднээс хүргэх юм.

### **ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦАД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ ТАЛААРХ БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ЗӨВЛӨМЖӨӨС**

Бодлого боловсруулах үйл явц дахь иргэдийн оролцоонд ажилгүйдэл, ядуурал, газарзүйн алслагдмал байдал зэрэг объектив хүчин зүйлээс гадна төрөө дээдлэх монголчуудын уламжлалт үзэл, иргэдийн улстөрийн соёл, төр, засгийн байгууллагын хаалттай байдал, хууль боловсруулах үйл явцын талаарх иргэдийн мэдлэг боловсрол хангалтгүй, хуучны төвлөрсөн сэтгэлгээний инерци хадгалагдсан зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байна.

Хууль тогтоомжийн хувьд иргэдийн оролцоог зохицуулсан гол хуулийн заалтууд нь давхацсан, ихэнхдээ тунхаг төдий, өөр хоорондоо уялдаа холбоо багатай байна. Иргэдийн оролцоог зохицуулсан хуулийн заалтад хэрэгжүүлэх механизмыг нарийвчлан заагаагүй учраас хэн, хэзээ, яаж, ямар санхүүжилтаар хэрэгжүүлэх нь тодорхойгүй, журам гаргахаар заасан ч тэр нь гараагүй, гарсан ч олон зүйлийг нарийвчлан тусгаагүй байна. Үүнийг дагаад хэрэгжих механизм нь бүрэлдээгүйн зэрэгцээ хэрэгжүүлэгч субъектууд нь ихэвчлэн өөрийн үзэмжээр шийдвэр гаргаж хэвшжээ.

Иймээс хоёр гол хууль болох Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд өргөдөл гомдол гаргах тухай хууль, Хууль, бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийг шинээр өөрчлөн найруулах шаардлагатай байна. Түүнчлэн хуулийг хэрэгжүүлэх институцийн хувьд УИХ-ын Тамгын Газар болон Байнгын Хорооны ажлын албыг олон нийттэй харилцах талаар өргөжүүлэн бэхжүүлэх, ажилтнуудыг чадавхижуулах шаардлагатай байна.

## НУТГИЙН БОЛОН ТӨВЛӨРСӨН УДИРДЛАГА

Монгол Улсад социалист систем нуран унаснаас хойш төвлөрлийг сааруулах үйл явц эрчимтэй явагдаж байна. Энэхүү үйл явц нь дан ганц төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжихээс гадна, төрийн зорилго, чиг үүрэг, улстөр, захиргааны тогтолцоог ч мөн адил хамаарч байгаа юм. Эдийн засгийн төвлөрлийг сааруулах үйл ажиллагаа 1990-ээд оны эхэн үеэс улсын өмчийн орон сууц, мал, үйлдвэр аж ахуйн газрыг хувьчилсанаар эхэлсэн. Өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд хийгдсэн төрийн захиргааны шинэчлэл, төвлөрлийг сааруулах үйл явцаас харахад энэ нь угтаа



социализмын үед байсан төвөөс бүгдийг хянаж төлөвлөдөг тогтолцоог агуулгын хувьд өнөөг хүртэл хадгалж иржээ. Тухайлбал, орон нутгийн засаг захиргааны нэгжүүд нь төсвийн хувьд төвөөс бүрэн хамааралтай, төрийн албаны тогтолцоо нь төвлөрсөн, боловсон хүчнийг томилох, удирдах асуудал дээр орон нутгийн эрх мэдэл ихээхэн хязгаарлагдмал байна.

Цаашид төвлөрлийг сааруулах бодлогод ямар өөрчлөлт оруулбал зохих, төв ба орон нутгийн засаглал хоорондын эрх мэдэл, чиг үүргийн тэнцвэрийг хэрхэн хангах тухай асуудалд Нээлттэй Нийгэм Форум онцгой анхаарал хандуулж бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийнхөө хүрээнд “Үндэсний ба нутгийн удирдлагын чиг үүргийн зохистой хуваарилалт” сэдэвт судалгааны ажлыг хийлгэлээ. Судалгааны ажлыг 2004 онд эхлүүлж, 2005 онд түүний үндсэн үр дүн гарч олон нийтэд танилцууллаа. Монгол Улсын төв Засгийн газар болон орон нутгийн удирдлагын үүрэг, эрх мэдлийн хуваарилалт, төсвийн харилцааны өнөөгийн нөхцөл байдал, бэрхшээлийг тодорхойлж, тэдгээрийг олон улсын нийтлэг хандлагын дагуу өөрчлөх боломжийн талаар зөвлөмж боловсруулсан юм. Энэ бол тухайн чиглэлээр анх удаа хийгдсэн бодлогын судалгаа бөгөөд нутгийн удирдлагын ерөнхий тогтолцооных нь хувьд боловсролын үйлчилгээг түлхүү авч үзсэн байна.

## **ТӨРИЙН БА НУТГИЙН УДИРДЛАГА ХООРОНДЫН ЗОХИСТОЙ ТЭНЦВЭРИЙГ ХАНГАХ АСУУДЛААРХ БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖӨӨС**

Зөвлөмж болгоход төрийн болон нутгийн удирдлага хоорондын эрх мэдэл, үйлчилгээний чиг үүргийн болон орлогын хуваарилалтын хүрээнд тодорхой шинэчлэл хийх шаардлагатай байна. Тухайлбал:

### **Төрийн болон нутгийн удирдлага хоорондын эрх мэдэл, үйлчилгээний чиг үүргийн хуваарилалт:**

- Орлогын хуваарилалтын хариуцлагыг Засгийн газар, үйлчилгээний нийлүүлэлтэд орон нутгийн удирдлага хариуцлага хүлээдэг байх зарчмаар ажиллах нь зүйтэй.
- Засаг даргын албан тушаалыг улстөрийн бус захиргааны статустай болгож орон нутаг дахь захиргааны менежерийн үүргийг хэрэгжүүлдэг болгох хувилбарыг санал болгож байна.
- Ингэснээр Засаг дарга дөрвөн жил тутам сонгуулиар солигддог байдал өөрчлөгдөж, ажлын үр дүнгээс хамааруулан удаан ажиллуулах боломж бүрдэнэ.
- Газарзүйн хувьд ойролцоо олон сумыг нэгтгэж захиргааны болон үйлчилгээний давхар зардлыг хэмнэх шаардлагатай гэх зэрэг.

### **Төрийн болон нутгийн удирдлага хоорондын орлогын хуваарилалт:**

- Орон нутгийн төвшинд орлого олох санаачилгыг бий болгох,
- Орон нутгийг санхүүгийн хувьд бие даалгаж, өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллуулах,
- Бүх төвшний төсвийн байгууллагуудын тоог багасгаж, зарлагын үр ашигтай тогтолцоог бий болгох,
- Орон нутгийн өмчийн ашиглалтыг сайжруулах, ялангуяа газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах явдлыг түргэтгэх,
- Засгийн газраас орон нутагт олгож буй санхүүгийн тусламж, дэмжлэгийг тодорхой шалгуураар үнэлэн олгож байх нь зүйтэй байна.

## НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖ

Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг үнэлэн дүгнэх судалгаа, шинжилгээ туйлын хомс байгаа нь эдгээр үйлчилгээний чанарыг сайжруулах талаар олон нийтийн зүгээс хүчтэй шахалт, шаардлага гарахгүй байх үндсэн нөхцөл болж байна гэж үзэж, нөхцөл байдлыг тодруулж бодлогын хувилбаруудыг боловсруулан нийтийн хүртээл болгох үүднээс 2005 онд Нээлттэй Нийгэм Форум нийгмийн үйлчилгээний асуудлаар хоёр судалгааг хийж гүйцэтгэлээ.



Юуны өмнө Улаанбаатар хотын Сонгино-Хайрхан дүүргийн хүн амзүй, нийгмийн үйлчилгээнд хувь судлаачдаар судалгаа хийлгэсэн болно. Хөдөөнөөс хот руу шилжин суурьшигчид тус дүүрэгт олноор төвлөрснөөс хүн амын бүтэц нь нэлээд өөрчлөгдсөн тул энэ дүүргийг сонгон авч хүн амын амьдралын нөхцөл, төрийн болон нийгмийн үйлчилгээнд хамрагдаж буй байдал, боломжийг судаллаа. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тодорхой нэгжийн ерөнхий нөхцөл байдал, тулгарч буй салбарын шинжтэй асуудлуудыг тодорхойлсонд судалгааны гол ач холбогдол оршино. Судалгаагаар орон сууц, гэр хороолол хосолсон бүтэцтэй хороонуудын төрийн болон нийгмийн үйлчилгээний байгууллагууд, Засаг даргын Тамгын газар, хөдөлмөр, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн ажилтнууд, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн улирдлагаас өргөн хүрээтэй мэдээлэл цуглуулан дүгнэлт хийж тодорхой зөвлөмж боловсрууллаа.

Судалгаанаас үзэхэд Сонгинохайрхан дүүргийн иргэдийн тав орчим хувь нь албан ёсны бүртгэлгүй байгаагаас сургууль, цэцэрлэг, эмнэлгийн үйлчилгээг хүртэж чадахгүй байна. Хорооны ажилтнуудын ажлын уялдаа холбоо сулаас болж бүртгэл, мэдээлэл олдохгүй байх нь элбэг тохиолджээ. Хүн амын өсөлттэй холбоотойгоор сургууль, цэцэрлэг, эмнэлгийн байгууллагууд ачааллаа даахаа больж, сургууль л гэхэд анх төсөвлөгдсөн хүчин чадлаасаа хоёр дахин илүү ачаалалтай ажиллаж байна. Ядуурал, ажилгүйдлийн улмаас хүүхдээ сургууль, цэцэрлэгт хамруулахгүй байх тохиолдол ихэсчээ. Эмнэлгийн хүчин чадлыг төлөвлөхдөө төлбөртэй үйлчилгээ явуулдаг хувийн эмнэлгүүдийн орны тоог оролцуулан тооцдог тул улсын эмнэлгийн

ачааллыг бодитойгоор тооцсон төлөвлөлт хийгддэггүй ажээ. Ажилгүйчүүдийн ихэнх нь дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлээгүй, бүртгүүлэхийн ач холбогдлыг ч мэдэхгүй, итгэдэггүй болох нь харагджээ. Иргэдийн санааг зовоож байгаа өөр нэг асуудал бол аюулгүй амьдрах орчин хангагдаагүй, шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагын хамгаалалтыг авах боломж муу байгаа явдал юм. Мөн чөлөөт цагаа өнгөрөөх соёл, амралтын ямар нэг орчин, байгууллага байхгүйд иргэд сэтгэл дундуур байгаа нь судалгаанаас харагдлаа.



Нээлттэй Нийгэм Форумын Бодлогын Судалгааны Тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд "ME Consulting"-ийн судлаач Л.Золбаатар "Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суурь боловсрол эзэмших боломж" сэдэвт судалгааг 2005 онд хийлээ. Уг судалгаагаар хот хөдөөгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суурь боловсрол үнэ төлбөргүй заавал эзэмших эрх хэрхэн биелж буйг судлахад энэ нь нэн хязгаарлагдмал төдийгүй нийгмийн халамжийн хуулиар олгогдох ёстой тэтгэмж, нэмэлт үйлчилгээ хүртэх боломж нь тухайн хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн төрлөөр бус, харин өрхийн амьжиргааны төвшингөөр тодорхойлогдож байгаа нь учир дутагдалтай байна. Тэрчлэн хөдөө орон нутагт сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан эмнэлэг, оношилгоо, тусгай боловсролын үйлчилгээ бараг байхгүй, ерөнхий боловсролын багш нарт тусгай боловсролын чиглэлээр ажиллах мэдлэг, арга барил олгодоггүй байна. Хэдийгээр багш нар, сургуулийн удирдлагын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ялгаварлан гадуурхах тохиолдол бага байгаа ч өнөө үйлчилж буй дүрэм, журмын дагуу багшийн хөдөлмөрийн үнэлгээний нэлээд хэсгийг сурагчдын сурлагын үзүүлэлтээр хэмжин тогтоодог нь хөгжлийн бэрхшээлтэй, ялангуяа сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ангидаа авч сургахад тодорхой саад болдог гэж үзэх үндэслэлтэй байна. Уг судалгааны дүгнэлт, бодлогын зөвлөмжийг 2006 оны эхээр олон нийт болон бодлого боловсруулагчдад танилцуулан хэлэлцүүлэхээр бэлтгэж байгаа болно.

## ЭРХЗҮЙН ТУСЛАЛЦАА

Монголын хүн амын дунд ядуу иргэдийн эзлэх хувь өндөр, улмаар тэдгээр хүмүүс гэмт хэрэгт холбогдсон үед өмгөөлөгч авах боломж хомс байгаа тул төлбөрийн чадваргүй иргэдэд эрхзүйн туслалцаа үзүүлэх нь хүний эрхийг хангахад чухал үүрэгтэй юм. Хуулийн хэрэгжилт, туслалцаа үзүүлэх ажлын уялдаа сул, санхүүжилт хомс зэрэг олон шалтгаанаас үүдэн энэ нь нэн тулгамдсан асуудал болж байна. Иймээс төлбөрийн чадваргүй иргэдэд эрхзүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийг боловсруулахад Нээлттэй Нийгэм Форум дэмжлэг үзүүлж, ХЗДХЯ болон Будапештэд төвтэй “Нээлттэй Нийгмийн Эрхзүйн Санаачилга” байгууллагатай хамтран “Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх эрхзүйн туслалцаа” төслийг хэрэгжүүлж байна.

### Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх эрхзүйн туслалцаа

Энэ төслийн хүрээнд нийгмийн ядуу хэсэгт үзүүлэх эрхзүйн туслалцааны тогтолцоог боловсронгуй болгох, үндэсний тогтолцоог шинэчлэх санал боловсруулах Ажлын хэсгийг ХЗДХЯ-наас байгуулсан ба “Төлбөрийн чадваргүй иргэдэд эрхзүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн төслийг боловсруулан Засгийн Газраар батлуулах гэж байна. Хөтөлбөрийг боловсруулж буйтай холбогдуулан Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газрын болон ХЗДХЯ-ны төлөөлөгчид ННФ-ын дэмжлэгтэйгээр Унгар улсын Будапешт хотноо зохиогдсон “Эрхзүйн туслалцаа” олон улсын хуралд оролцон бусад улсын ололт амжилт, сургамжаас суралцлаа.

Сонгинохайрхан дүүрэг болон Хэнтий аймаг дахь төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн туслалцаа үзүүлэх туршилтын төвийг үргэлжлүүлэн ажиллуулж, тухайн дүүрэг болон аймгийн шүүхийн нийт шийдвэрлэж буй эрүүгийн хэргийн 97 гаруй хувийг өмгөөлсөн байна. Төвүүд нь тухайн дүүрэг, аймгийн цагдаа, шүүхтэй хамтын ажиллагааны журмын үндсэн хамтран ажилладаг. Энэхүү журмын дагуу аливаа сэжигтэн, яллагдагч нь төлбөрийн чадваргүй бол мөрдөн байцаах ажиллагаа эхлэхээс өмнө төвд мэдэгдэн өмгөөлөгч авдаг. Ингэснээр мөрдөн байцаах, шүүх үйл ажиллагаа өмгөөлөгчгүйгээс болж саатдаг, хугацаа алддаг байдал буурчээ.

Эрхзүйн туслалцаа төслийн хүрээнд иргэдэд зориулсан цуврал хөтөчийн нэг болох “Хуульзүйн туслалцаа хэрхэн авах вэ?” гарын авлагыг МУИС-ийн Хуульзүйн Дээд Сургуулийн “Хүмүүнлэг” хуульзүйн клиниктэй хамтран бэлтгэн гаргалаа. Гарын авлага нь өмгөөллийн үйлчилгээний асуудлаар иргэдэд чухал шаардлагатай мэдээллийг хялбаршуулсан хэлбэрээр хүргэж, төлбөрийн чадваргүй иргэдэд үйлчилгээ үзүүлэх боломжтой өмгөөлөгчдийн жагсаалт, эрхзүйн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын лавлагаа танилцуулгыг багтаасанаараа ач холбогдолтой юм.

### **Эрхзүйн мэдээлэл, үйлчилгээг орон нутагт нэвтрүүлэх нь**

ННФ орон нутаг дахь эрхзүйн боловсрол, мэдээлэл, зөвлөгөө лавлагааны тогтолцоог боловсронгуй болгох үүднээс “Эрхзүйн мэдээлэл, үйлчилгээг орон нутагт нэвтрүүлэх нь” төслийг ХЗДХЯ-тай хамтран 2005 оноос эхлэн хэрэгжүүлж эхэллээ. Төслийн хүлээж буй үр дүн нь анхан шатны эрхзүйн зөвлөгөө, боловсролыг төрийн үйлчилгээ болгон хэвшүүлж нутгийн удирдлагад институтчилэн бэхжүүлэх, улмаар хөдөө орон нутгийн иргэдийн эрхзүйн туслалцаа, иргэдийн эрхзүйн боловсролын төвшинг нэмэгдүүлэх явдал юм.

Эрхзүйн албан бус боловсрол, анхан шатны зөвлөгөөний аргачлал, стандартыг боловсруулан хэрэгжүүлэх, энэхүү үйлчилгээг явуулах төрийн албан хаагчдын чадавхийг сайжруулах зорилгоор аймаг дүүргийн Засаг Дарга, түүний Тамгын Газрын хуулийн ажилтнуудад зориулсан гарын авлага болон иргэдэд зориулсан анхан шатны хялбаршуулсан гарын авлагуудыг өдөр тутмын амьдралд тулгардаг дараахь сэдвээр бэлтгэн боловсрууллаа. Үүнд:

1. Монголын хууль тогтоомж ба эрхзүйн тогтолцоо
2. Эрхзүйн мэдээлэл, зөвлөгөө өгөх, сургалт явуулах чадвар
3. Альтернатив аргаар маргааныг шийдвэрлэх
4. Гэр бүлийн эрхзүй /гэр бүлийн хүчирхийлэл/
5. Эрүүгийн эрхзүй
6. Хөдөлмөрийн эрхзүй
7. Нийгмийн халамжийн эрхзүй
8. Иргэний эрхзүй
9. Захиргааны эрхзүй
10. Татварын эрхзүй
11. Газрын эрхзүй
12. Бизнесийн эрхзүй зэрэг ном багтаж байна.

Гадаадын зөвлөхүүдтэй хамтран эдгээр гарын авлагыг боловсруулахдаа шинэлэг аргазүй, аргачлалыг тусгасны зэрэгцээ гарын авлагын зохиогч нарт зориулан хоёр удаа сургалт зохион байгуулав.

Төсөл цаашид үргэлжлэх бөгөөд үр дүнд нь аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга болон түүний Тамгын газрын хуульзүйн хэлтсийн ажилтнуудын иргэдэд эрхзүйн анхан шатны зөвлөгөө, мэдээлэл өгөх аргачлал стандартыг боловсруулан нэвтрүүлэх юм.

### **Нөхцөл байдлын судалгаа**

ННФ 2005 онд НҮБХХ болон ХЗДХЯ-тай хамтран “Эрхзүйн мэдээлэл, сурталчилгаа, туслалцааны хүртээмжтэй байдал” нөхцөл байдлын судалгааг хийлээ. Судалгааг Хэнтий, Өмнөговь, Дархан-Уул, Хөвсгөл, Архангай, Ховд аймаг болон нийслэлийн Сонгинохайрхан, Сүхбаатар, Багануур, Налайх, Баянзүрх, Баянгол, Хан-Уул дүүрэгт явуулж, иргэдийн эрхзүйн мэдээлэл, сурталчилгаа түгээх, туслалцаа үзүүлэх

байгууллагуудын талаарх мэдлэг, үнэлэмж; итгэх итгэл; эрхзүйн туслалцааны бодит хэрэгцээ, шаардлага, төрийн болон төрийн бус байгууллагуудын зүгээс иргэдийн эрхийг хамгаалах талаар үзүүлж байгаа үйлчилгээний хүртээмж; иргэд хууль хяналтын болон бусад байгууллагад хандан асуудлаа шийдвэрлүүлэх боломжийн талаар тодорхой дүгнэлт гаргаж эрхзүйн туслалцааг илүү хүртээмжтэй, үр нөлөөтэй үзүүлэх цаашдын арга хэлбэрийг тодорхойлох зорилго тавьсан юм.

Судалгаанаас үзвэл иргэд эрхзүйн мэдээлэл, сурталчилгааны ач холбогдлын талаар харьцангуй сайн мэддэг боловч эдгээрийг түгээх байгууллагуудын үйл ажиллагааны талаарх мэдлэг төдийлөн хангалттай биш байна. Судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь хэдийгээр өмгөөллийн үйл ажиллагааны талаар хангалттай сайн мэддэггүй ч хэрэг маргаанаа шийдвэрлүүлэхэд өмгөөлөгчийн оролцоог харьцангуй өндрөөр үнэлжээ.

### **Стратегийн өмгөөлөл**

Нээлттэй Нийгэм Форум хүний эрхийг дэмжих, хамгаалах, түгээх, ялангуяа эрхзүйн туслалцаа үзүүлэх албан бус буюу ТББ-ын чадавхийг бэхжүүлэх төсөл дээр АНУ-д төвтэй “Глобал Райтс” олон улсын байгууллагатай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж, тус байгууллагын Өмнөд Африк улсад зохион байгуулсан ТББ-уудын хүний эрхийг хамгаалах стратегийн сургалтад Монголын ТББ-ын төлөөлөгчидтэй хамтран оролцов. “Глобал Райтс” олон улсын байгууллагатай хамтын ажиллагаагааны хүрээнд Женев дэх НҮБ-ын Хүний Эрхийн Комиссын 62 дугаар хуралд ННФ ажиглагчаар оролцож, хүний эрхийг хамгаалахад олон улсын буюу НҮБ-ын механизмыг ашиглах талаар мэдээлэл, туршлагаас суралцав. Түүнчлэн НҮБ-ын хүний эрхийн асуудлаарх тусгай элч болон институттэй холбоо тогтоож, НҮБ-ын Хүний Эрхийн Хорооны эрүү шүүлт тулгах асуудлаарх тусгай илтгэгч Манфред Новак Монголд айлчлах үеэр нь Нээлттэй Нийгэм Форум хүний эрхийн ТББ-уудын дунд уулзалт зохион байгууллаа. Манфред Новак НҮБ-ын Хүний Эрхийн Хорооны тусгай процедурын талаар дэлгэрэнгүй мэдээлэл хийж, Монголын ТББ-ууд энэхүү механизмыг хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаандаа хэрхэн ашиглаж болох талаар зөвлөмж өгсөн болно.

Тэрчлэн ННФ 2005 онд олон нийтийг төлөөлөн стратегийн өмгөөллийг хэрхэн хийх талаар Хүний Эрх, Хөгжил Төвтэй хамтран гарын авлага боловсрууллаа. Гарын авлагад стратегийн өмгөөллийн талаарх олон улсын ойлголт, стандарт, туршлага, Монголд стратегийн өмгөөлөл явуулах эрхзүйн орчин, тодорхой туршлага жишээнүүд болон стратегийн өмгөөлөл явуулах аргачлал, аргазүйн зөвлөгөөг багтаасан болно.



## ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ЭРХЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Эдүгээ Монголд төрийн бус салбар улам боловсронгуй болж хөгжлийн шинэ шатанд гарч байна. Манай улсын хувьд энэ төрлийн харилцааг зохицуулж буй гол хууль нь 1997 онд батлагдсан “Төрийн бус байгууллагын тухай хууль” юм. 2005 оны байдлаар энэ хуулийн дагуу байгуулагдсан 5000 гаруй төрийн бус байгууллага Хуульзүй, дотоод хэргийн яаманд бүртгэгджээ. Энэ хууль нь иргэний нийгмийн бүрдэл хэсэг болох сайн дурын үүсгэл санаачлагын байгууллагууд олноор үүсч төлөвшихөд зохих үүрэг гүйцэтгэсэн боловч эрхзүйн шинэтгэл эрчимтэй хийгдэж буй өнөөгийн нөхцөлд шинээр үүсч буй харилцааг зохицуулахад учир дутагдалтай байдал ажиглагдаж байна. Иймээс уг хуулийг бүхэлд нь эргэн судалж боловсронгуй болгох, чингэхдээ олон улсын чиг хандлага, жишиг загварт нийцүүлэх, сүүлд гарсан гол хуулиудтай /“Иргэний хууль”, “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль”/ уялдуулах шаардлага зүй ёсоор гарч ирлээ.

Нээлттэй Нийгэм Форум энэ хуулийн төслийг боловсруулах ХЗДХЯ-ны санаачилгыг дэмжин олон улсын жишигт нийцүүлэх, техникийн туслалцаа үзүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна. Ялангуяа энэ үйл явцын ил тод байдлыг хангах, хуулийн төслийг боловсруулахад ТББ-уудын оролцоог хангах, санаа бодлыг нь тусгах, төслийн чанарыг сайжруулах зорилгоор 2003 оноос эхлэн цуврал уулзалт, хэлэлцүүлгүүд зохион байгуулав. Тэрчлэн ТББ-ын төлөөлөл бүхий өргөтгөсөн ажлын хэсэгтэй хамтран олон улсын байгууллагын санал зөвлөмжийг авлаа. 2005 онд хуулийн төслийг олон нийтэд танилцуулан хэлэлцүүлэх уулзалт ярилцлагыг зохион байгуулж, ТББ-уудын санал, шүүмжийг хүлээн авах үйл ажиллагааг үргэлжүүлэв. Хуулийн төслийг [www.forum.mn](http://www.forum.mn) болон [www.open-government.mn](http://www.open-government.mn) веб сайтуудад байрлуулан олон нийтийн онлайн хэлэлцүүлэг өрнүүллээ.

Хуулийн төслийг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор Ашгийн Бус Байгууллагын Хуулийн Олон Улсын Төв, Иргэний Нийгмийн Хуулийн Олон Улсын Төв, АНУ дахь Нээлттэй Нийгэм Хүрээлэн зэрэг байгууллагаас дахин санал зөвлөмж авсан бөгөөд Иргэний Нийгмийн Хуулийн Олон Улсын Төвийн Ерөнхийлөгч, Төв Европын Их сургуулийн профессор, доктор Леон Айриш Монголд ирж хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгтэй хамтран ажиллалаа. Эдүгээ Ашгийн бус хуулийн этгээдийн тухай хуулийн төсөл УИХ-ын 2006 оны хэлэлцэх асуудлын жагсаалтад багтсан байна. ТББ-уудын дунд зохиосон олон удаагийн хэлэлцүүлгийн үр дүнд энэ хуулийн үйлчлэх хүрээ, ашгийн бус хуулийн этгээдийн тухай ойлголт, үндсэн шинж, хэлбэр, ангилал зэргийг хуулийн төсөлд шинээр нэмж тусгасны зэрэгцээ өөрчлөн байгуулах онцлог, татан буугдсаны дараахь эд хөрөнгийн зохицуулалт зэргийг илүү тодорхой тусгав. Дийлэнх улс орон ашгийн бус хуулийн этгээдэд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг зохих хэмжээгээр зөвшөөрдөг бөгөөд үүнийг тэдний бодитойгоор оршин тогтнох, үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцлийг хангахад чиглэсэн нэлээд чухал зохицуулалт гэж үздэг байна. Иймээс ашгийн бус хуулийн этгээд нь хууль буюу дүрэмд заасан зорилгодоо нийцсэн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж болохыг төсөлд тодорхой тусгасан ба үүнтэй уялдуулан тэдгээрийн орлого ямар эх үүсвэрээс бүрдэх, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангаа хэдийд гаргах, хэнд тайлагнах зэргийг илүү дэлгэрэнгүй тусгаж өгөв.

Төрийн бус байгууллагын тухай хуулийн дагуу байгуулагдаж, бүртгүүлсэн хуулийн этгээдийг “нийгэмд үйлчилдэг”, “гишүүддээ үйлчилдэг” гэж хоёр ангилдаг боловч ийнхүү ангилсаны ач холбогдол, үр дагавар харагдахгүй, зөвхөн ангилал төдий байна. Бусад орны энэ төрлийн хууль тогтоомжоос үзэхэд ангиллаас нь хамааран татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлдэг жишиг байгааг харгалзан зарим зохицуулалтыг төсөлд тусгалаа. Нийгэмд үйлчилдэг ашгийн бус хуулийн этгээдийг ямар шалгуураар тогтоох, энэ статусыг ямар байгууллага олгох, үйл ажиллагаанд нь ямар зорилгоор мониторинг хийх, төрөөс ямар дэмжлэг тусалцаа үзүүлэх зэргийг тодорхой тусгасан байна.

Энэхүү хуулийн төслийг боловсруулахад хэрэгцээтэй тоо, баримтаар хангах үүднээс ННФ 2005 онд “Монгол Улс дахь Төрийн Бус Байгууллагуудын мэдээлэл” судалгааг “Ардчиллын Боловсрол” ТББ-тай гэрээ байгуулан хийж гүйцэтгэлээ. Энэ бол ХЗДХЯ болон Татварын албадын бүртгэл тайлан дээр үндэслэсэн анхны тоон мэдээлэл бүхий судалгаа юм. Судалгаанд ХЗДХЯ-нд бүртгэлтэй 3720, Татварын албанд бүртгэлтэй 1042 ТББ хамрагдсан байна. Судалгааны тайлан [www.forum.mn](http://www.forum.mn) вебсайт дээр англи, монгол хэл дээр тавигдсан болно.

Төрийн бус байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх зорилгоор ННФ 2005 онд Дэлхийн Банктай хамтран жижиг тэтгэлэг олгох хөтөлбөрийг хэрэгжүүлжээ. Хөтөлбөрийн зорилго нь хөгжлийн үйл явцад иргэдийн оролцоог хангах, мэдээллийн солилцоо, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих, бодлогын хэрэгжилтийн хяналт, мониторинг, үнэлгээнд иргэдийн болон иргэний нийгмийн оролцоог хангах, ялангуяа нийгмийн эмзэг бүлгийнхнийг хамруулах, орон нутгийн төвшний санал, санаачилга, үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн юм. Энэ хүрээнд нийтдээ зургаан ТББ тэтгэлэг хүртэж, төрийн ил тод байдал, хариуцлага тооцох байдлыг дээшлүүлэх, нийгмийн эмзэг хэсгийнхний дуу хоолойг хөгжлийн хөтөлбөр, шийдвэрт тусгах чиглэлээр төсөл хэрэгжүүлж байна.

### **“МОНГОЛ УЛС ДАХЬ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН МЭДЭЭЛЭЛ” СУДАЛГААНЫ ДҮНГЭЭС**

ХЗДХЯ-нд бүртгүүлсэн ТББ-уудын тоог авч үзвэл, жилд дунджаар 560, сард 50, долоо хоногт 12 байгууллага бүртгүүлсэн байна. Тэдгээрийн 80 гаруй хувь нь нийгэмд үйлчилдэг, 20 орчим хувь нь гишүүддээ үйлчилдэг гэж бүртгүүлжээ. Нийт ТББ-уудын 77 хувь нь Улаанбаатар хотод байрладаг, 23 хувь нь хөдөө орон нутагт ажиллаж байна. Түүнчлэн 13,4 хувь нь хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, бизнес, 11,8 хувь нь спорт, аялал жуулчлал, чөлөөт цаг, 11 хувь нь нийгмийн салбарыг өөрийн үйл ажиллагааны үндсэн чиглэлээр тодорхойлжээ. Хүний нөөцийн хувьд нийт ТББ-ын ойролцоогоор 30 хувь нь хоёр үндсэн ажилтантай, 23,5 хувь нь таван ажилтантай, 17,6 хувь нь гурван ажилтантай байна.

Татварын албанд тушаасан ТББ-уудын тайлан мэдээллээс үндэслэж гаргасан тооцоогоор нийт ТББ-уудын 20 хүрэхгүй хувь нь идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг дүр зураг харагдаж байна. ТББ-уудын санхүүжилтийн байдлыг авч үзвэл 59.5 хувь нь гадаадын донор байгууллагууд, 27.9 хувь нь өөрсдийн үйл ажиллагааны орлого, 12.6 хувь нь хандив, дэмжлэг зэрэг эх үүсвэрээс бүрдсэн ажээ.

## ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

### ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ИНДЕКС

Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас татгалзаж, ардчилал, зах зээлийн эдийн засаг, эдийн засгийн эрх чөлөөг эрхэмлэсэн нийгэм рүү эргэлт буцалтгүй шилжиж эхлээд 15 жил боллоо. Энэ хугацаанд Монголын эдийн засгийг нээлттэй болгох, олон улсын худалдааг дэмжих, хувийн секторыг хөгжүүлэх, төрийн оролцоог багасгах, зах зээлд тулгуурласан зохицуулалтыг бий болгох олон чухал алхам хийгдсэн. АНУ-ын Херитэдж сангаас гаргадаг дэлхийн 155 орны эдийн засгийн эрх чөлөөний жагсаалтад Монгол Улс 2005 онд 50 дугаар байрт бичигджээ. Хэдийгээр энэ нь хөгжиж буй улсын хувьд



чамлахааргүй үзүүлэлт боловч өнөөдөр авилгал, нийтийг хамарсан ядуурал, эдийн засгийн эрх чөлөөг ил, далдаар боосон хүнд суртал байсаар байна. Энэ нь эдийн засгийн хөгжлийг удаашруулж, нөөцийн үр ашиггүй хуваарилалт, алдагдлыг бий болгож буй гол шалтгаан юм.

Нээлттэй Нийгэм Форум дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний индексийг тооцдог судалгааны томоохон институт болох Фрейзер Институтийн аргачлалд тулгуурлан Монголын эдийн засгийн эрх чөлөөг судалж бодитойгоор хэмжих, улс орны хөгжилд учирч байгаа бэрхшээл, асуудлыг ил тод, нийтээр хэлэлцэх зорилготойгоор энэ хөтөлбөрийг 2005 оноос хэрэгжүүлж эхэлсэн юм. Хөтөлбөрийн хүрээнд МУИС-ийн Эдийн Засгийн сургууль, Санхүү, Эдийн Засгийн Дээд Сургууль, Үндэсний Хөгжлийн Хүрээлэн, Монголын Банкуудын Холбоотой хамтран судлаачид, профессоруудаас бүрдсэн дөрвөн баг байгуулан ажиллаж, эдийн засгийн эрх чөлөөний индексийг чиглэл бүрээр тодорхойлон гаргалаа.

Тухайлбал, эдийн засаг дахь Засгийн газрын хувь хэмжээ, эрүүл мөнгө хүртэх боломж, олон улсын худалдааны эрх чөлөө, зээлийн зохицуулалтын талаар өргөн хүрээтэй судалгаа явуулж, судалгааны явц, үр дүнг мэргэжлийн хүмүүсийн дунд тогтмол хэлэлцүүлэв. Судалгааны эцсийн үр дүн буюу индекс, санал зөвлөмжийг бодлого боловсруулагчид, эдийн засагчид, санхүүгийн томоохон групп, компаниудын удирдлага, Засгийн газрын холбогдох байгууллагын албан тушаалтнууд, судлаачдыг оролцуулсан цуврал уулзалтаар хэлэлцүүлээ. Энэ нь эдийн засгийн эрх чөлөөний асуудалд олон


нийтийн анхаарлыг хандуулахад ихээхэн тус дэмтэй алхам болсон юм. Цаашдаа эдгээр асуудлаар улс орны хэмжээнд өргөн хүрээтэй мэтгэлцээн өрнүүлэх нь эдийн засгийн бодлогын хөгжил дэвшилд нөлөөлнө гэж Форум үзэж байна. Судалгаагаар сүүдэр эдийн засгийн ДНБ-д үзүүлэх нөлөө, хувийн хөрөнгө оруулалтын тооцоо, эдийн засгийн зарим үзүүлэлт Монголын нөхцөл байдалтай нийцэхгүй байгаа зэрэгт үндэслэн аргагүйн зөвлөмжүүд боловсруулаа.

Эдийн засгийн эрх чөлөөний асуудалд холбогдох бодлогыг сайжруулахад индексийг ашиглах явдал нь энэ хөтөлбөрийн бас нэг чухал хэсэг юм. ННФ нь эдийн засгийн эрх чөлөөний индексүүдэд тулгуурлан эдийн засгийн эрх чөлөөний тайланг жил бүр нийтлэн гаргах бөгөөд зөвхөн тухайн индексүүдийг хөрвүүлэн тайлбарлаад зогсохгүй эдийн засгийн гол тулгамдсан асуудлын шинжилгээг хийж, бодлого боловсруулагчдад зориулсан санал зөвлөмжөөр хангах юм.

Нээлттэй Нийгэм Форум 2005 онд Фрейзер институтын албан ёсны түнш байгууллага боллоо. Тус институтын гишүүн байгууллагуудын дунд зохиогддог "Олон улсын эдийн засгийн эрх чөлөө" сэдэвт хуралд ННФ анх удаа оролцон "Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний индекс, түүнийг боловсруулахад тулгарах бэрхшээл" сэдэвт илтгэлийг тавьж хэлэлцүүлсэн нь 2006 оноос эхлэн Монгол Улсын мэдээллийг энэхүү байгууллагын олон улсын индекст хамруулахад ихээхэн тус дэм болсон юм.

Түүнчлэн 2005 онд Монгол Улс анх удаа Дэлхийн Эдийн Засгийн Форум /ДЭЗФ/-аас эрхлэн гаргадаг Дэлхий нийтийн өрсөлдөх чадварын индекст хамрагдсан болно. Уг тайланг гаргахад АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагын санхүүжилттэй Эдийн Засгийн Бодлогын Шинэчлэл, Өрсөлдөх Чадварын төсөл /ЭЗБШӨЧ/ нь ДЭЗФ-ын гол түнш байгууллага болон ажилласан юм. Монгол Улсын дэлхий нийтэд өрсөлдөх чадварын индексийн үр дүнг танилцуулах уулзалтыг Форум ДЭЗФ, ЭЗБШӨЧ төсөлтэй хамтран бизнесийн болон хандивлагч байгууллагуудын дунд зохион байгуулав. 2006 оны Монгол Улсын өрсөлдөх чадварын индексийг боловсруулан гаргахад Форум нь ДЭЗФ-тай хамтран ажиллахаар боллоо.

Монгол Улсын зээлийн зохицуулалтын индекс



## СҮҮДЭР ЭДИЙН ЗАСГИЙН ҮҮРЭГ, РОЛЬ

Шилжилтийн үед сүүдрийн эдийн засгийн цар хүрээ тэлсээр байгаа ч түүний бодит хэмжээ, онцлогийн талаар мэдээлэл тун хомс байгаатай холбогдуулан Нээлттэй Нийгэм Форум Монгол дахь албан бус сектор, сүүдэр эдийн засгийн талаарх нарийвчилсан судалгааг 2004 онд эхлүүлсэн юм. “Албан бус секторын өрхийн судалгаа”-г 2005 онд бүрэн гүйцэтгэж тайланг олон нийтэд танилцуулсан бөгөөд уг салбарын талаар баримтлах бодлогыг боловсруулахад шаардлагатай мэдээллийн баазыг бүрдүүлж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар олон чухал санал зөвлөмжийг бодлого боловсруулагчдад хүргэлээ.



Энэ судалгааг Нээлттэй Нийгэм Форум АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн Эдийн Засгийн Бодлогын Шинэтгэл, Өрсөлдөх Чадвар төсөлтэй хамтран санхүүжүүлж, АНУ-ын Мэриландын Их Сургуулийн дэргэдэх Институцийн Шинэтгэл ба Албан Бус Секторын төвийн зөвлөхүүдийн боловсруулсан аргазүйд үндэслэн Үндэсний Статистикийн Газартай хамтран гүйцэтгэсэн болно. Судалгааг гүйцэтгэгч талуудад зориулан сургалтыг Мэриландын Их Сургууль болон Үндэсний Статистикийн Газарт зохион байгуулснаар ийм төрлийн судалгааг дотоодын мэргэжилтнүүд гүйцэтгэх чадвартай болсон төдийгүй судалгааны дүн шинжилгээг нэгтгэх, өгөгдлийг ашиглах чадавхийг бүрдүүлсэн юм.

Судалгааны дүнд үндэслэн албан бус секторын үйлдвэрлэлийг үндэсний тооцооны систем, дотоодын нийт бүтээгдэхүүнд нэгтгэн тооцоход шаардагдах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Үндэсний Статистикийн Газарт танилцууллаа. Тэрчлэн албан бус секторын талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулахад шаардагдах суурь мэдээлэл, тухайлбал ажил эрхлэлт, уг салбарт ажиллагсдын нийгмийн хамгаалал, татварын бодлого, санхүүгийн үйлчилгээ хүртэх боломж, эрсдэл хүлээх сонирхол зэрэг мэдээллийг ашиглан уг секторыг эдийн засгийн өндөр үр ашигтай хэсэг болгох бодлогыг боловсруулах боломжийг анх удаа бүрдүүлснээрээ энэхүү судалгаа ач холбогдолтой боллоо.

## АЛБАН БУС СЕКТОРЫН ӨРХИЙН СУДАЛГААНЫ ЗАРИМ ДҮНГЭЭС

Албан бус сектор дахь мал аж ахуй болон мал аж ахуйн бус үйлдвэрлэлийн тооцоо /тэрбум төгрөгөөр/								
Албан бус сектор дахь мал аж ахуйн бус үйлдвэрлэл			Мал аж ахуй			Бүгд		
Доод хэмжээ	Дундаж хэмжээ	Дээд хэмжээ	Доод хэмжээ	Дундаж хэмжээ	Дээд хэмжээ	Доод хэмжээ	Дундаж хэмжээ	Дээд хэмжээ
Дугтуйн аргаар								
391	<b>463</b>	535	189	<b>303</b>	417	632	<b>766</b>	899
Үржүүлэгчийн аргаар								
248	<b>369</b>	490	162	<b>215</b>	267	452	<b>584</b>	715
Эдгээр дүнтэй харьцуулах зорилгоор дараачийн хүснэгтэд ҮСГ-аас ДНБ-ийг тооцсон урьдчилсан дүнг үзүүлэв.								
2004 оны ДНБ-ийг тооцсон урьдчилсан дүн (тэрбум төгрөгөөр)								
Албан сектор, МАА-н бус үйлдвэрлэл	Албан бус сектор, МАА-н бус үйлдвэрлэл	Мал аж ахуй	Бүгд					
1,219	259	330	1,809					
Монгол дахь албан бус секторын мал аж ахуй болон мал аж ахуйн бус үйлдвэрлэлийг өнөөгийн албан ёсны тооцооны дүнтэй харьцуулсан тооцоо, судалгааны арга тус бүрээр /хувиар/								
МААБ /АБС <sup>АБСӨС</sup> / ДНБ – АБС <sup>Бик</sup>			МАА <sup>АБСӨС</sup> / МАА <sup>ҮСГ</sup>			АБС <sup>АБСӨС</sup> – АБС <sup>Бик</sup> – МАА <sup>ҮСГ</sup> / ДНБ		
Доод хэмжээ	Дундаж хэмжээ	Дээд хэмжээ	Доод хэмжээ	Дундаж хэмжээ	Дээд хэмжээ	Доод хэмжээ	Дундаж хэмжээ	Дээд хэмжээ
Дугтуйн аргаар								
25.2	<b>29.9</b>	34.5	57.1	<b>91.7</b>	126.4	-0.01	<b>9.7</b>	20.1
Үржүүлэгчийн аргаар								
16.0	<b>23.8</b>	31.6	49.1	<b>65.0</b>	80.9	-9.9	0.0	9.3
Судалгаанд оролцогсдын ихэнх нь Татварын хуулийг сахин мөрдөхгүй байх нь нийтлэг байгаа төдийгүй авилгалтай холбоотой зан үйлдэл түгээмэл тархсан гэж үзэж байна. Үүний цаад шалтгаан нь зохицуулалтын үр нөлөө гэж үзэж болох бөгөөд сүүдрийн эдийн засаг хүрээгээ тэлэх бас нэг нөхцөл болж байна. Албан бус сектор дахь санхүүжилттэй холбоотой асуудлаар харилцан адилгүй байр суурь, төсөөлөлтэй байна. Зээлийн барьцаа их өндөр байгаа нь бизнесийн үйл ажиллагааг ихээхэн боогдуулж байдаг хэдий ч тавигдах шаардлагууд нь албан бус секторын хувьд харьцангуй хөнгөрч байна. Гэхдээ л банкны зээлийн хүү өссөн хэвээр байна.								

Жич тайлбар: МААБ - мал аж ахуйн бус салбарын үйлдвэрлэлийн тооцоо, Бик-Бикалис нарын тооцоо, АБС - албан бус салбарын хэмжээний тооцоо, АБСөС - энэхүү судалгааны тооцоо, ҮСГ-үндэсний Статистикийн Газрын тооцоо.

## УУЛ УУРХАЙН САЛБАРЫН БОДЛОГЫН АСУУДАЛ

Сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарын Монголын эдийн засагт эзлэх байр суурь эрс нэмэгдэж, алт, зэс зэрэг гол экспортын бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнэ ханш өсч байна. Эдүгээ Оюу Толгой, Бороо зэрэг асар том хэмжээний зэс, алтны нөөцийг илрүүлэн, гадаадын хөрөнгө оруулагчдын хамтаар ашиглаж байгаа буюу ашиглахаар төлөвлөж байна. Ашигт малтмалын хайгуул, олборлолттой холбоотой янз бүрийн байр суурь, мэтгэлцээн, тэмцэл нийгэмд өрнөж эхэлжээ. Тухайлбал, уул уурхайн салбараас улсын төсөвт орох орлого ямар хэмжээ, хэлбэртэй байх, гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжихэд ямар бодлого баримтлах, байгаль орчинд үзүүлэх сөрөг үр дагаврыг хэрхэн зохицуулах, Монголын ард түмэнд өгөх үр өгөөж зэрэг асуудлаар эрс тэрс байр суурь давамгайлж байна. Уул уурхай бол Монгол Улсын өсөлтийн нэгэн эх сурвалж гэж хэн хүнгүй үзэх болжээ.

Ийм нөхцөлд уул уурхайн салбарын Монголын нийт эдийн засагт үзүүлэх үр нөлөөний талаар төрөөс баримталж буй бодлогод Нээлттэй Нийгэм Форум анхааралтай хандаж, зарим арга хэмжээг 2005 оноос хэрэгжүүлжээ. Юуны өмнө Форумын зүгээс баримт мэдээлэл, судалгаанд үндэслэсэн, хэлэлцүүлэг өрнүүлэх зорилт дэвшүүлэн ажиллалаа. Тухайлбал, "Форум" телевизийн нэвтрүүлгийн хүрээнд гадаадын хөрөнгө оруулагчдад үзүүлж буй татварын хөнгөлөлт чөлөөлөлт нь нийгэмд баялаг бүтээх зорилготой хэрхэн уялдаж буй байдал, лиценз олголт, түүнтэй холбоотой авилгал, хууль бус үйл ажиллагаа зэрэг хурц тулгамдсан асуудлыг хөндөн ярилцсан нь салбарын хөгжлийн бодлогыг нээлттэй, ил тод, олон талын байр суурийг тусгасан хэлбэрээр боловсруулахад чухал хувь нэмэр оруулав.

ННФ уул уурхайн салбар болон гадаадын хөрөнгө оруулагчдад холбогдох татварын асуудлаар УИХ, Засгийн газрын гишүүдтэй санал солилцож, Нью-Йорк хотноо төвтэй Орлогын Ажиглагч хөтөлбөрийн хамт боловсруулсан санамж бичгүүдээр дамжуулан өөрсдийн байр суурь, зөвлөмжөө өгсөн болно. Оюу Толгой орд газрыг нээн илрүүлж, цаашид ашиглахаар төлөвлөж буй "Айвенхоу Майнз" компаниас гаргасан орд ашиглалтын цогцолбор төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийж, Монголын Засгийн газарт уг орд газрын ашиглалтаас орох орлогын талаар өөрийн дүгнэлтийг гаргаж бодлого боловсруулагчид болон олон нийтэд хүргэлээ. Тэрчлэн энэ асуудлаар янз бүрийн байр суурьтай талуудын хооронд уулзалт ярилцлага зохион байгуулав. Дээрх дүн шинжилгээнүүдэд тулгуурлан Монгол Улсын Засгийн газар уул уурхайн компаниудтай гэрээ байгуулахад эдийн засгийн загвар ашиглан санхүүгийн дүн шинжилгээ хийж, улмаар татвар, нөөц ашигласны төлбөр зэргийг оновчтой тогтоох боломжтойг онцлов. Түүнчлэн томоохон гэрээ хэлэлцээр хийхэд гадаад, дотоодын өндөр төвшний мэргэжилтнүүдийн туслалцааг авахын ач холбогдлыг санууллаа.

Уул уурхайн холбогдолтой бодлогын баримт бичиг, мэдээ мэдээлэл, үзэл бодол зэрэг иж бүрэн мэдээллийг агуулсан буланг [www.forum.mn](http://www.forum.mn) вэб порталд нээн ажиллуулав. Эдгээр үйл ажиллагааг 2006 онд улам гүнзгийрүүлэн үргэлжлүүлэх юм.

## ГАЗРЫН ШИНЭТГЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Газрын шинэтгэлийн асуудлаар Нээлттэй Нийгэм Форум иж бүрэн үйл ажиллагааг өмнөх жилүүдэд явуулж ирлээ. 2005 онд газрын шинэтгэлийн явцад мониторинг хийх үйл ажиллагааг үргэлжлүүлж дүгнэлт хийснээс гадна газрын шинэтгэлийн эрхзүйн асуудлаар бодлогын судалгаа хийж гүйцэтгэлээ.

“Байгаль-21” төрийн бус байгууллагын 2004 онд эхлүүлсэн газрын мониторингийн төслийг дуусгаж, газрын шинэтгэлийн ололт амжилт, алдаа оноог харуулсан иж бүрэн мэдээллийг бүрдүүлэн дүн шинжилгээ



хийж, үр дүнг нь цуврал семинар, өдөр тутмын сонины тогтмол булан, ном товхимол зэргээр дамжуулан олон нийт болон бодлого боловсруулагчдад хүргэлээ. Түүнчлэн ННФ-ын вэб хуудаснаа мониторингийн явц, үр дүнгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэв. Мониторингийн үйл ажиллагааны нэгдсэн дүгнэлтүүдийг бодлого боловсруулагчдад зориулан зөвлөмж байдлаар боловсруулж тарааснаас гадна олон талын оролцоотой семинар зохион байгуулсан нь мониторингийн дүнг тал бүрээс нь хэлэлцэх боломжийг олгосон юм.

Түүнчлэн газрын шинэтгэлийн хууль, эрхзүйн асуудлаар хийсэн бодлогын судалгааг дуусгаж, үр дүнг нь УИХ-ын гишүүд, газрын албадын албан тушаалтнууд, бодлого боловсруулагчид, олон нийтэд танилцуулав. Судлаачийн зарим дүгнэлт, зөвлөмж газрын тухай хууль тогтоомжид орсон өөрчлөлтөд тусгалаа олсон болно. Газрын шинэтгэлийн чиглэлээр ажиллаж байсан хоёрдахь судлаачийн ажлын явц, үр дүн хангалтгүй төвшинд байсан учир судалгааны хөтөлбөрөөс хассан байна.

2005 оны 10 дугаар сард “Шилжилтийн улс орны газрын шинэтгэлийн бодлого” сэдэвт олон улсын бага хурлыг Газрын харилцаа, геодези, зурагзүйн газартай хамтран амжилттай зохион байгууллаа. Уг уулзалтыг зохион байгуулахад Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн Орон Нутгийн Засаглал, Төрийн Албаны Шинэтгэлийн Санаачилга ихээхэн дэмжлэг үзүүлж хамтран ажиллалаа. Хуралд Монгол Улсын Их Хурал, Засгийн



газрын төлөөлөгчид, газрын асуудал эрхэлсэн яам, агентлагийн албан тушаалтнууд оролцож, Армени, Герман, ОХУ, Румын, Украин, Литва, Швед зэрэг 10 гаруй улс орны мэргэжилтнүүдтэй туршлага солилцлоо. Ингэснээр цаашид газрын шинэтгэлийн бодлогыг боловсронгуй болгоход шаардлагатай мэдээлэл, мэдлэгтэй болсноос гадна бүс нутгийн хамтын ажиллагааны эхлэлийг тавьсан гэж хэлж болох юм. Хурлын илтгэл зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг ННФ-ын вэб портал дээр байрлуулснаас гадна ном товхимол болгон гаргах бэлтгэл ажлыг хийж байна.



### Газрын мониторингийн төслийн дүгнэлтээс

Шинээр батлагдсан газрын хууль тогтоомжийг хэрэгжүүлж эхэлснээс хойшхи хоёр жил гаруйн хугацаанд энэ чиглэлээр улс, орон нутгийн хэмжээнд нэлээд ажил хийгдэж, нааштай эхлэлүүд тавигдсан ч хэрэгжүүлэх үйл явц зарим талаар удаашралтай байна.

- Газрын хууль тогтоомжийн талаарх иргэдэд хүрсэн мэдлэг, мэдээлэл хангалтгүй байна.
- Хууль, тогтоомжийг амжилттай хэрэгжүүлэх хамгийн чухал шат болсон сум, дүүрэг, баг, хорооны ажил хариуцсан хүмүүсийн мэдлэг нимгэн, хүнд сурталтай, зохион байгуулалт, шуурхай байдал хангалтгүй байна.
- Улаанбаатар хот зэрэг хүн ам ихээр төвлөрөн суурьшсан хот суурин, дүүрэг, хороод дахь газрын албадын ачаалал хэт ихэссэн, шаардлагатай тооны мэргэжлийн боловсон хүчин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, зураг материалаар хангагдаагүй байна.
- Өнөөгийн мөрдөгдөж буй газрын тухай болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжуудад зохицуулагдаагүй орхигдсон зарим асуудлыг тусгаж хуульчлах шаардлагатай.

Газрын хууль, тогтоомжийг боловсронгуй болгож, түүний хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр дараахь санал зөвлөмжийг бодлого боловсруулагчид, хууль хэрэгжүүлэгчдэд санал болгож байна. Үүнд:

- Газрын тухай хуулиар:
  - Монгол Улсын аж ахуйн нэгж байгууллагад богино хугацаагаар газар ашиглуулах асуудлыг нарийвчлан авч үзэж тусгах;
  - Бэлчээрийн газрыг иргэдийн хамтлаг, нөхөрлөл, болон эрчимжсэн фермерийн аж ахуйд эзэмшүүлэх асуудлыг шийдвэрлэх;
  - Дуудлага худалдаа эсвэл төсөл шалгаруулахад ганц санал ирсэн тохиолдолд хэрхэн шийдвэрлэхийг тодорхой болгох;

- Газар өмчлөлийн тухай хуулиар:
  - Тусгай хамгаалалттай болон тусгай хэрэгцээний газарт байгаа төв суурин газарт газар эзэмшүүлэх болон өмчлүүлэх асуудлыг анхаарах;
  - Иргэд сайн дураараа суурьшиж, төвлөрөл үүсгэсэн газарт газар өмчлөх асуудлыг шийдэх;
  - Хөдөө сумын харъяалалтай тосгон, Нийслэл, төв суурин газрын харъяалалтай тосгонд газар өмчлүүлэх асуудлыг зааглан тусгах;
  - Иргэд заавал төв, суурин газарт газар өмчлөхөөр хуульд тусгасныг эргэн харах; Хэрэв тухайн иргэн хүсвэл газраа өмчилж, эзэмшиж болох эрхийг зарим талаар хязгаарласан заалт бүхий Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг бүхэлд нь эргэж харах;
  - Иргэнд гэр бүлийнх нь хэрэгцээнд өмчлүүлэх газрын хэмжээг ам бүлийнх нь тоог харгалзан тогтоох асуудлыг сайтар судлан үзэх шаардлагатай байна.

Зохион байгуулалтын хүрээнд:

- Хууль, тогтоомжийг амжилттай хэрэгжүүлэх хамгийн чухал шат нь хуулийн мөн чанар, утга учрыг түүнийг хэрэгжүүлэгч бүх шатанд ажиллаж буй төрийн захиргааны удирдах албан тушаалтан, ажил хариуцсан хүмүүс, иргэдэд нэгдсэн зөв ойлголттойгоор хүргэх явдал бөгөөд үүнд чиглэгдсэн сурталчилгаа, сургалт, семинарыг оновчтой бөгөөд үр дүнтэй хэлбэрээр зохион байгуулах;
- Хуулийг хэрэгжүүлэх албадыг мэргэжлийн боловсон хүчин, шаардлагатай техник хэрэгслээр хангах;
- Газрын харилцааг боловсронгуй болгох чиглэлээр гадаад орон, олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл, зээл тусламжийн үр өгөөжийг сайжруулах;
- Хууль хэрэгжүүлэхэд оролцож буй бүх шатны байгууллагуудын ажлын идэвх санаачилга, уялдаа холбоог сайжруулах;
- Газрын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхдээ аль болох иргэд, олон нийтийн санал хүсэлт, оролцоонд тулгуурлах;
- Газар төлөвлөлт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг иргэдэд нээлттэй болгох хэрэгтэй байна.

## **ХУВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН**

Монголын эдийн засгийн урт хугацааны тогтвортой хөгжил нь жижиг, дунд үйлдвэрийн өсөлтөөс ихээхэн хамааралтай билээ. Харамсалтай нь эдгээр хувийн хэвшлийнхэн санхүүжилтийн маш их бэрхшээлтэй тулгардаг. Хөгжиж буй улс орнууд дахь эдийн засгийн өсөлтийн эргэлтийг хөдөлгөдөг санхүүгийн эх үүсвэрүүд Монголд байхгүйн зэрэгцээ санхүүжилт авах гол эх үүсвэр болох банк, банк бус санхүүгийн байгууллагууд нь зээл олгохдоо маш хатуу нөхцөл шаарддаг. Компани эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийх санхүүгийн эх үүсвэрийн (тухайлбал, ивээн тэтгэгч, хувийн болон аз туршсан хөрөнгө оруулалтын сан, санхүүгийн бус хөрөнгө оруулагч, олон нийтийн хөрөнгө оруулалтын зах зээл зэрэг) орон зай хоосон хэвээр байна. Иймээс Форум нь “Эдийн Засгийн Бодлогын Өрсөлдөх Чадвар” төсөлтэй хамтран 2004 онд хувийн хөрөнгө оруулалтын сан байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг тодорхойлох анхан шатны судалгааг хийсэн юм. Энэхүү судалгааны зөвлөмжүүдэд тулгуурлан хувийн хөрөнгө оруулалтын санг Монголд байгуулах боломжийг тодорхойлох хоёр дахь шатны судалгааг 2005 онд явууллаа.

Судалгаагаар хувийн хөрөнгө оруулалтын уламжлалт санд хамрагдах боломжтой компанийн чанар, хэмжээг нарийвчлан тодорхойлох зорилгоор компанийн удирдлага, өгөөжийн шаардагдах хувь хэмжээ, гарц, хөрөнгө оруулагчийн оролцоо ба удирдах зөвлөлийн гишүүнчлэл, үүсгэн байгуулагчийн дэмжлэг, бизнесийн баримт бичиг зэрэг асуудлыг авч үзсэн юм. Судалгааны үр дүнгээс үзэхэд Монголд найдвар төрүүлэхүйц компаниуд байгаа хэдий ч “цэвэр” компани эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийдэг уламжлалт хөрөнгө оруулагчдын хатуу шалгуурыг давах компани нэг ч байхгүй нь харагдлаа. Иймээс компани эзэмшигчийн өмчид хийх уламжлалт хөрөнгө оруулалтаас өөр хувилбарыг хайх, улмаар түүнтэй адилтгах хөрөнгө оруулалт буюу “хувьцаа эзэмшигчийн зээлийн сан” нь Монголын хувьд хамгийн тохиромжтой байж болох тухай зөвлөмжийг гаргалаа.

Түүнчлэн судалгаанд хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээ, худалдааны банкны үйлчилгээ, зуучлалын бусад хэлбэр, аз турших буюу эрсдэлтэй лизингийн хэлбэр зэргийг судлах санал зөвлөмжийг тусгасан болно. Дээрх судалгааг удирдан явуулсан олон улсын зөвлөх Брюс Норлунд “Хувийн компани эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийх буюу аз турших капиталаар компанийн хөрөнгийг бүрдүүлэх нь” сэдэвт сургалтыг банк, бизнес болон олон улсын байгууллагын төлөөлөгчдөд зориулан явуулсан нь оролцогчдын мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх ач холбогдолтой болсон юм.

Судалгааны ажлын нэг чухал үр дүн нь бизнесийн санхүүгийн боломж олгоход чиглэсэн энэ төрлийн хувийн хөрөнгө оруулалттай компани байгуулагдсан явдал юм.

### Монгол Улсад хувийн хөрөнгө оруулалтын сан байгуулах төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг тодорхойлох хоёр дахь шатны судалгааны үр дүнгээс

Бид “хөрөнгө оруулалт хийх магадлал бүхий компани” буюу хөрөнгө оруулалт хийхэд нэлээд боломжийн компанийг хайсан бөгөөд тэд дараахь үндсэн шалгуур үзүүлэлтийг хангасан байх ёстой байв. Үүнд:

1. Менежментийн хүчирхэг баг
2. Хөрөнгө оруулагчид шаардагдах өгөөжийн хувийг олгож чадах бүтээгдэхүүн ба үйлчилгээний зах зээл
3. Төлөвлөсөн “гарц” (тодорхой)
4. Оролцоо ба удирдах зөвлөлийн гишүүнчлэл
5. Үүсгэн байгуулагчийн тогтвортой хичээл зүтгэл
6. Сайтар бэлдсэн санхүүгийн тайлан, баримт бичгүүд

Дүн шинжилгээгээ 24 компани дээр явуулсан бөгөөд эдгээрийн найм нь илүү эрчимтэй дүн шинжилгээ хийх хангалттай үндэслэлтэй байлаа. Судалгаанд хамрагдсан ихэнх компани хэмжээний хувьд тавьсан шаардлагад нийцэж байв. Компаниуд нэг сая долларын орлоготой бөгөөд тэдэнд 500,000 долларын капитал шаардлагатай байсан. Зарим компани энэ хязгаараас доогуур үзүүлэлттэй байсан ч бидний үзэж байгаагаар тэд хөрөнгө оруулалт хийх илүү их боломжтой байв.

Бидний судалсан компаниуд нь өнөөгийн байдлаар Монголд байгаа “дээд давхарга”-ын компаниудыг төлөөлж байна. Найман компаниас зөвхөн дөрвөн компанийн таамаглан тооцоолсон өгөөжийн хувь хэмжээ нь 25 хувь буюу түүнээс дээш гарсан.

Компанийн эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийдэг хатуу шаардлагатай хувийн хөрөнгө оруулагчийн үүднээс авч үзвэл бид судалгааныхаа үр дүнг дараахь байдлаар дүгнэсэн болно:

- 1. Компанийн удирдлага.** Зах зээл, бизнесүүд нь дөнгөж эхлэлийн үе шатанд байгаа ч бидэнтэй уулзсан олон компанийн удирдлагын баг болон компанийн эзэд сайхан сэтгэгдэл төрүүлсэн. Гэхдээ ихэнх компанийн удирдлага, эзэд мэдээлэл өгөх талаар бидэнтэй хамтран ажиллах хүсэлтэй байсан ч компанийн ил тод байдал, итгэл хүлээх чадвартай эсэхийг бүрэн тодорхойлохын тулд нэгээс илүү удаа уулзах шаардлагатай байлаа.
- 2. Өгөөжийн шаардагдаж буй хувь хэмжээ.** Компаниудын гаргаж өгсөн, гэхдээ бидний бие даан шалгаагүй мэдээллээс үзвэл иж бүрэн судалгааны дүн шинжилгээнд хамрагдсан 8 компанийн

Компани	ӨХХ
А	25%
Б	3%
В	41%
Г	байхгүй
Д	36%
Е	47%
Ж	21%
З	-2%

хувьд эзэмшигчийн өмчид оруулах хөрөнгө оруулалтын ирээдүйн өгөөжийн хувь хэмжээ (ӨХХ) нь -2%-иас 47% хүртэл хэлбэлзэж байна. Ирээдүй байгаа ч гэсэн уламжлалт “цэвэр” хувийн хөрөнгө оруулалтын хэрэгслэлд нийцэх ирээдүйн хэлцлийн тоо хангалтгүй байна.

- 3. Гарц.** Хөрөнгө оруулалтын өгөөжийг хүртэхийн тулд хөрөнгө оруулалтаас гарах арга зам буюу гарц олох асуудал нь Монгол шиг хөгжиж буй зах зээлийн нөхцөлд компани эзэмшигчийн өмчид хувийн хөрөнгө оруулалт хийхэд тавигддаг гол шаардлага болдог. Хөрөнгийн зах зээлээр дамжих гарц өнөөгийн байдлаар Монголд хэрэгжих боломжгүй байна. Ийм нөхцөлд компани эзэмшигчийн өмчид хийсэн хөрөнгө оруулалтаас гарах хувилбарууд хязгаарлагдмал, стратегийн хөрөнгө оруулагч олох, зээлээр худалдан авах зэргээс шалтгаалан хязгаарлалт эрсдлийг нэмэгдүүлдэг.
- 4. Хөрөнгө оруулагчийн оролцоо ба удирдах зөвлөлийн гишүүнчлэл.** Компанийн удирдлага, эздийн хандлагыг дүгнэхэд хөрөнгө оруулагчийн зүгээс компанийн хөгжлийн асуудалд оролцож, удирдах зөвлөлийн гишүүн байх шаардлагын талаар янз бүрийн санал сэтгэгдэл илэрхийлж байлаа. Хувийн хөрөнгө оруулагчийн зүгээс удирдлага заавар авах асуудлыг компаниудын ойролцоогоор хагас нь хүлээн зөвшөөрч байсан. Зарим нь техникийн ба санхүүгийн туслалцаа авах сонирхолтой байсан. Гэхдээ зарим компани хөрөнгө оруулагчийн оролцоог компанийн хэрэгт дайран орох явдал хэмээн үзэж хөрөнгө оруулагчийн хөрөнгөөс гадна авчрах үнэ цэнийг бүрэн ойлгохгүй байсан байж магадгүй юм.
- 5. Үүсгэн байгуулагчийн дэмжлэг.** Бидэнтэй уулзсан компаниудын олонх нь бүлэг компаниудын нэг хэсэг байсан. Хувийн хөрөнгө оруулагчид бүлэгт багтдаг компанид хөрөнгө оруулах сонирхолгүй байдаг бөгөөд тухайн бизнест өөрийнхөө хөрөнгийн ихэнхийг зориулсан үүсгэн байгуулагчтай шууд ажиллахыг илүү сонирхдог.
- 6. Бизнесийн баримт бичиг.** Зарим компани бизнесийн төлөвлөгөө, санхүүгийн тайлан тэнцэл зэрэг баримт бичгийг өгсөн боловч нэг нь ч хувийн хөрөнгө оруулагчийн шаардлагад нийцэхээргүй байсан. Зах зээл хөгжиж буй Монгол шиг оронд ийм зүйл тохиолддог.

## ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЯРИА ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Монгол орны хөгжлийн урт хугацааны үзэл баримтлал боловсруулахад хувь нэмэр оруулах зорилгоор ННФ “Хөгжлийн тухай яриа” байнгын хэлэлцүүлэг бий болгохыг зорьж байна.

2005 онд ННФ Монголын тэргүүлэх эдийн засагчид, бодлого боловсруулагчид, их, дээд сургуулиудтай хамтран цуврал лекц, ярилцлагыг зохион байгуулж эхэлсэн бөгөөд дэлхийд нэртэй хоёр эдийн засагчийн лекцийг зохион байгуулсан байна.



2005 оны тавдугаар сард Нобелийн шагналт эдийн засагч Роберт Манделлийн цуврал лекц, уулзалтыг Монгол Улсын Их Сургуультай хамтран зохион байгуулав. Дэлхийн тэргүүлэх макро эдийн засагчдын нэг Роберт Манделл тодорхой бүс нутгууд нэг мөнгөн тэмдэгтэд шилжих боломж болон дэлхийн эдийн засгийн гол чиг хандлагын талаар бодлого боловсруулагчид, судлаачид, эрдэм шинжилгээнийхэн, өргөн олон нийтэд зориулан хоёр лекц уншиж, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчидтэй ярилцлага өрнүүллээ. Тэрбээр мөн Монгол Улсын Ерөнхий сайдтай уулзсан. Роберт Манделл Монгол Улсын хөгжилд даяарчлалын гүйцэтгэх үүрэг, ялангуяа тус улсын хөрш Хятад улсын дэлхийн эдийн засгийн тавцанд өсөн нэмэгдэж буй үүрэг ролийн талаар үзэл бодлоо хуваалцлаа.

Нэрт эдийн засагчидтай хийсэн цуврал ярилцлага, лекцийн дараагийн зочин нь Нобелийн шагналт эдийн засагч Жозеф Штиглиц байлаа. Тэрбээр 2005 оны зургадугаар сарын 6-нд ННФ-аас зохион байгуулсан сэтгүүлчдэд зориулсан сургалтад видео бага хурлаар дамжуулан оролцож, Монголын хөгжилд хэвлэл, мэдээллийн гүйцэтгэх үүргийн талаар лекц уншсан юм. Түүний яриа Монголын хувьд хамгийн хурдацтай хөгжиж буй уул уурхайн салбар руу чиглэсэн бөгөөд “нөөц баялгийн хяслан”-гаас зайлсхийх, үр шимийг нь хэрхэн хүртэх тухай байлаа. Жозеф Штиглицийн лекцийг бид [www.forum.mn](http://www.forum.mn) портал сайтаараа дамжуулан олны хүртээл болгосон бөгөөд эдүгээ Монголын өдөр тутмын томоохон сонин болох “Зууны мэдээ” сонин түүний лекцээр эрдэмтэн судлаачдын дунд “Байгалийн нөөц баялаг ба хөгжил” сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлж байна.

2002-2004 онд олон талын оролцоотойгоор хөгжлийн сценари боловсруулах тодорхой аргазүйд тулгуурлан боловсруулсан Монгол Улсын эдийн засгийн 2015 он хүртэлх хөгжлийн ирээдүйн дүр төрхийг олон нийтэд илүү хүртээмжтэй болгох талаар ажиллалаа.

Форум нь эдийн засгийн хөгжлийн ирээдүйг дүрслэх, олон нийт ирээдүйнхээ талаар бодож эргэцүүлэх, хэлэлцэхийг хөхиүлэн дэмжих зорилгоор Монголын ирээдүйн хөгжлийн дөрвөн үндсэн дүр зургийн талаар холбогдох нийтлэл, зураг, баримт бичгийг багтаасан сэтгүүл хэвлэн нийтлүүлсэн бөгөөд дүр төрхүүдийн тухай сонирхсон хүмүүс онлайн хэлэлцүүлэг, мэтгэлцээн өрнүүлж байна. Мөн Форумын олон нийтэд хүрэх гол хэрэгсэл болох портал сайтаар дамжуулан барууны тэргүүлэх эдийн засагчдын бичсэн бодлогын асуудлуудаарх нийтлэлүүдийг орчуулан тавьж байна.

Үндэсний хөгжлийн яриа хэлэлцүүлэг өрнүүлэх энэ ажлын хүрээнд Нээлттэй Нийгэм Форум Дэлхийн Банктай хамтран жижиг, дунд үйлдвэрлэл ба бичил зээлийн хөгжлийн талаар хандивлагчдын үйл ажиллагааг уялдуулахад чиглэсэн сар тутмын уулзалтыг зохион байгуулсан болно.



## БУСАД

### **"АЛБАДАН АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛЫГ ХЭВШҮҮЛЭХ" ТӨСӨЛ**

Албадан ажил хийлгэх ял нь гэмт хэргийн улмаас учруулсан хор уршгаа ялтан нийгэмдээ нөхөн төлөх, нийгэм хамт олны дунд засран хүмүүжиж гэм буруугаа ухаарах, цаашид нийгэмд бие даан амьдрах чадвартай болох боломжийг бүрдүүлдэг. Гол давуу тал нь насанд хүрээгүй хүмүүс болон хөнгөвтөр гэмт хэрэг анх удаа үйлдсэн гэмт хэрэгтэн шоронд хоригдон нийгмээс тасрах, рецедив гэмт хэрэгтнүүдийн нөлөөнд автаж давтан гэмт хэрэг үйлдэх нөхцлөөс урьдчилан сэргийлэх явдал юм. Нөгөө талаар эдийн засгийн хүндрэлтэй байгаа манай улсад нэлээд дарамт авчирдаг шоронгийн өртөг зардлыг хөнгөлөх ач холбогдолтой юм. Иймээс энэхүү шинэ ял нь нийгэм, эдийн засгийн хувьд ихээхэн ач холбогдолтой төдийгүй эрүүгийн ял шийтгэлийн тогтолцоонд нийгэм, хамт олны оролцоог бүрдүүлэх шинэ хандлагыг бий болгож буйгаараа онцлог юм. Төслийн зорилго нь хөнгөвтөр гэмт хэрэг анх удаа үйлдсэн болон насанд хүрээгүй гэмт этгээдийг нийгэм, хамт олны дунд хүмүүжүүлэх, нийгэмд тустай ажил хийснээр учруулсан гэм хороо төлөх боломжийг бий болгох, гэмт хэрэг үйлдсэн хүнийг хүнд хөнгөнөөс нь үл шалтгаалан тусад нь хорих ёстой гэсэн нийгмийн хандлагыг өөрчлөх явдал юм.

ННФ нь МННХ-гээс санхүүжүүлэн хэрэгжүүлж байсан "Албадан ажил хийлгэх ялыг хэвшүүлэх" төслийг Шүүхийн Шийдвэр Биелүүлэх Ерөнхий Газартай хамтран хоёр дахь жилдээ хэрэгжүүлж байна. 2005 онд хийгдсэн үнэлгээний үндсэн дээр төслийн үр дүнг дүгнэж, цаашид энэхүү төслийг өргөжүүлэн зөвхөн нийслэлийн дүүргүүдийн хэмжээнд бус, улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр боллоо.

Төслийн хүрээнд албадан ажил хийлгэх ял оноох, эдлүүлэх, хянах ажиллагааг явуулах хуулийн байгууллагуудын ажилтнуудыг бэлтгэх, мэдээллээр хангах тогтмол сургалтыг зохион байгуулах, олон нийтэд мэдээллээр үйлчлэх зэрэг үйл ажиллагаа хийгдэж байна. Түүнчлэн ажлаар хангах байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллаж, уг ялаар шийтгэгдсэн хүмүүстэй хэрхэн харьцах, ажиллуулах талаар зөвлөгөө, сургалт зохион байгуулав. Ялантай ажиллах, нийгэмших, засрал хүмүүжилд нь нөлөөлөх үйл ажиллагааг нийгмийн ажилтнуудын тусалцаатайгаар хэрэгжүүлж, нийгэмд тустай ажлаар хангалаа.

## **ДОРНО ДОРНО: ХИЛ ХЯЗГААРГҮЙ ТҮНШЛЭЛ БҮСИЙН ХӨТӨЛБӨР**

---

Дорно дорно хөтөлбөр нь нээлттэй нийгмийг хөгжүүлэх, түүнийг бэхжүүлэх нөхцлийг бий болгоход чиглэсэн хүмүүсийн идэвх санаачилга, хамтын ажиллагаа, хил хязгааргүй түншлэлийг дэмждэг Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн бүсийн хөтөлбөр бөгөөд ННФ Монгол дахь үйл ажиллагааг нь хариуцан хэрэгжүүлж байна. Хөтөлбөр нь нээлттэй нийгмийн үзэл санааг бүсийн хэмжээнд бэхжүүлэхэд түлхэц болох шинэ санаа, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх явдлыг дэмжин хоёр буюу түүнээс дээш орныг хамарсан төслийг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлдэг.

Орон нутгийн нөхцөл байдлыг сайн мэдэрч дороос гарч ирсэн санаачилгуудад анхаарлаа хандуулж нээлттэй нийгэм хөгжүүлэхэд хүмүүс хил хязгаар харгалзахгүйгээр хүч хавсран ажиллах боломжийг нэмэгдүүлэх явдлыг урт хугацааны зорилго болгодог энэ хөтөлбөрийн хүрээнд бүсийн орнуудад зохиогдож буй шинэлэг санаа, арга туршлагаа хуваалцах зорилго бүхий арга хэмжээнд Монголын мэргэжилтэн, төлөөлөгчдийг хамруулах үйл ажиллагаа хийж байна.

2005 онд энэхүү хөтөлбөрийн хүрээнд болон санхүүжилтээр дараахь хүмүүс хурал зөвлөгөөнд оролцлоо. Тухайлбал:

Д.Биндэрья, Б.Эрдэнэбаатар нар “Боловсролын салбарын хариуцлагатай байдал болон чанарын баталгаа:шалгалтын тоон мэдээллийн боломжит хувь нэмэр” хуралд /Украин улс, 2005 оны 10 дугаар сарын 5-9/,

Б.Энхжин “Шорон дахь ДОХ/ХВДХ-ын чиглэлийн үйл ажиллагаа: урьдчилан сэргийлэх, эмчилгээ, дэмжлэг” хуралд /Украин улс, 2005 оны 11 дүгээр сарын 1-2/,

Н.Энхтуяа, Р.Банди нар “Боловсролын бодлогын шинэчлэл болон Бодлогын төвүүдийн гүйцэтгэх үүрэг ” /Литва улс, 2005 оны 11 дүгээр сарын 11-12/,

Р.Нарангэрэл, М.Төрбаяр нар “Иргэний Нийгмийн Хуулийн дэлхийн чуулган” /Турк улс, 2005 оны 11 дүгээр сарын 17-19/ тус тус оролцжээ.

## ФОРУМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ:

### ХӨГЖЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТӨВ

Монгол Улсад ажиллаж буй донор байгууллагуудтай (Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн Банк, НҮБ) хамтран үйл ажиллагаагаа өргөжүүлсэн Хөгжлийн Мэдээллийн төв бодлогын болон хөгжлийн сэдвээр шинээр гарч байгаа ном, судалгааны тайлан, үнэлгээ, бодлогын баримт бичиг зэрэг цогц мэдээллийг нэг цэгээс хүргэхийн зэрэгцээ судлаачид, бодлого боловсруулагчид, төрийн болон ТББ, донор байгууллагын ажилтнууд олон нийттэй уулзалт хийдэг, шинээр гарч буй судалгаа, ном бүтээлээ танилцуулдаг түшиц газар болж эхэллээ. Ингэснээр хүмүүс хэрэгцээ шаардлагатай мэдээллээ үнэ төлбөргүй авч улс орны хөгжлийн



асуудлаар өрнөж буй уулзалт ярилцлагад илүү мэдлэг, мэдээлэлтэй оролцоход тус нэмэр болж байна.

Мэдээллийн төв нь зөвхөн мэдээллийн үйлчилгээ үзүүлээд зогсохгүй хөгжлийн бодлогын асуудлаар уулзалт ярилцлага өрнүүлэх, бусад улс орны онлайн номын сан болон мэдээллийн санг танилцуулах, сургалт явуулах, мэдээллийг хүртээмжтэй, энгийн, хялбар аргаар түгээх, олон улсын хөгжлийн агентлагуудаас эрхлэн хэвлэж байгаа чухал сэдвийн номыг өөрийн орны хэрэглэгчдэд хүргэх зэргээр үйл ажиллагаагаа улам өргөжүүлэхийг зорьж ажиллалаа.

Хөгжлийн Мэдээллийн төвд 2005 оны жилийн эцсийн байдлаар судалгааны тайлан, бодлогын баримт бичиг, донор байгууллагуудын гол хэвлэн нийтлэл, тайлан, статистик мэдээлэл, сүүлийн үед хэвлэгдэн олны анхаарал татаж байгаа ном зэрэг 3200 орчим эх сурвалж хэвлэмэл болон электрон хэлбэрээр ашиглагдаж байна. Түүнчлэн гадаад, дотоодын тогтмол хэвлэл, өдөр тутмын сонин зэрэг 20 гаруй төрлийн хэвлэлээр олон нийтэд үйлчилдэг. Төвд байгаа бүх ном, судалгааны тайлангуудыг Онлайн каталогийн [www.forum.mn/](http://www.forum.mn/) хайж захиалах боломжтой.

### Үйл ажиллагаа, үр дүн

Хөгжлийн Мэдээллийн төв нь судлаачид, бодлогын хүрээнийхэн, их дээд сургуулийн багш нар, төрийн болон ТББ-ын ажилтнууд, сэтгүүлчид, олон улсын байгууллагын ажилтнууд, УИХ-ын гишүүд, олон

нийтэд мэдээллийн үйлчилгээ үзүүлж ирсэн ба 2005 онд нийт 5100 орчим хүн уг төвд хандан үйлчилгээ авчээ. Үүнээс 3500 гаруй хүн ном, судалгаааны материалыг гэрээр авч ашигласан байна.

Мөн хөдөө орон нутгийн номын сан, мэдээллийн төвүүд, их дээд сургуулийн номын сан, УИХ-ын болон Засгийн газрын гишүүд, ТББ-уудад 11700 гаруй ном түгээж, Дэлхийн Банкнаас эрхлэн гаргаж байгаа номыг хөнгөлөлттэй үнээр захиалан нийлүүлдэг боллоо. 2005 онд төвийн мэдээллийн сан 400 орчим ном, 80 гаруй шинэ судалгаааны тайлан, үнэлгээ, 30 гаруй CD-ээр нэмэгджээ.

Түүнчлэн судлаачид, зохиогчид, Засгийн газрын агентлаг болон донор байгууллагын ажилтнуудыг урьж олон нийттэй чөлөөтэй ярилцах боломжийг олгохын зэрэгцээ тус төвийн онлайн каталоги, Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банкны онлайн мэдээллийн сан, Кэмбрижийн онлайн сэтгүүлүүд, Оксфордын лавлах номуудыг хэрхэн ашиглах талаар зааварчилга-сургалт, шинээр хэвлэгдэн гарч байгаа судалгаа болон орчуулгын номын нээлт зэрэг нийтэд зориулсан 20 орчим арга хэмжээг зохион байгууллаа.

Төвийн үйлчлүүлэгчид Интернэт ашиглан судалгаа хийх, мэдээлэл хайх, электрон мэдээлэл ашиглах боломжоор хангагддаг. 2005 онд хараагүй болон сул хараатай иргэд ашиглах тусгай компьютер, техник технологийг бий болгосон юм. Тайлант хугацаанд нийтдээ 500 орчим хүн 2000 орчим цаг Интернэт ашигласан байна.

2005 онд Хөгжлийн Мэдээллийн төв нь үйл ажиллагааны хувьд төлөвшиж бусад улс оронд ажилладаг ижил төрлийн мэдээллийн төвд болдог арга хэмжээг олон нийтэд хүргэхийг зорьж, үйлчилгээгээ зөвхөн мэдээллийн төвд төдийгүй боломжит үйлчилгээг онлайнаар хүргэсэн нь үр дүнгээ өгч, бодлогын хүрээнд ажиллаж буй хүмүүс хэрэгцээ шаардлагатай мэдээллээ захиалдаг болж байна. Түүнчлэн хамтран ажиллаж байгаа хөгжлийн агентлаг, судалгаааны төв, Засгийн газрын болон ТББ-ууд нь зөвхөн хэрэглэгч-үйлчлүүлэгч байх төдийгүй ном, судалгаааны тайлан, бодлогын баримт бичиг зэрэг мэдээлэл нийлүүлж хувь нэмрээ оруулж байна.

## ТЕЛЕВИЗИЙН ХӨТӨЛБӨР

Бодлого боловсруулах үйл явц, түүний хэрэгжилтэд иргэдийн идэвхтэй оролцоог хангахад дөхөм үзүүлж, улс орны хөгжлийн болон бодлогын өргөн хүрээтэй асуудлаар мэдлэг, мэдээлэл түгээх зорилготой Нээлттэй Нийгэм Форумын телевизийн хөтөлбөр 2005 онд тус бүр нь нэг цагийн үргэлжлэл бүхий 30 удаагийн “Форум” шууд нэвтрүүлгийг бэлтгэн Монголын үндэсний телевизээр орон даяар дамжууллаа. Нэвтрүүлэгт янз бүрийн ажил мэргэжлийн 1000 орчим хүн биеэр оролцож байр сууриа илэрхийлэн мөн хэдэн мянган үзэгч нэвтрүүлгийн сэдвүүдээр утсаар саналаа өгсөн юм.

Монгол орны нийгэм, эдийн засаг, улстөрийн амьдралын тулгамдсан асуудлууд, шийдвэрлэх арга замуудыг сонирхогч олон талын оролцоотой хэлэлцүүлдэг “Форум” нэвтрүүлгийн сэдэв, агуулга их өргөн байлаа. Тухайлбал, иргэдийн шууд оролцоо бүхий нээлттэй засаглал, иргэний хөдөлгөөн, төрийн ой санамж, хариуцлагатай төр, сонгуулийн тогтолцоо, татвар, нийгмийн даатгалын тогтолцоо, мэдээллийн эрх чөлөө болон хэвлэл, мэдээллийн өөрийн зохицуулалт, авилгын индекс, сонирхлын зөрчил, Монголын өрсөлдөх чадавхийг ахиулах тэргүүлэх салбарууд - уул уурхайн болон аялал жуулчлалын хөгжлийн асуудлууд, ядуурал, монгол хүний орлого зэрэг олон талт сэдвийг хөндлөө. “Форум” нэвтрүүлгийн дэвшүүлсэн асуудлууд нь нийгмийн анхаарлыг нэлээд татаж, иргэний нийгмийн төлөвшилт, бодлого боловсруулагчдын төвшинд зохих нөлөө үзүүлж эхэллээ гэж дүгнэж болохоор байна.

Ялангуяа Монголын говьд шинээр нээгдсэн зэс, алтны дэлхийд томоохонд тооцогдох орд газрын ашиглалт, алтны шороон ордуудын олборлолтоос эдийн засагт үзүүлж байгаа үр ашгийн төвшин, уул уурхайн олборлолтоос үүдсэн экологийн сүйрлийг хөндсөн цуврал нэвтрүүлэг нийгмийг ямар нэг хэмжээгээр цочроож, байгаль хамгаалах, газрын хэвлийн баялгийг оновчтой ашиглах чиглэлийн иргэний үүсгэл санаачилгын хэд хэдэн хөдөлгөөн бий болж, идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхлэхэд зохих түлхэц болсон юм.

Монголын Хэвлэлийн Хүрээлэнгээс нийт телевиз үзэгчдийн дунд тогтмол явуулдаг санал асуулгын дүнгээр “Форум” нэвтрүүлэг 2005 оны телевизийн улстөр, нийгмийн шилдэг нэвтрүүлгээр шалгарч өндөр чансаатай нэвтрүүлгийн нэг боллоо.

## Нээлттэй Нийгэм Форумын 2005 оны нэвтрүүлгүүдийн товч танилцуулга

1	2005 оны 1-р сарын 5.	<u>“2016 ОНЫ МОНГОЛ: ГОЧООГИЙН 4 ТАВИЛАН”</u> Жил гаруйн өмнө МННХ-ээс боловсруулж “Шинэ эрин” сэтгүүлд нийтэлсэн 2016 оны Монголын хөгжлийн сценари буюу зураглалын дөрвөн хувилбарыг хэлэлцлээ.
2	2005 оны 1-р сарын 12.	<u>“ХАРИУЦЛАГАТАЙ ТӨР”</u> Улсын Их Хурлаас 1998 онд баталсан Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, УИХ-ын тогтоолоор РТХЭГ-ыг татан буулгаж үндэсний нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болгон зохион байгуулахаар заасан атал хэрэгжүүлэлгүй зургаан жил болсон төр, засгийн хариуцлагын тухай нэвтрүүлэг.
3	2005 оны 1-р сарын 19.	<u>“МОНГОЛЫН АЛТ”</u> Алтын уурхайнууд өнөөдөр улс орны эдийн засагт ямар хувь нэмэр оруулж байгаа болон байгаль орчныг хэрхэн сүйтгэж нөхөн сэргээлт хийхгүй байгаа талаар хэлэлцэв.
4	2005 оны 1-р сарын 26.	<u>“ЯДУУРЛЫН ЭСРЭГ ДАЙНЫ БАЙДАЛ”</u> 2004 оны намар Монгол Улсын Ерөнхий сайд Ц.Элбэгдорж “Засгийн газар ядууралд дайн зарлаж байна” хэмээн албан ёсоор мэдэгдсэн. Ингээд Засгийн газар ядууралтай хэр сайн “байлдаж” байгаа талаар дүгнэн ярилцав.
5	2005 оны 2-р сарын 2.	<u>“НҮҮХ ҮҮ?”</u> Орон нутгаас бэлтгэсэн “Форум” нэвтрүүлгийн анхны дугаар бөгөөд Монгол Улсын 331 сумыг төлөөлүүлж Архангай аймгийн Батцэнгэл сумын жишээн дээр хөдөөд малчдын тоо жил бүр цөөрч, хөдөөгөөс хот, суурин газар руу шилжигсдийн тоо буурахгүй байгаагийн шалтгаан, цаашдын чиг хандлагыг малчдын оролцоотойгоор хэлэлцлээ.
6	2005 оны 2-р сарын 16.	<u>“МОНГОЛ БӨХ - СУМО”</u> Сүүлийн үед монголчуудын хамгийн үзэх дуртай болсон японы мэргэжлийн сумогийн барилдаан ба монголын үндэсний бөхийг харьцуулан ярилцаж монгол бөхөд хавтгайрсан нутаг нугын үзэл, “начны найраа” зэрэг сөрөг үзэгдлүүдийг хэрхэн даван туулах тухай нэвтрүүлэг.
7	2005 оны 2-р сарын 23.	<u>“УЛСТӨРИЙН ШИНЭ НӨХЦӨЛ БАЙДАЛ”</u> Монголд хоёр нам хэт давамгайлж байснаа улстөрийн зөвшилцлийн үр дүнд хүчтэй сөрөг хүчин байхаа больсон шинэ нөхцөл байдал, үр дагаврын тухай нэвтрүүлэг.
8	2005 оны 3-р сарын 2.	<u>АВИЛГЫН ИНДЕКС</u> Монгол дахь авилгын нөхцөл байдал улам бүр муудсаар байгааг тодорхойлоод байдлыг эрүүлжүүлэх арга замуудыг шүүн хэлэлцлээ.
9	2005 оны 3-р сарын 9.	<u>ХОТ ТӨЛӨВЛӨЛИЙН БОДИТ БАЙДАЛ</u> Улаанбаатарт орон сууцны дэргэдэх хүүхдийн тоглоомын талбай, сургуулийн биеийн тамирын талбай, явган зам, зүлэг, цэцэрлэгийн дээр баригдсан, баригдаж буй барилгуудыг тойрсон “газрын маргаан” нэртэй зөрчил тэмцлийн тухай нэвтрүүлэг юм.
10	2005 оны 3-р сарын 16.	<u>МОНГОЛД АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ЯМАР ЧИГЛЭЛЭЭР ХӨГЖИХ ВЭ?</u> Зөвхөн сайхан орон, байгаль нутаг нь онгон төрхөөрөө, хүн ард нь нөхөрсөг, хөдөө нутагтаа нүүдлийн соёл иргэншлийг хадгалж үлдсэн гээд улиг болсон сурталчилгаагаар хол явахгүй талаар санал солилцов.

## Нээлттэй Нийгэм Форумын 2005 оны нэвтрүүлгүүдийн товч танилцуулга

<b>ОЮУТОЛГОЙ БИДЭНД ЮУ ӨГӨХ ВЭ?</b> Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт дэлхийд томд орох алт, зэсийн орд илрүүлсэн Канадын "Айвенхоу Майнз" компанийн эзэн ноён Роберт Фридландтай Засгийн газрын байгуулах гэж байгаа тогтвортой байдлын гэрээ Монголчуудын эрх ашигт хэр нийцэж байгаа талаар ярилцав.	2005 оны 3-р сарын 23	11
<b>ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ӨӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ</b> Монголын хэвлэл, мэдээллийг эрүүлжүүлэх алхмуудын талаар сэтгүүлчид болон улстөрчид, үзэгч, уншигч, сонсогчдийн төлөөллөөр хэлэлцүүлээ.	2005 оны 3-р сарын 30	12
<b>СУРАХ БИЧГИЙН ҮНЭ</b> Сурах бичгийг үнэтэй болгох тухай төрийн байгууллагуудын шийдвэр, үүнээс гарах үр дагаврын талаар яам, хэвлэх үйлдвэрийн захирлууд, эцэг эхчүүдийн оролцоотойгоор хэлэлцлээ.	2005 оны 4-р сарын 6	13
<b>2008 ОНЫ "ТОГЛООМЫН ДҮРЭМ"</b> УИХ-ын сонгуулийн хуулийг өөрчлөх хувилбаруудыг хэлэлцэв.	2005 оны 4-р сарын 13	14
<b>МЭДЭХ ЭРХ</b> Манай төр, засаг иргэддээ хаалттай учраас авилгал хавтгайрч, дээд ба дунд шатны албан тушаалтнууд дураараа дургиж байгааг дүгнээд мэдээллийн эрх чөлөөний хуулийн төслийг хэрхэн бэлтгэж байгаа талаар хэлэлцэв.	2005 оны 4-р сарын 20	15
<b>ОЛИМПИЙН НАЙДВАР</b> 2008 онд өмнөд хөршийн маань нийслэлд болох олимпоос бид аварга төрнө гэж найдах эрхтэй юу? Ямар төрлөөр, хэн Монголын анхны олимпийн аварга гэсэн алдрыг хүртэх вэ? Энэ талаар Монголын нэртэй тамирчид, дасгалжуулагчид, ивээн тэтгэгч, бизнесийнхэн ярилцав.	2005 оны 4-р сарын 27	16
<b>МОНГОЛЫН НОГООН ХЭРЭМ</b> "Ногоон хэрэм" бол 2005-2035 он хүртэлх 30 жилийн хугацаанд Монгол орны баруун зүүн тийш 12 аймгийг хөндлөн өнгөрөх 2500 км урт ойн үндсэн зурвас, бас 1200 км-ээс доошгүй урттай туслах зурвас байгуулах асар их бүтээн байгуулалт юм. Энэ бүтэх үү?	2005 оны 05-р сарын 04	17
<b>МАРГААШИЙН ТЭТГЭВЭР</b> Өнөөдөр манай улсын хэмжээнд 170 гаруй мянган хүн өндөр насны тэтгэвэр авдаг. Жилд 74 орчим тэрбум төгрөг зарцуулдгийн 70 тэрбум нь одоо ажил хөдөлмөр эрхлэж байгаа хүмүүсийн ирээдүйд авах тэтгэвэртээ төлсөн мөнгө. Үлдсэн 4 тэрбум гаруйг нь л улсын төсвөөс гаргадаг байна. Монгол Улсын нийгмийн даатгал, тэтгэврийн тогтолцоо аль зүгт явж байна вэ?	2005 оны 5-р сарын 11	18
<b>ТАТВАР</b> УИХ-ын чуулганаар Монгол Улсын татварын хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулна. 100 сая төгрөгөөс дээш орлоготой компаниуд 30 хувийн татвар төлдөг байсан босгыг 500 сая төгрөг болгож нэмэгдүүлнэ. Тэгвэл 100 гаруй томоохон компанийн татвар 15 хувь болж буурна. Энэ асуудлыг Сангийн сайдын оролцоотойгоор хэлэлцлээ.	2005 оны 5-р сарын 25	19
<b>ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨН</b> Иргэдийн хөдөлгөөний тавьж байгаа шаардлагыг албан тушаалтнууд хэрхэн хүлээж авдаг вэ, иргэдийн тэмцэл үр дүнд хүрдэг үү?... Голуудын цутгалд алт олборлохыг эсэргүүцсэн хөдөлгөөн бараг аймаг бүхэнд байгуулагдсан, гэвч тэдний тэмцэл алт олборлохыг бүрмөсөн зогсоох эцсийн зорилгоо биелүүлж чадахгүй байгаагийн шалтгааныг хэлэлцлээ.	2005 оны 6-р сарын 08	20

## Нээлттэй Нийгэм Форумын 2005 оны нэвтрүүлгүүдийн товч танилцуулга

21	2005 оны 6-р сарын 15	<b>НЭГ УДААГИЙН МОНГОЛ</b> Олон хүний нэрлэж заншсанаар төрийн хар хайрцагны бодлого буюу төрийн ой санамж, залгамж чанар Монголын төрд хангалтгүй байгаа талаар ярилцав.
22	2005 оны 6-р сарын 22	<b>"МОНГОЛЧУУД ЭРГЭЖ ИРЭХ ҮҮ?"</b> 1990-оноос хойш Монголын аль ч төр, Засгийн газар иргэдээ гадаад руу цагаачлахыг уриалж байгаагүй атал хэдэн арван мянгаараа гадагшаа гараад суурьчихсан. Цаашдаа юу болох вэ?
23	2005 оны 11-р сарын 2.	<b>АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ: ЧИНГИСИЙН МОНГОЛ</b> Ядаж Чингис хааныхаа нэрээр бид жуулчдыг татаж чадаж байна уу? Үүнийг яаж манай аялал жуулчлалын том брэнд болгох вэ гэсэн асуулт тавьж ярилцав.
24	2005 оны 11-р сарын 9.	<b>СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ</b> Энэ сэдвийг анх удаа хөндөн ярилцаж төр, засгийн ажил, төрийн албан тушаалтнуудын үйл ажиллагаанд хэм хэмжээ суларч, дүрэм журам, хууль ёс алдагдаж авилгалын үүд нээгдэж байна гэсэн дүгнэлт хийлээ.
25	2005 оны 11-р сарын 16.	<b>ӨРСӨЛДӨХ ЧАДВАР: АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ</b> Монгол Улс энэ онд дор хаяж 500 мянган жуулчин авах зорилт хэрэгжихгүй болжээ. Аялал жуулчлалын салбарын бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэх арга замыг эрэлхийлсэн нэвтрүүлэг.
26	2005 оны 11-р сарын 23.	<b>МОНГОЛ ХҮНИЙ ОРЛОГО</b> Монголчууд бид ахуй амьдрал, амьжиргааны төвшнөөрөө яалт ч үгүй бие биенээсээ илт ялгардаг болсон. Баян чинээлэг хэсэг нь хүн амын 20 хувь, үгээгүй ядуу нь 80 хувьд хүрсэн ч гэж ярьж байгаа. Энэ тухай илэн далангүй ярилцлаа.
27	2005 оны 11-р сарын 30.	<b>ГАЗРЫН МАРГААН</b> Улаанбаатар хотын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө, газрын бүртгэл, кадастр, хэн ямар газрыг эзэмшдэг, аль газрыг хэзээ ямар журмаар олгох тухай мэдээллийг иргэдэд өгдөггүй хэвээрээ байгааг шүүмжлэн ярилцав.
28	2005 оны 12-р сарын 07.	<b>МОНГОЛД ЭРҮҮ ШҮҮЛТ БИЙ ЮУ?</b> Сэжигтнийг мөрдөн байцаах болон урьдчилан хорих явцад дарамт шахалт, зодуур, эрүү шүүлт хамгийн их гардаг ноцтой асуудлыг хэрхэн шийдэх арга замыг хэлэлцлээ.
29	2005 оны 12-р сарын 14.	<b>ШАГНАЛ</b> Монгол Улсын Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ дагуу иргэддээ олгодог төрийн шагналын систем өнөөгийн нийгмийн үнэлэмжид нийцэхээ больж хоцрогдсоныг олон талаас хөндөн ярилцав.
30	2005 оны 12-р сарын 21.	<b>ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗ: АНХНЫ АЛХАМ</b> Олон Нийтийн Радио, Телевизийн тухай хууль хүчин төгөлдөр болсноос хойш өөрчлөлт ажиглагдахгүй, харин хувийн арилжааны телевизүүд илүү шинэлэг, санаачилгатай ажиллаж өрсөлдөөнд давж гараад байгааг анхааруулсан нэвтрүүлэг.



### "www.forum.mn" ПОРТАЛ САЙТ

Монгол дахь бодлого боловсруулах болон хэрэгжүүлэх үйл явц, бодлогын шийдвэрийн талаарх мэдээллээр олон нийтийг хангах, бодлогод хяналт тавих, үнэлэх зэрэг чиглэлд түлхүү анхаарах зорилттой "www.forum.mn" портал сайт нь 2005 онд өмнө нь эхлүүлсэн ажлыг үргэлжлүүлэхийн зэрэгцээ зарим нэг буланг шинээр үүсгэж мэдээлийн баазаа өргөжүүллээ. Ийм шинэлэг эхлэлийн нэг нь 2005 оны 11 дүгээр сараас ажлуулсан **"News headlines"** булан юм. Энэ нь тухайн өдрийн Монголын улстөр, эдийн засгийн онцлох үйл явдлын талаарх тойм мэдээллийг олон нийтэд хүргэх зорилготой бөгөөд өдөр тутмын сонин хэвлэлүүдийн мэдээлэлд үндэслэн өдөр бүр байнга шинэчилдэг. Өнгөрсөн хугацаанд нийт 40 орчим мэдээллийг монгол, англи хэлээр бэлтгэн толилуулсан нь портал сайтын олны анхаарлыг татсан чухал хэсэг боллоо.

2005 онд Монголын уул уурхайн салбарын хувьд ихээхэн онцлогтой жил болж өнгөрсөн. Энэхүү онцлогийг энэ салбарын хөгжлийн хурдацтай холбоотойгоор олон нийтийн үүсгэл санаачилгын үндсэн дээр орон нутгийн болон газар шорооны төлөөх иргэдийн хөдөлгөөнүүд олноор байгуулагдан нэгдэн нягтрах үйл явц өрнөсөнтэй холбон ойлгож болох юм. Чухам энэ үед бидний 2004 оны 12 дугаар сарын 20-нд эхлүүлсэн **"Уул уурхай ба хөгжил"** сэдэвт ажиглалт цаг үеийн чухал мэдээллийг нэг дороос үзэх боломжийг олгосноороо ач холбогдолтой боллоо. Улс орны хэмжээнд хөрөнгө оруулалтаар хамгийн өндөрт орж байгаа уул уурхайн салбарын Монгол Улсын хөгжилд оруулж буй төлөв байдалд ажиглалт хийж, мэдээллээр тогтмол баяжуулахыг эрмэлзсний үндсэн дээр тайлант хугацаанд тус салбарын талаарх судалгаа, тайлан үнэлгээ, томоохон төслүүд, тэдгээрт холбогдох гэрээ, баримт бичиг, хууль тогтоомж, хэрэгжилтийн тухай баримт, тогтмол мэдээлэл зэрэг 70 гаруй мэдээллийг цуглуулсан байна. Монгол Улсын Засгийн Газар, "Айвенхоу Майнз Лимитед" болон "Айвенхоу Майнз Монголия ИНК" ХХК-ийн хооронд байгуулах тогтвортой байдлын гэрээний төслийг Санхүү, Эдийн Засгийн Яамнаас боловсруулж Улсын Их Хурлын олонхийн бүлэгт танилцуулсантай холбогдуулан уг гэрээний төслийг сайтад тавьж, сар гаруй хугацаанд олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэхэд нийт 90 хүн санал бодлоо илэрхийлсэн байна.

Монгол Улс дахь жижиг, дунд бизнесийн салбарын мэдээллийг олон нийтэд хүргэхээр 2005 оны дөрөвдүгээр сараас эхлэн **"Жижиг, дунд бизнес"** сэдвийн дор ажиглалтын буланг мөн шинээр нээлээ. Одоогийн байдлаар холбогдох хууль тогтоомж, хандивлагчдын үйл ажиллагаа, энэ салбарын талаарх судалгаа, тайлан, үнэлгээ зэрэг 20 орчим мэдээллийг энд багцлан оруулаад байна.

2004 онд эхлүүлсэн бусад тогтмол ажиглалтыг мөн үргэлжлүүллээ. Тухайлбал, Улсын Их Хурлын болон Орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит **"Сонгуулийн ажиглалт"**-ыг

үргэлжлүүлэн явуулж, эдгээр сонгуулийн үр дүнд бий болсон улстөрийн нөхцөл байдал /Их эвслийн Засгийн газар байгуулагдсан/, шинэ парламентын өмнө тулгарч буй хүндрэл бэрхшээлүүд /сонгуулийн нэг субъект болох “Эх орон-Ардчилал” эвсэл задарсан зэрэг/, Эвслийн Засгийн газрын үйл ажиллагаа, мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх нийтдээ 110 гаруй мэдээ, мэдээллийг нийтэллээ. Мэдээллийг багцлахдаа намуудын амлалт Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хүрээнд хэрхэн хэрэгжиж буй байдлыг илүүтэй харгалзсан. Тэрчлэн бодлогын асуудлаар улстөрчдийн хэлсэн үг, байр суурийг харуулсан “Хэн юу хэлэв” буланг тогтмол ажиллуулав.

2005 оны тавдугаар сард болсон Ерөнхийлөгчийн сонгуулийн кампанит ажлын явцыг ажиглаж, үйл явдлыг дэлгэрэнгүй мэдээллээ.

**“Ерөнхийлөгчийн сонгууль-2005”** ажиглалтын хүрээнд сонгуульд нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрүүд, тэдгээрийг харьцуулсан тойм өгүүллийг сэтгүүлчид, мэргэжлийн хүмүүсээр бичүүлсний зэрэгцээ нэр дэвшигчдийн рейтингийн судалгаа, хэвлэл, мэдээллийн мониторинг, сонгуулийн кампанит ажлын явцын мэдээлэл, сонгуулийн үр дүн зэргийг тогтмол мэдээлэв. Нийт 140 орчим мэдээллийг олон нийтэд хүргэсэн байна.

Портал нь 2004 оноос эхлэн **“Төсвийн үйл явц”-ын** талаарх багц мэдээллүүдийг тогтмол толилуулдаг болсон. Тайлант хугацаанд 2005 оны улсын төсвийн тодотгол, тухайлбал, төсөв ерөнхийлөн захирагчдын зарлага, орлого, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, гадаад зээлийн ашиглалт, төлбөр зэрэгт холбогдох нийт 40 гаруй мэдээ, мэдээллийг түгээлээ. Тэрчлэн Монголд анх удаа 2004 оны улсын төсвийн гүйцэтгэл, болон Засгийн газрын жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит, 2006 оны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг бүрэн эхээр нь веб сайтад байрлуулж, олон нийтийн санал бодлыг нь хүлээн авч эхлэв. Монгол Улсын татварын тогтолцоог боловсронгуй болгох үүднээс татварын багц хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулахаар шинэчилсэн найруулгын төслийг бэлтгэж татвар төлөгчид болон бизнес эрхлэгчдээс санал авч буйтай холбогдуулан Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн төсөл, Онцгой албан татварын хуулийн төсөл, Хүн амын орлогын албан татварын хуулийн төсөл, Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн төсөл, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн төсөл зэрэг бичиг баримтыг сайтад байруулан санал авч эхэлсэн байна.

Монголын хөгжлийн талаарх олон янзын байр суурийг агуулсан дүн шинжилгээ бүхий өгүүллийг толилуулдаг **“Нийтлэл”** хэсэгт 2005 онд шинээр 50 өгүүлэл нэмэгджээ. Өмнөх онд улстөр, төсөв, мэдээллийн эрх чөлөөний тухай асуудлууд түлхүү тусгагдсныг харгалзан бусад сэдвийг тодорхой хэмжээгээр хөндөхийг зорьсны үр дүнд эдгээрээс гадна татвар, байгаль орчин, гадаад, дотоод бодлого, даяаршлын асуудлыг хөндсөн нийтлэлээр баяжсан бөгөөд эрдэмтэн судлаач, багш, сэтгүүлч, төрийн албан хаагч, улстөрч зэрэг давхардсан тоогоор

40 гаруй хүн нийтлэл, өгүүллээ нийлүүлжээ. 2005 онд “Орчуулгын нийтлэл” сэдвийн дор гадаадын нэр хүнд бүхий нийтлэлч, сэтгэгчдийн 14 гаруй бүтээлээс монгол хэлнээ хөрвүүлэн олны хүртээл болгов. Тухайлбал, Ромын хоёрдугаар хамба лам Ионн Паул, Френсис Фукуяама, Билдад Кагей, Марк Скаузен, Жорж Папендреу, Партха Дасгупта, Жеймс Гуартний, Роберт Манделл, Раи Човдури нарын нийтлэл, өгүүллийг монгол уншигчдад хүргэсэн байна.

**“Бодлогын асуудал”** буланд 2005 онд Татварын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслүүд, УИХ-ын сонгуулийн хуулийн төсөл, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн төсөл, Мэдээллийн технологийн тухай хуулийн төсөл, Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл, Ашгийн төлөө бус байгууллагын тухай хуулийн төсөл, Улстөрийн намын тухай хуулийн төсөл, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн төсөл, Ашигт малтмалын хуулийн шинэчилсэн найруулгын төсөл зэрэг баримт бичгүүд, тэдгээртэй холбоотой судалгаа, санал зөвлөмжийг багцлан толилуулсан байна. Тэрчлэн “Улстөрийн намуудын тухай” болон “Олон нийтийн радио, телевизийн тухай” хуулиудыг Монголын парламент хэрхэн хэлэлцэж баталсан талаарх мэдээ мэдээлэл, тойм өгүүллийг толилууллаа. Энэ буланд 2005 он гарсаар тайлант хугацаанд 40 гаруй мэдээллийг шинээр оруулсан бөгөөд эдгээр асуудлаар нийт 100 гаруй хүн санал бодлоо илэрхийлжээ.

2005 онд Монголын нийгэм, эдийн засгийн хөгжлийн сэдвээр донор байгууллагууд болон бусад судалгааны төвийн хийсэн 70 орчим шинэ судалгааг **“Эх сурвалж”** хэсэгт бүрэн эхээр нь pdf форматаар байрлуулав. Мөн бодлогын асуудлаар хэвлэгдэж буй ном товхимол, гарын авлагуудыг танилцуулжээ.

2005 онд манай сайтад нийт 180 гаруй мянган хүн, өдөрт дунджаар 500 орчим хүн нэвтэрч, 800 гаруй мэдээллээр порталын мэдээллийн сан арвижсан болно.

## БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

ННФ-ын Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр нь 2003 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд дотоодын бодлого судлаачдын хүчин чадлыг бэхжүүлэх, чанартай бодлогын шинжилгээ, судалгаагаар дамжуулан бодлого боловсруулагчид болон олон нийтэд мэдээлэл хүргэх, нөлөөлөх ажлыг эрчимжүүлэх зорилготой юм. Энэ хөтөлбөрт хамрагдах тухайн жилийн судалгааны сэдэв, шалгаруулалтад бүрдүүлэх материал, судлаачдад тавигдах ерөнхий шаардлага зэргийг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, өөрийн веб сайтаар дамжуулан 1- 1,5 сарын туршид зарлан мэдээлж, судлаачдыг ирүүлсэн материалын үнэлгээ, ярилцлага гэсэн хоёр үе шаттайгаар сонгон шалгаруулдаг. Хөтөлбөрт хамрагдсан судлаачдын судалгааны ажлын үр дүн, бодлогын зөвлөмжийг хэвлэн нийтэлж, уулзалт хэлэлцүүлгээр дамжуулан олны хүртээл болгож байна.

2005 онд Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрт нийт 50 гаруй судлаач хамрагдах хүсэлт ирүүлснээс зургаан судлаач шалгарч, 2005 оны тавдугаар сараас эхлэн дараахь судалгааг хийж гүйцэтгэж байна. Тухайлбал:

- Л. Золбаатар** “Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суурь боловсрол эзэмших боломж”,
- Г.Жаргал** “Орон нутгийн болон үндэсний татвар: Орон нутаг илүү бие даах боломжтой юу?”,
- О.Мөнхбат** “Төрийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдаж авах нь”,
- З.Батболд** “Зүүн Хойд Азийн зах зээл дэх Монголын стратегийн байр суурь”,
- Ч.Тамир** “Шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь: Эрхзүйн орчин болон институтчилэл”,
- Д.Дэлгэрцогт** “Засаг, захиргааны нэгжийн шинэтгэл ба төрийн хийгээд нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж”.

Хөтөлбөрийн хүрээнд бодлогын судалгаа, шинжилгээний аргагүй, бодлогын баримтыг бичиж боловсруулах аргачлал, нөлөөллийн үйл ажиллагааны стратеги гэсэн гурван сэдвээр сургалт зохиож, дотоод, гадаадын мэргэжилтнүүдийг зөвлөхөөр сонгон, судлаачидтай хамтран ажиллуулж байна. Судлаачид хөдөө орон нутагт судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг гүйцэтгэж, судалгааны дунд шатны үр дүнгээр олон нийтийн дунд хэлэлцүүлэг явуулж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр асуудал хөндсөн өгүүлүүд бичиж нийтлүүлдэг уламжлал тогтлоо. Дунджаар есөн сарын хугацаатай хэрэгжих эдгээр судалгаа нь 2006 оны гуравдугаар сард дуусах юм.

## ХЭВЛЭН НИЙТЛЭЛ

Нээлттэй Нийгэм Форумын үйл ажиллагааны нэг чухал хэсэг нь хэвлэн нийтлэл юм. Бодлого боловсруулах болон хэрэгжүүлэх явцад иргэд оролцох, хянах явцыг мэдээллээр хангахад хувь нэмэр оруулах зорилгоор бодлогын судалгаа шинжилгээний тайлан, иргэдэд зориулсан гарын авлага, номзүйн болон лавлагааны цуврал, орчуулгын ном зэргийг хэвлэн нийтэлж олны хүртээл болгож байна.

Шинээр хэвлэгдэн гарч буй ном товхимол нь хөдөө, орон нутгийн болон их, дээд сургуулийн номын сан, мэдээллийн болон судалгааны төв, ТББ, Засгийн газрын агентлаг, УИХ-ын гишүүд, донор байгууллагуудад түгээгдэж байна. Мөн Форумын хүрээнд зохиогдож буй олон нийтийн хэлэлцүүлэг, уулзалт ярилцлагын үеэр оролцогсдод тардаг болно.

### Үйл ажиллагаа үр дүн

Форумаас эрхлэн нийтдээ 57 нэрийн ном хэвлэснээс 27-г нь 2005 онд гаргажээ. Түүний дотор иргэдэд зориулсан гарын авлага, бодлогын судалгааны тайлан, номзүйн цуврал зэрэг номууд шинээр хэвлэгдэн гарсан байна.

### Иргэдэд зориулсан гарын авлага

- Хууль хэрхэн бүтдэг вэ (англи хэл дээр)
- Газрын харилцааны шинэтгэл (англи хэл дээр)
- Мэдээллийн эрх чөлөө
- Иргэн ба татвар (англи хэл дээр)
- Улсын төсвийн үйл явц
- Орон нутгийн төсвийн үйл явц
- Эдийн засаг, бизнесийн асуудлаар бичих нь – 1,2
- Хуульзүйн туслалцаа хэрхэн авах вэ
- Газрын тосны тухай бичихүй
- Та хотын хүн боллоо (шилжин суурьшигчдад зориулсан гарын авлага)
- Олборлох Салбарын Ил Тод Байдлын Санаачилга: Сурвалж бичиг

### Судалгааны тайлан

- Соёл, урлагийн салбарын хувьчлал (англи хэл дээр)
- Эрүүл мэндийн салбарын хувьчлал (англи хэл дээр)
- Боловсролын салбарын хувьчлал (англи хэл дээр)
- Мал аж ахуйд төр, засгийн үүрэг
- Хөгжлийн албан ёсны тусламж – хөдөөгийн хөгжилд
- Төрийн эрх мэдлийг урвуулан ашиглахын эсрэг авах арга хэмжээ
- Монгол Улсын газрын шинэтгэлийн асуудал
- Үндэсний ба нутгийн удирдлагын чиг үүргийн зохистой хуваарилалт
- Сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн мониторинг
- Монгол Улсын албан бус секторын хамрах хүрээ, төлөв байдал (англи, монгол хэл дээр)

**Лавлагаа, ном зүйн цуврал**

- Монгол дахь ядуурлын асуудалд холбогдох номзүй
- Монгол дахь авилгалын асуудалд холбогдох номзүй

Түүнчлэн Нээлттэй Нийгэм Форум Монсудар хэвлэлийн газартай хамтран орчуулгын төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд гадаад хэл дээр хэвлэгдэн гарсан нийгэм, эдийн засаг, улстөр, хөгжлийн сэдэвтэй дэлхий нийтээр уншиж байгаа зохиол бүтээлийг орчуулан нийтэлж уншигчдад хүргэхийг зорьж байна. Уг төслийн хүрээнд 11 ном сонгон орчуулж хэвлэхээр тохиролцсон ба одоогоор дараахь номууд хэвлэлтээс гарч уншигчдын гарт хүрчээ.



- Майкл Фейрбенкс, Стэйс Линдсей “Далайг хагалах нь: Эдийн засгийн хөгжлийн нуугдмал боломжийг ашиглах нь”
- Самуэл Хантингтон “Иргэншил хоорондын мөргөлдөөн, шинэчлэгдэн буй дэлхийн дэг журам”
- Дэвид Боаз “Либертарианизм”
- Айзек Азимов “Эхлэлийн эхлэл”
- Даниел Ж . Бурстин “Америк орон: Ардчиллын туршлага”
- Франсис Фукуяма “Төрийг байгуулах нь”
- Карл Поппер “Нээлттэй Нийгэм, түүний дайснууд”
- Жоорж Оруэлл “1984”

Орчуулгын төслийн хүрээнд хэвлэгдэн гарч байгаа номуудаас бизнесийн ашиг олохыг зориогүй ба орлогоороо зарлагаа нөхөж дараа дараагийн хэрэгцээ шаардлагатай номуудыг монгол хэлнээ орчуулан хэвлэх сан бий болгоход чиглэж буй юм. Иймээс уг ажил нь иргэдийн танин мэдэхүй, мэдлэг боловсролыг дээшлүүлэх, нийгмийн сэтгэлгээний цаашдын хөгжилд түлхэц өгч, дараа дараагийн ном орчуулагдан хэвлэгдэх эрэлт хэрэгцээг бий болно гэж үзэж байна.

## ХАВСРАЛТ

## САНХҮҮГИЙН ТАЙЛАН

<b>НИЙТ ЗАРЦУУЛАЛТ</b>			
\$ доллар			
Хөтөлбөр	Үйл ажиллагааны зардал	Бусад байгууллагад олгосон тэтгэлэг	Нийт зардал
<b>ЗАСАГЛАЛ</b>	<b>204,780</b>	<b>323,849</b>	<b>528,629</b>
Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө	37,314	47,493	84,807
Нээлттэй ил тод төсөв	11,970	1,451	13,421
Боловсролын салбарын төсвийн зарцуулалт	44,317 <sup>1</sup>	-	44,317
Сонгуулийн кампанит ажлын санхүүжилт	24,150	-	24,150
Төрийн үйлчилгээний мониторинг	20,985	131,641	152,626
Мэдээллийн эрх чөлөө ба иргэдийн оролцоо	2,890	6,676	9,566
Нутгийн болон төвлөрсөн удирдлага	8,933	14,290	23,223
Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж	11,832	5,580	17,412
Эрхзүйн туслалцаа	19,486	75,968	95,454
Төрийн бус байгууллагын эрхзүйн зохицуулалт	22,903	750	23,653
Боловсрол	-	40,000	40,000
<b>ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>	<b>132,761</b>	<b>56,546</b>	<b>189,307</b>
Эдийн засгийн эрх чөлөөний индекс	57,370	23,590	80,960
Сүүдэр эдийн засгийн үүрэг, роль	13,029 <sup>2</sup>	-	13,029
Уул уурхайн салбарын бодлогын асуудал	11,025	16,576	27,601
Газрын шинэтгэлийн хэрэгжилт	32,209	-	32,209
Хувийн хөрөнгө оруулалтын сан	12,397 <sup>3</sup>	-	12,397
Хөгжлийн бодлогын яриа хэлэлцүүлэг	6,731	16,380	23,111
<b>БУСАД</b>	<b>-</b>	<b>9,378</b>	<b>9,378</b>
Дорно дорно хөтөлбөр	-	9,378	9,378
<b>ФОРУМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЯВУУЛАХ АРГА ХЭРЭГСЭЛ</b>	<b>244,808</b>	<b>-</b>	<b>244,808</b>
Хөгжлийн мэдээллийн төв	35,013	-	35,013
Телевизийн хөтөлбөр	73,625	-	73,625
Портал сайт	49,755	-	49,755
Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр	47,778	-	47,778
Олон нийтийн хэлэлцүүлэг	28,963	-	28,963
Хэвлэн нийтлэл	9,674	-	9,674
<b>ЗАХИРГАА</b>	<b>285,090</b>	<b>-</b>	<b>285,090</b>
<b>НИЙТ ДҮН</b>	<b>867,439</b>	<b>389,773</b>	<b>1,257,212</b>

**Тайлбар тэмдэглэл:** <sup>1</sup> Дэлхийн банктэй хамтарч хэрэгжүүлсэн;

<sup>2,3</sup> АНУ-ын ОУХА-ийн санхүүжилттэй Эдийн засгийн бодлогын шинэчлэл, өрсөлдөх чадварын төсөлтэй хамтарч хэрэгжүүлсэн.

<b>ТЭТГЭЛГИЙН НИЙТ ЗАРЦУУЛАЛТ</b> (төрлөөр)						
\$ доллар						
<b>Хөтөлбөр</b>	<b>Нийт</b>		<b>Байгууллага</b>		<b>Хувь хүн</b>	
	<b>Тоо</b>	<b>Дүн</b>	<b>Тоо</b>	<b>Дүн</b>	<b>Тоо</b>	<b>Дүн</b>
<b>ЗАСАГЛАЛ</b>	<b>38</b>	<b>323,849</b>	<b>20</b>	<b>279,510</b>	<b>18</b>	<b>44,339</b>
Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө	5	47,493	2	41,135	3	6,358
Нээлттэй ил тод төсөв	1	1,451			1	1,451
Боловсролын салбарын төсвийн зарцуулалт						
Сонгуулийн кампанит ажлын санхүүжилт						
Төрийн үйлчилгээний мониторинг	15	131,641	15	131,641		
Мэдээллийн эрх чөлөө ба иргэдийн оролцоо	1	6,676			1	6,676
Нутгийн болон төвлөрсөн удирдлага	2	14,290			2	14,290
Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж	1	5,580			1	5,580
Эрхзүйн туслалцаа	11	75,968	2	66,734	9	9,234
Төрийн бус байгууллагын						
эрхзүйн зохицуулалт	1	750			1	750
Боловсрол		40,000	1	40,000		
<b>ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>	<b>9</b>	<b>56,546</b>	<b>3</b>	<b>30,154</b>	<b>6</b>	<b>26,392</b>
Эдийн засгийн эрх чөлөөний индекс	2	23,590	1	16,500	1	7,090
Сүүдэр эдийн засгийн үүрэг, роль						
Уул уурхайн салбарын бодлогын асуудал	5	16,576	1	5,654	4	10,922
Газрын шинэтгэлийн хэрэгжилт						
Хувийн хөрөнгө оруулалтын сан						
Хөгжлийн бодлогын яриа хэлэлцүүлэг	2	16,380	1	8,000	1	8,380
<b>БУСАД</b>	<b>8</b>	<b>9,378</b>				
Дорно дорно хөтөлбөр	8	9,378			8	9,378
<b>НИЙТ ДҮН</b>	<b>55</b>	<b>389,773</b>	<b>23</b>	<b>309,664</b>	<b>24</b>	<b>80,109</b>



<b>БАЙГУУЛЛАГАД ОЛГОСОН ТЭТГЭЛЭГ</b>		<b>\$ 309664</b>		
\$ доллар				
<b>Тэтгэлэг хүртэгсэд</b>	<b>Зорилго</b>	<b>Хугацаа</b>	<b>Нийт санхүүжилт</b>	
<b>ЗАСАГЛАЛ</b>				
<b>ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ</b>				
1	Глоб интернэшнл	Мэдлэг бол хүч	2005 оны VI.28-VII.5	<b>1,775</b>
2	Глоб интернэшнл	Үзэл бодлоо илэрхийлэх зөрчлийн мониторинг	2005 оны X.21- 2006 оны I.30	<b>39,360</b>
<b>ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МОНИТОРИНГ</b>				
3	Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо	Тусгай зөвшөөрлийн мониторинг	2005 оны XII 1- 2006 оны IV.30	<b>5,379</b>
4	Нийгмийн халамж - Хамтын ажиллагаа сан	Баянхонгор, Дорнод аймгууд дахь улсын асрамжийн газрын нөхцөл байдлын үнэлгээ	2005 оны XII.1- 2006 оны VI.30	<b>6,200</b>
5	Хүний Эрх Хөгжил Төв	Орон нутгийн шүүхийн үйл ажиллагаанд мониторинг хийх	2005 оны XII.1- 2006 оны VI.30	<b>7,310</b>
6	Хүний Эрх Шударга Ёсны Төлөө Хөдөлгөөн	Анхан шатны шүүх хуралдааны мониторинг	2005 оны XII.1- 2006 оны VI.30	<b>11,160</b>
7	Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөн	Төсвийн хүү торгуулийн орлогын бүрдүүлэлтийн мониторинг	2005 оны XII.1- 2006 оны VI.30	<b>13,300</b>
8	Нийгмийн Судалгааны Байгууллагуудын Хамтын Ажиллагааг Дэмжих Төв	Төрөөс иргэдэд газар өмчлүүлэх (эзэмшүүлэх ашиглуулах) үйлчилгээнд хийх мониторинг	2005 оны XII.1- 2006 оны V.30	<b>13,150</b>
9	Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөний Өвөрхөнгөй аймгийн салбар	Орон нутгийн төсөв дэх иргэдийн оролцоо	2005 оны XII.1- 2006 оны VI.30	<b>13,400</b>
10	Бэр цэцэг холбоо	Цэргийн дүрэмт хувцасны хангалтанд мониторинг	2005 оны XII.1- 2006 оны V.30	<b>5,341</b>
11	Монголын Хуульч Эмэгтэйчүүдийн Холбоо	Барилга байгууламж барих зорилгоор иргэр аж ахуйн нэгжид газар олгох төрийн үйлчилгээнд мониторинг хийх	2005 оны XII.1- 2006 оны VIII.30	<b>5,722</b>
12	Зориг сан	Гаалийн мониторинг	2005 оны XII.1- 2006 оны V.30	<b>10,220</b>
13	Монголын Тэргэнцэртэй Иргэдийг Дэмжих "Төмөр сан"	Нийгмийн халамжийн үйлчилгээнд мониторинг хийх	2005 оны XII.1- 2006 оны VI.30	<b>8,600</b>
14	Эмэгтэйчүүдийн Үндэсний Сүлжээний Багануур дахь Салбар	Газрын харилцаа ба иргэд	2005 оны XII.1- 2006 оны VIII.30	<b>8,900</b>
15	Монголын Эм Найруулагчдын Холбоо	Эм барих лицензийн олголт	2005 оны XII.1- 2006 оны V.30	<b>8,096</b>
16	Монголын Худалдаа Эд Хэрэглэгчийн Хоршооллын Төв Холбоо	Орон сууцны дэргэдэх хүүхдийн тоглоомын талбайн газар олголт, эзэмшлийн байдалд хийх мониторинг	2005 оны XII.1- 2006 оны ?.30	<b>6,715</b>
17	Монголын Тул Хамгаалах Нийгэмлэг	Байгаль орчныг хамгаалах сангийн үйл ажиллагаанд хийх мониторинг	2005 оны XII.1- 2006 оны VIII.30	<b>8,148</b>
<b>ЭРХЗҮЙН ТУСЛАЛЦАА</b>				
18	Хууль Зүй Дотоод Хэргийн Яам	ЗДТГ-ын хуулийн хэлтсийн эрх зүйн сургалт сурталчилгаа хариуцсан ажилтнуудын чадавхийг сайжруулах буюу Паралегал төсөл	2005 оны IX.5- 2006 оны XII.31	<b>50,827</b>
19	Хууль Зүй Дотоод Хэргийн Яам	Сонгинохайрхан дүүрэг болон Хэнтий аймаг дахь төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн тусалцаа үзүүлэх туршилтын үйл ажиллагаа	2003 оны XII.25- 2006 оны X.30	<b>15,907</b>
<b>БОЛОВСРОЛ</b>				
20	Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг	Үйл ажиллагааг дэмжих	2005 оны I.1-XII.30	<b>40,000</b>
<b>ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>				
<b>ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ИНДЕКС</b>				
21	МУИС-ийн Эдийн Засгийн Сургууль	Эдийн засгийн эрх чөлөөний тайлан	2005 оны XII.27- 2006 оны VI.10	<b>16,500</b>
<b>УУЛ УУРХАЙН САЛБАРЫН БОДЛОГЫН АСУУДАЛ</b>				
22	Онги Голынхон Хөдөлгөөн	Онги голынхон хөдөлгөөний үйл ажиллагааг дэмжих	2005 оны IX.1-2006 оны II.28	<b>5,654</b>
<b>ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЯРИА ХЭЛЭЛЦҮҮЛЭГ</b>				
23	МУИС-ийн Эдийн засгийн сургууль	Хөгжлийн бодлогын яриа хэлэлцүүлэг R.Mundell - Монгол дахь айлчлал	2005 оны V.2-VI.30	<b>8,000</b>

<b>ХУВЬ ХҮНД ОЛГОСОН ТЭТГЭЛЭГ</b>		<b>\$ 80109</b>			
\$ доллар					
<b>Тэтгэлэг хүртэгсэд</b>	<b>Байгууллага</b>	<b>Зорилго</b>	<b>Хугацаа</b>	<b>Нийт санхүүжилт</b>	
<b>ЗАСАГЛАЛ</b>					
<b>ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ</b>					
1	У. Дөлгөөн	Мэдээлэл харилцаа холбоо технологийн газар	Сараева хотод Хэвлэлийн эрх чөлөөний тухай олон улсын бага хурал	2005.V.11-13	<b>2,005</b>
2	Д.Зумбэрэлхам	Глоб интернэшнл	Сараева хотод Хэвлэлийн эрх чөлөөний тухай олон улсын бага хурал	2005.V.11-13	<b>2,005</b>
3	Д.Сарангэрэл	Монголын Чөлөөт Сэтгүүлчдийн холбоо	Люксембург хотод болсон AIPCE - ийн Их хурал	2005. IX.28-X.2	<b>2,348</b>
<b>НЭЭЛТТЭЙ ИЛ ТОД ТӨСӨВ</b>					
4	Р.Бурмаа	Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүдын Хөдөлгөөн	Казакстан улсад зохиогдсон төсвийн зарцуулалтын анализ ба төсвийн байгууллагуудын үйл ажиллагаа	2005.IV.19-20	<b>1,451</b>
<b>МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО</b>					
5	Ч.Тамир	МУИС	Шийдвэр гаргах төвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	2005.IX.1- 2006.III.1	<b>6,676</b>
<b>НУТГИЙН БОЛОН ТӨВЛӨРСӨН УДИРДЛАГА</b>					
6	Г.Жаргал	Удирдлагын Академи	Орон нутгийн эдийн засгийг бие даан хөгжүүлэх арга зам, боломж	2005.XI.15-2006.VII.15	<b>7,800</b>
7	Д.Дэлгэрцогт	Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн шинэчлэлт ба төрийн болон нийгмийн үйлчилгээний асуудал		<b>6,490</b>
<b>НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖ</b>					
8	Л.Золбаатар	ME зөвлөх компани	Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суурь боловсрол эзэмших боломж	2005.V.9-XII.9	<b>5,580</b>
<b>ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА</b>					
9	Ц.Цолмон	Хууль Зүй Дотоод Хэргийн Яам	Унгар улсад зохиогдсон Эрхзүйн туслалцааны хүртээмж бага хурал	2005.II.24-26	<b>916</b>
10	Ш.Солонго	Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар	Унгар улсад зохиогдсон Эрхзүйн туслалцааны хүртээмж бага хурал	2005.II.24-26	<b>916</b>
11	Л.Гарамжил	Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газар	Киргиз улсад зохиогдсон согтууруулах ундаа, хар тамхины эсрэг Атлантк бүсийн уулзалт	2005.V.9-12	<b>1,205</b>
12	Б.Даваасүрэн	Хууль Зүй Дотоод Хэргийн Яам	Киргиз улсад зохиогдсон согтууруулах ундаа, хар тамхины эсрэг Атлантк бүсийн уулзалт	2005.V.9-12	<b>1,205</b>
13	Ч.Лхамсүрэн	Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газар	Польш улсад зохиогдсон согтууруулах ундаа, хар тамхины эсрэг Атлантк бүсийн уулзалт	2005.VI.9-44	<b>1,107</b>
14	Б.Энхцогт	Архидалт мансуурлын эсрэг нийгэмлэгийн Өвөрхангай дахь салбар	Польш улсад зохиогдсон согтууруулах ундаа, хар тамхины эсрэг Атлантк бүсийн уулзалт	2005.VI.9-44	<b>1,107</b>
15	П.Эрдэнэцэцэг	Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын Харьяа 411 анги	Польш улсад зохиогдсон Хамгаалал ба хүчирхийлэл сэдэвт сургалт	2005.IX.16-20	<b>926</b>
16	С.Баасанбат	Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв	Польш улсад зохиогдсон Хамгаалал ба хүчирхийлэл сэдэвт сургалт	2005.IX.16-20	<b>926</b>
17	О.Пүрэвсүрэн	Албадан хөдөлмөр хийлгэх төсөл	Польш улсад зохиогдсон Хамгаалал ба хүчирхийлэл сэдэвт сургалт	2005.IX.16-20	<b>926</b>

<b>ХУВЬ ХҮНД ОЛГОСОН ТЭТГЭЛЭГ</b>		<b>\$ 80109</b>		
\$ доллар				
<b>Тэтгэлэг хүртэгсэд</b>	<b>Байгууллага</b>	<b>Зорилго</b>	<b>Хугацаа</b>	<b>Нийт санхүүжилт</b>
<b>ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ</b>				
18 Н.Чимэг	Шинжлэх Ухааны Академи	Израил улсад зохиогдсон Иргэний нийгэм дэх эмэгтэйчүүдийн манлайлал судалгааны курс	2005.II.7-III.3	<b>750</b>
<b>ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ИНДЕКС</b>				
19 О.Мөнхбат	МУИС	Төрийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тогтолцоог боловсронгуй болгох	2005.V.2-2006.I.3	<b>7,090</b>
<b>УУЛ УУРХАЙН САЛБАРЫН БОДЛОГЫН АСУУДАЛ</b>				
20 Г.Цогтсайхан	Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар	Киргиз улсын EITI салбарыг судлах	2005.X.23-29	<b>2,670</b>
21 Ц.Дамиран	УИХ	Киргиз улсын EITI салбарыг судлах	2005.X.23-29	<b>2,704</b>
22 Р.Бадамдамдин	УИХ	Киргиз улсын EITI салбарыг судлах	2005.X.23-29	<b>2,671</b>
23 Л.Дэлгэрдалай	Ашигт Малтмал Газрын Тосны Хэрэг Эрхлэх Газар	Киргиз улсын EITI салбарыг судлах	2005.X.23-29	<b>2,877</b>
<b>ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЯРИА ХЭЛЭЛЦҮҮЛЭГ</b>				
24 З.Батболд	Проспер компани	Монгол Улс Зүүн Хойд Азийн бүсчлэлийн хэрэгцээ, шаардлагад тээврийн дэд бүтцээ тохируулан хөгжүүлэх арга замууд	2005.VI.9-2006.II.9	<b>8,380</b>
<b>БУСАД</b>		<b>ДОРНО ДОРНО ХӨТӨЛБӨР</b>		
25 Б.Эрдэнэчулуун	Мэргэжлийн Хяналтын Газар	Украин улсад болсон Болосролын чанар ба хариуцлагын асуудал сургалт	2005.X.5-9	<b>912</b>
26 Д.Биндэрьяа	Боловсролын Үнэлгээний Газар	Украин улсад болсон Болосролын чанар ба хариуцлагын асуудал сургалт	2005.X.5-9	<b>912</b>
27 Б.Энхжин	Эрүүл Мэндийн Яам		2005.XI.1-2	<b>734</b>
28 Р.Банди	Боловсролын Яам	Литва улсад болсон Боловсролын бодлогын шилжилт ба боловсролын бодлогын төвүүд сургалт	2005.XI.11-12	<b>1,104</b>
29 Н.Энхтуяа	Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг	Литва улсад болсон Боловсролын бодлогын шилжилт ба боловсролын бодлогын төвүүд сургалт	2005.XI.11-12	<b>1,104</b>
30 М.Төрбаяр	Хууль Зүй, Дотоод Хэргийн Яам	Турк улсад болсон Иргэний нийгмийн хуулийн Форум	2005.XI.17-19	<b>1,810</b>
31 Р.Нарангэрэл	Иргэдийн боловсрол төв	Турк улсад болсон Иргэний нийгмийн хуулийн Форум	2005.XI.17-19	<b>1,810</b>
32 Л.Гантулга	Дундговь аймаг	Киев хотод Нээлттэй сүлжээний бодлого семинар	2006.II.20-25	<b>992</b>

**АЖИЛТНУУД****Нээлттэй Нийгэм Форумын Удирдах зөвлөл:**

Ж.Нарантуяа	<a href="mailto:narantuya@mail.parl.gov.mn">narantuya@mail.parl.gov.mn</a>
Д.Жаргалсайхан	<a href="mailto:djargal@yahoo.com">djargal@yahoo.com</a>
Саха Меяанатан	<a href="mailto:smeyanathan@worldbank.org">smeyanathan@worldbank.org</a>
Ц.Ариунаа	<a href="mailto:ariunaa@artscouncil.mn">ariunaa@artscouncil.mn</a>
П.Цэнгүүн	<a href="mailto:ptsenguun@altantaria.mn">ptsenguun@altantaria.mn</a>
Л.Төр-Од	<a href="mailto:turod@undp.org">turod@undp.org</a>

**Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал:**

<b>П.Эрдэнэжаргал</b>	<b><a href="mailto:jargal@soros.org.mn">jargal@soros.org.mn</a></b>
-----------------------	---

**Нээлттэй Нийгэм Форумын ажилтнууд:**

М.Амарбаяр	TV хөтөлбөрийн редактор	<a href="mailto:amarbayar@soros.org.mn">amarbayar@soros.org.mn</a>
Д.Аюуш	Нягтлан бодогч	<a href="mailto:ayush@soros.org.mn">ayush@soros.org.mn</a>
Р.Бадамрагчаа	ННФ-ын захирлын туслах	<a href="mailto:badmaa@soros.org.mn">badmaa@soros.org.mn</a>
Д.Балжид	Мэдээллийн менежер	<a href="mailto:baljid@soros.org.mn">baljid@soros.org.mn</a>
Т.Батбаатар	Веб мастер	<a href="mailto:batbaatar@soros.org.mn">batbaatar@soros.org.mn</a>
Ж.Баярцэцэг	ННФ-ын менежер	<a href="mailto:bayar@soros.org.mn">bayar@soros.org.mn</a>
Н.Дорждарь	ННФ-ын менежер	<a href="mailto:dorjdari@soros.org.mn">dorjdari@soros.org.mn</a>
Д.Гантуяа	Порталын ерөнхий редактор	<a href="mailto:gantuya@soros.org.mn">gantuya@soros.org.mn</a>
Ц.Ганболд	TV хөтөлбөрийн ерөнхий менежер	<a href="mailto:ganbold@soros.org.mn">ganbold@soros.org.mn</a>
Ш.Ганчимэг	Захиргааны туслах ажилтан	<a href="mailto:ganaa@osf.org.mn">ganaa@osf.org.mn</a>
А.Гэрэлмаа	ННФ-ын менежер	<a href="mailto:gerelmaa@soros.org.mn">gerelmaa@soros.org.mn</a>
Д.Жавхлан	Санхүүгийн захирал	<a href="mailto:javkhlan@soros.org.mn">javkhlan@soros.org.mn</a>
Б.Ичинхорлоо	ННФ-ын туслах ажилтан	<a href="mailto:ichka@soros.org.mn">ichka@soros.org.mn</a>
Б.Мөнхсоёл	ННФ-ын менежер	<a href="mailto:soyoloo@soros.org.mn">soyoloo@soros.org.mn</a>
Б.Нарантуяа	TV хөтөлбөрийн менежер	<a href="mailto:naraa@soros.org.mn">naraa@soros.org.mn</a>
Ш.Цог	Порталын англи хэлний редактор	<a href="mailto:tsog@soros.org.mn">tsog@soros.org.mn</a>
Д.Цэрэнжав	TV хөтөлбөрийн редактор	<a href="mailto:tseren@soros.org.mn">tseren@soros.org.mn</a>
Т.Цэцэгдарь	Мэдээллийн төвийн туслах ажилтан	<a href="mailto:daria@soros.org.mn">daria@soros.org.mn</a>
Д.Өлзийбадрах	Мэдээлэл сүлжээний зохицуулагч	<a href="mailto:ulzii@soros.org.mn">ulzii@soros.org.mn</a>
Т.Отгонбаяр	Захиргааны туслах ажилтан	<a href="mailto:reseption@soros.org.mn">reseption@soros.org.mn</a>
Ч.Саруул	Жолооч	<a href="mailto:saruul@soros.org.mn">saruul@soros.org.mn</a>
Б.Баатар	Жолооч	<a href="mailto:baatar@soros.org.mn">baatar@soros.org.mn</a>
Г.Цэдэвхүү	Жолооч	<a href="mailto:cedev@soros.org.mn">cedev@soros.org.mn</a>

**Байгууллагын имэйл:****[osf@soros.org.mn](mailto:osf@soros.org.mn)**



# НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

---

2005 оны жилийн тайлан

---

---

Жамьян гүний гудамж-5/1, Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар-48, Монгол Улс  
Утас: (976-11) 313207,  
Факс: (976-11) 324857  
Веб сайт: <http://www.forum.mn>

---

## Гарчиг

3	ӨМНӨТГӨЛ
4	ФОРУМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ: ЗАСАГЛАЛ
5	Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө
9	Нээлтэй ил тод төсөв
11	Сонгуулийн кампанит ажлын санхүүжилт
13	Төрийн үйлчилгээний мониторинг
15	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
16	Мэдээллийн эрх чөлөө ба иргэдийн оролцоо
18	Нутгийн болон төвлөрсөн удирдлага
20	Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж
22	Эрхзүйн туслалцаа
25	Төрийн бус байгууллагын эрхзүйн зохицуулалт
	ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО
27	Эдийн засгийн эрх чөлөөний индекс
29	Сүүдэр эдийн засгийн үүрэг, роль
31	Уул уурхайн салбарын бодлогын асуудал
32	Газрын шинэтгэлийн хэрэгжилт
36	Хувийн хөрөнгө оруулалтын сан
39	Хөгжлийн бодлогын яриа хэлэлцүүлэг
	БУСАД
41	Албадан ажил хийлгэх ялыг хэвшүүлэх төсөл
42	Дорно дорно хөтөлбөр
	ФОРУМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ:
43	Хөгжлийн мэдээллийн төв
45	Телевизийн хөтөлбөр
49	Портал сайт
52	Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр
53	Хэвлэн нийтлэл
	ХАВСРАЛТ
55	Санхүүгийн тайлан
60	Ажилтнууд

## ӨМНӨТГӨЛ

2005 он Монголын хувьд нийгэм, улстөр, эдийн засгийн төдийгүй нийгмийг доргиосон иргэдийн хөдөлгөөний идэвхжлийг өдөөсөн олон чухал үйл явдлаар дүүрэн жил байлаа.

Юуны өмнө дурдахад энэ онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль боллоо. Хэдийгээр Монгол Улс парламентын засаглалтай улс боловч ард түмний бүх нийтийн сонгуулиар Ерөнхийлөгчөө сонгодог учраас энэ сонгууль манай улсын улстөрийн амьдралд тун чухал үйл явдал болсон нь дамжиггүй юм.

2004 оны парламентын сонгуулиар Монголд анх удаа улстөрийн томоохон хүчнүүд тэнцвэртэй суудал авснаар их Эвслийн Засгийн газрыг байгуулсан билээ. Эвслийн Засгийн газар эрх барьсан жил гаруйн хугацаанд Монголын нийгэмд тулгарч ужгирсан олон чухал асуудлыг ил болгож, нээлттэй ярьж шийдэх түүхэн боломж бий болсныг тэмдэглэх хэрэгтэй юм. Тухайлбал, авилгал, хээл хахууль Монгол Улсын эдийн засгийн өсөлт, хөгжилтөд ноцтой хохирол учруулж байгааг төр, засгийн удирдах дээд төвшинд бодитой хүлээн зөвшөөрч авилгын эсрэг НҮБ-ын конвенцид нэгдэж Авилгатай тэмцэх хуулийг хэлэлцэж эхэлжээ.

АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Буш манай улсад анх удаа айлчилж, Монголын ардчиллыг өндрөөр үнэлэв. Чухам энэ онд арваад жилийн тэртээх ардчилсан хувьсгалыг санагдуулахуйц үйл явцын гараа нэгэнтээ эхэлжээ. Улаанбаатарын төв талбайд иргэний нийгмийн хөдөлгөөний төлөөлөгчид жагсаж, шар, нил ягаан, гүн ногоон өнгөөр тууз зүүн Монголд хувьсгал, өөрчлөлт шинэчлэлтийн шинэ давалгаа, түүнийг тээгч ард олны сэтгэлзүй бэлэн болсныг зарлав. Ардчилал олон нийтийн оролцоо, иргэний хөдөлгөөний идэвхжлээр дамжин гүнзгийрч байна.

Эрхзүйн шинэчлэлийн хоёр дахь давалгаа хүчээ авав. Өөрчлөгдөн байгаа Монголын нийгэмд өмнө цагт батлан мөрдүүлсэн олон хууль, эрхзүйн баримт бичгүүд шаардлага хангахаа больсныг харуулж эхэллээ. Ашигт малтмал, татвар болон авилгалын зэрэг чухал хуулиудын шинэ төслүүд өргөн баригдаж, олон нийт, хөдөлгөөн, улстөрийн хүчнүүд нэг ширээнд хамтран хэлэлцэх анхны боломж бүрджээ.

Эдийн засгийн шинэтгэлийн үр дүнгүүд мэдрэгдэж, Монголын эдийн засгийн өсөлт 2004 онд 10-иас илүү хувийг давсан бол 2005 онд 6,2 хувьд хүрлээ. Эдийн засгийн өсөлтийн шалтгааныг олборлох болон үйлчилгээний салбарын түлхүү хөгжил, өрсөлдөх чадварын шинэ нөхцөл байдалтай холбон дүгнэж буй бол бууралтыг тариалангийн ургац алдалт, нэхмэл оёмол бүтээгдэхүүнийг АНУ, Европын холбооны зах зээлд нийлүүлж байсан хөнгөлөлтийн нөхцөл цуцлагдсан зэрэгтэй эдүгээ холбон авч үзэж байгаа юм.

Монголын уул уурхайн салбар гадаадын хөрөнгө оруулалтыг эрчимтэй татаж эхлэв. Үүний хэрээр олон нийт, орон нутгийн ард иргэдийн зүгээс

байгаль орчин, татвар, улс орны хөгжлийн асуудлаар ярих, хэлэлцэх нь идэвхжиж ирлээ.

Хэвлэл, мэдээллийн салбарт шинэлэг үйл явдал элбэг тохиолоо. Нэн түрүүнд Монголын Үндэсний Радио, Телевизийг олон нийтийн болгох үйл явцыг энд дурдах хэрэгтэй юм. Олон арван жил төрийн мэдэлд байж олон нийтэд гэхээс илүү засаг, төрд илүүтэй үйлчилж байсан энэ байгууллагыг жинхэнэ олон нийтийн болгох шийдвэртэй алхмыг 2005 онд хийж чадлаа.

Энэ мэтчилэнгээр 2005 онд Монгол Улсад тохиосон олон чухал үйл явлууд, нэн чухал, суурь шинж чанартай шинэчлэлийн үйл явцад “Нээлттэй Нийгэм Форум” идэвхтэй байр суурьтай байж, тодорхой хувь нэмрийг оруулахыг зорьж ажиллалаа. Монголын нийгэмд өрнөсөн түүхэн үйл явцын дэлгэц дээр Нээлттэй Нийгэм Форумаас авч хэрэгжүүлсэн, санаачилсан, санхүүжүүлсэн, иргэний нийгмийн бусад байгууллагатай хамтран гүйцэтгэсэн арга хэмжээ, үйл ажиллагааны тайланг Та бүхэнд толилуулж буйдаа таатай байна.

**Нээлттэй Нийгэм Форумын  
Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал**



## ЗАСАГЛАЛ

### ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

Монгол Улс ардчилсан шинэтгэл эхлээд 15 жил болж байна. Энэ хугацаанд ардчилсан нийгмийн нэг гол үнэт зүйл болох чөлөөт хэвлэл, мэдээллийн үндэс суурь тавигдаж, хөгжлийн тодорхой шатанд хүрлээ. 1990 онд Монголд үндэсний ганц телевиз, радио, нэг намын харьяаллын өдөр тутмын нэг сонин, залуучууд, үйлдвэрчний эвлэл, зохиолчдын байгууллагын гэх тодотголтой долоо хоног тутмын цөөн хэвлэлтэй байсан бол эдүгээ Монголд өдөр тутмын долоон сонин /үүний нэг нь намын харьяалалтай/, 155 орчим чөлөөт сонин, 22 телевиз үйл ажиллагаа явуулж байна.



Хэдий тийм ч ард түмнийг тэнцвэртэй, шударга мэдээ мэдээллээр хангах хэвлэл мэдээллийн үндсэн үүрэг хангалтгүй биелж буйд Монголын олон нийт болон сэтгүүлчид өөрсдөө төдийлөн сэтгэл ханамжтай бус байгаа юм. Үүнд улстөр, нийгэм, эдийн засаг, бизнесийн олон хүчин зүйл нөлөөлж байдаг ч хамгийн гол шалтгааныг нь хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай ойлголт бүрэн төлөвшиж, түүний өөрийн зохицуулалтын механизмууд төгс хөгжиж чадахгүй байгаатай холбон авч үзэх нь түгээмэл байна. Иймээс Нээлттэй Нийгэм Форум байгуулагдсан цагаасаа эхлэн хэвлэл, мэдээллийн эрх чөлөөг дэмжих үйл явцад өөрийн анхаарлаа байнга чиглүүлэн ажиллаж эхэлсэн юм.

ННФ-ыг үндэслэгч Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн /Соросын сан/-гийн хэвлэл, мэдээллийн хөтөлбөрүүд энэ чиглэлд тодорхой үйл ажиллагаа явуулж байсныг дурдахгүй өнгөрч болохгүй. 2004 онд Монголын хувьд улстөрийн хоёр ч сонгууль болсонтой холбогдуулан ННФ "Сонгуулийн үеэр хэвлэл, мэдээллийн хэрэгслийн гүйцэтгэх үүрэг" төслийг хэрэгжүүлсэн бөгөөд улмаар 2005 оны гуравдугаар сараас эхлэн "Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө" төслийг хэрэгжүүлж эхлээд байна. ННФ энэ төслийн хүрээнд иргэний нийгмийн бусад байгууллагатай хамтран нөлөөллийн тодорхой үйл ажиллагааг тасралтгүй явуулж, Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл, Монголын Хэвлэлийн Хүрээлэн, Глоб Интернейшнл ТББ, АНУ-ын Бодлогын Хэлэлцүүлгийг Дэмжих Санаачилга, Лондон дахь Хэвлэл, Мэдээллийн Сүлжээ Хөтөлбөр зэрэг байгууллага болон хэвлэл, мэдээллийн бусад хэрэгсэлтэй хамтран ажиллалаа.

### Олон нийтийн радио, телевизийг дэмжих үйл явц

2005 оны нэгдүгээр сард Монголын парламент Олон нийтийн радио, телевизийн (ОНРТ) тухай хуулийг батлан гаргасан. Энэ бол Монголын ууган телевизийг төрийн өмчөөс олон нийтийн мэдэлд шилжүүлэх, Үндэсний радио, телевизийг олон нийтийнх болгох үндсийг тавьсан эрхзүйн чухал акт болсон юм. Энэхүү хуулийг батлуулахад ННФ багагүй хүчин чармайлт тавьж, анхнаас нь дэмжин ажилласан бөгөөд хуулийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүднээс ННФ нь төр, засгийн болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллалаа.

Юуны өмнө ОНРТ-ийн удирдах дээд байгууллага болох Үндэсний Зөвлөлийн 15 гишүүнд ТББ-уудын төлөөллийг нэр дэвшүүлэх үйл явцыг шударга, ил тод, өргөн хүрээнд явуулах үүднээс шат дараалсан арга хэмжээг Хэвлэлийн Хүрээлэн, бусад ТББ-тай хамтран зохион байгууллаа. Хуулийн дагуу шинээр зохион байгуулагдсан ОНРТ-ийн сэтгүүлчид, мэргэжилтнүүд, Үндэсний Зөвлөлийн гишүүд, иргэний нийгмийн төлөөлөгчдөд зориулан шинэ чиг үүргийн нь талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, олон улсын туршлагаас суралцах боломж олгох зорилгоор “Олон Нийтийн Радио, Телевизийн шилжилтийн үеийн тулгамдсан асуудлууд” сэдэвт олон улсын дугуй ширээний уулзалт ярилцлагыг ННХ-ийн Хэвлэл, Мэдээллийн Сүлжээ хөтөлбөртэй хамтран зохион байгуулав. Уулзалтад Польш, Эстони, АНУ, Румын, Английн экспертүүд оролцож, Монголын радио, телевизийн нэвтрүүлгийн бодлого, санхүүжилт, өөрийн удирдлага, бүтэц, зохион байгуулалтын талаар Монголын мэргэжилтнүүдийн тавьсан илтгэлүүдийг сонсч, харилцан ярилцаж тулгамдсан асуудлуудаар зөвлөгөө өгөв. Дугуй ширээний ярилцлагын үр дүнд ОНРТ-д шилжих цаашдын бодлого, үйл ажиллагааны тухай санал зөвлөмж гаргаж Үндэсний Зөвлөлд өргөн барьсан нь үйл ажиллагаагаа эхлэхэд нь тулгуурлах анхны суурь баримт бичиг болсон юм. ОНРТ-ийн шилжилтийн үйл явцыг дэмжих үйл ажиллагааг бид цаашид үргэлжлүүлэн явуулах болно.

#### “Олон нийтийн радио, телевиз. Шилжилтийн үеийн тулгамдсан асуудлууд” олон улсын дугуй ширээний ярилцлагад оролцогсдын зөвлөмжөөс

1. Үндэсний зөвлөл нь ОНРТ-ийн стратегийн баримт бичиг, журам дүрмийг үйл ажиллагааны төлөвлөгөөний хамт боловсруулах,
2. Зөвлөлийн хурлын тэмдэглэл болон бусад бүх бичиг баримт олон нийтэд ил тод байх бөгөөд өөрийн нөхцөлд тохирсон ёсзүйн зарчим батлах,
3. Санхүү, менежмент, хөтөлбөрийн асуудал эрхэлсэн дэд хороо байгуулах,
4. Засгийн газартай санхүүжилтийн удаан хугацааны гэрээ хийх, бизнес төлөвлөгөө боловсруулах,
5. ОНРТ-ийн ерөнхий захирал, дэд захирал болон бусад удирдах албан тушаалтныг томилохдоо нээлттэй, ил тод зарчим баримтлан сонгон шалгаруулах нь зүйтэй.

### **Хэвлэл, мэдээллийн өөрийн зохицуулалт**

Хэвлэл, мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийг бичиж нийтлүүлсэн зүйлийнхээ төлөө шүүхэд очихоос нь өмнө сэргийлэх, нөгөөтэйгүүр олон нийтийн санал гомдлыг барагдуулахад чиглэсэн бүтэц буюу өөрөө өөрийгөө зохицуулах механизм олон улсын пратикт маш өргөн хэрэглэгддэг. Монголд чөлөөт хэвлэл хөгжсөн 15 орчим жилийн туршлагаас харахад энэхүү бүтцийг бий болгох хэрэгцээ шаардлага улам өссөөр байна. 2004 онд 200 сэтгүүлчдийг хамарсан судалгаагаар 81 хувь нь Хэвлэлийн Зөвлөл хэрэгтэй гэж үзсэн бөгөөд ННФ ийм хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг тандах зорилгоор туршилтын төсөл



хэрэгжүүлээ. Сэтгүүлчдийн баримтлах ёсзүйн дүрмийн хэрэгжилтийг хянахад чиглэсэн Хэвлэлийн Зөвлөл байгуулах боломж, нөхцлүүдийг судлах ажлыг 2005 онд үргэлжлүүлж, олон улсын туршлагаас суралцах зэргээр Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлтэй хамтран ажиллалаа.

### **Сэтгүүлчдийн ур чадварыг дээшлүүлэх нь**

Хараат бус хэвлэл, мэдээллийг дэмжих нэг арга зам нь мэргэжлийн сэтгүүлчдийн ур чадварыг хөгжүүлэх явдал юм. 2005 онд эдийн засаг болон хөгжлийн асуудлуудын талаар бичдэг сэтгүүлчдийн дадлага, туршлагыг өргөжүүлэхэд түлхүү анхаарлаа. АНУ-ын Бодлогын Хэлэлцүүлгийг Дэмжих Санаачилга (БХДС буюу IPD) байгууллагатай хамтран сургалт семинар зохион байгуулав. Энэ сургалт нь хөгжлийн асуудлаарх мэдлэг, мэдээллийг түгээдэг олон улсын туршлагатай эдийн засагчид, сэтгүүлчидтэй Монголын сэтгүүлчдийг уулзуулан туршлага судлуулах, мэдээ, мэдээлэл, нийтлэлийн стратеги тоймлон гаргахад нь тус дөхөм болох зорилготой байв. Тэрчлэн Форум БХДС-тай хамтран эдийн засаг болон хөгжлийн асуудлаарх шилдэг цуврал нийтлэлийн уралдааныг сэтгүүлчдийн дунд зарлан явууллаа. Мөн эдийн засаг, бизнесийн чиглэлээр хэрхэн бичих талаар цуврал гарын авлагыг хэвлэн нийтлүүлэв. Энэ төсөл үргэлжлэн хэрэгжих юм.

### **Сэтгүүлчдийн эрх ашгийг хамгаалах нь**

Монголын сэтгүүлчид мэргэжлийн үүргээ гүйцэтгэх явцдаа олон саад бэрхшээлтэй учрахын сацуу үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхэд нь

элдэв хорио хязгаар тулгарсаар байна. 2004 онд улстөрийн сэдвээр мэдээ материал бэлтгэдэг 200 сэтгүүлчийн дунд явуулсан судалгаагаар “Монголд цагдан хяналт бодитой байдаг”, мөн “өөрийгөө хянадаг” гэж оролцогсад нь 100 хувь хүлээн зөвшөөрчээ. Хамгийн их буюу 29 хувь нь “миний эрх ашгийг хамгаалах байгууллага байхгүй”, 27,5 хувь нь “хууль, эрхзүйн орчин таатай бус учир шоронд орохоос айдаг”, 15,5 хувь нь “цагдаа, хүчний байгууллага, шүүхэд дуудагдахаас айдаг” гэжээ. Есөн хувь нь шийтгүүлэх, цалингаа хасуулах, ажлаас халагдахаас, долоон хувь нь эх сурвалжаа нотолж чадахгүйгээс айдаг гэж хариулсан байдаг. Freedom House-ийн судалгаагаар Монгол Улс 2005 онд хэвлэлийн бүрэн эрх чөлөөтэйгээс хагас эрх чөлөөтэй гэсэн ангилалд оржээ. Иймд цаашид сэтгүүлчдэд эрхийг нь таниулах, хуулийн мэдлэг олгож зөвлөгөө өгөх, эрх ашгийг нь хамгаалахын төлөө ажиллах зайлшгүй шаардлагатай байна. Энэ ажилд бодит хувь нэмэр үзүүлэх зорилгоор ННФ “Глоб Интернэшнл” ТББ-ын хэрэгжүүлж буй “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлийн мониторинг ба хараат бус хэвлэл, мэдээллийг дэмжих нь” төслийг Лондон дахь Хэвлэл, Мэдээллийн Сүлжээ Хөтөлбөртэй хамтран санхүүжүүлж байна.

12 сар үргэлжлэх энэ төслөөр Олон Улсын Үзэл Бодлоо Илэрхийлэх Эрх Чөлөөний Солилцоо (IFEX) болон Москвад төвтэй Хүнд Нөхцөл Байдалд буй Сэтгүүлчдийн Төв зэрэг байгууллагатай хамтран Монгол дахь үзэл бодлын чөлөөт илэрхийллийн хяналтын чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн харилцан уялдаатай хоёр үйл ажиллагаа явуулах юм. Одоогоор эрхзүйн туслалцааны асуудлаар сургалт явуулж эхлээд буй бөгөөд үзэл бодлын чөлөөт илэрхийллийн байдлын тухай мэдээг үндэсний болон олон улсын хэмжээнд түгээж байна. Мөн үзэл бодлын эрх чөлөөний зөрчлийг илрүүлж мэдээлдэг мониторингийн баг буюу Үндэсний сүлжээг байгуулан ажиллуулж байна.

## НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД ТӨСӨВ

Төсвийн үйл явцад иргэдийн оролцоо хангалтгүй байгаа нь тэдний төрд итгэх итгэлийг бууруулж, төрийн байгууллагуудын хариуцлага хүлээх явдлыг сулруулж байна. Нээлттэй Нийгэм Форум улсын болон орон нутгийн төсвийг нээлттэй, ил тод болгоход чиглэсэн үйл ажиллагааг 2005 онд хэрэгжүүлэхдээ төсвийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг иргэдэд хүргэхийн зэрэгцээ улсын төсвийн бүрдүүлэлт, зарцуулалтад төрийн бус байгууллагууд мониторинг хийх ажлыг дэмжихэд түлхүү анхаарч ажиллалаа.

Төсвийн мэдээллийг ил тод болгох үүднээс Засгийн газраас УИХ-д өргөн барьсан, эдийн засгийн салбар, төсөв ерөнхийлөн захиран зарцуулагч нэг бүрээр ангилсан 2006 оны төсвийн төсөл, 2006 оны төсвийн хүрээний мэдэгдлийг бүрэн эхээр нь вэб порталд тавин анх удаагаа өргөн олон нийтэд хүргэснээр төсөв төлөвлөлт, түүний нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх чиглэлтэй уялдсан байдалд иргэд өөрсдөө дүгнэлт хийх боломжийг бүрдүүллээ. Тэрчлэн төсвийн мэдээллийг ойлгох, төсвийн үйл явцад иргэд оролцоог хангах зорилгоор улсын болон орон нутгийн төсвийн төсвийн талаарх гарын авлагыг тус тусад нь боловсруулан гаргалаа.

Төсвийн үйл явцыг ил тод болгох эрмэлзэл бүхий дотоод, гадаадын байгууллагуудтай хамтран ажиллах үүднээс Казахстан улсад болсон төсвийн ил тод, нээлттэй байдлыг дэмжих бүсийн олон улсын уулзалтад УИХ-ын Төсвийн байнгын хорооны гишүүн, Сангийн яамны ажилтан, төрийн бус байгууллагын төлөөлөгчдөөс бүрдсэн баг оролцож, цаашдын хамтын ажиллагааны үндсийг тавив. Мөн АНУ-ын Олон Улсын Төсвийн Төсөл байгууллагатай хамтран ажиллаж, 2005-2006 онд дэлхийн 60 гаруй оронд хийгдэж буй "Нээлттэй төсвийн асуулга" судалгааны Монголын талаарх хэсгийг ННФ гүйцэтгэв. Энэхүү судалгааны 2004 оны асуулгаар Монгол Улс төсвийн ил тод, нээлттэй байдлын хувьд хамгийн доогуур байрт орж байсан бол одоо энэ үзүүлэлт бага зэрэг ахисан байдалтай байна. Судалгааны эцсийн дүн 2006 оны хоёрдугаар улиралд гарах юм.

Эдгээр үйл ажиллагааны дүнд иргэд төсвийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг авч ашиглах, төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавихад шаардлагатай суурь мэдээллээр тодорхой хэмжээгээр хангагдсан хэдий ч төрийн байгууллагууд мэдээллийг олон нийт ашиглаж болохуйц байдлаар тогтмол, дэлгэрэнгүй өгөх тал дээр ихээхэн чармайлт гаргах хэрэгтэй байна. Ялангуяа орон нутгийн болон төсвийн санхүүжилттэй агентлаг, аж ахуйн нэгжүүдийн хувьд дэлгэрэнгүй мэдээлэл тэр бүр байхгүй байгаа юм.

Иргэний нийгмийн байгууллагууд төсвийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих явдалд түлхэц өгөх үүднээс Нээлттэй Нийгэм Форум 2004 онд эхлүүлсэн "Боловсролын салбар дахь төсвийн зарцуулалтын судалгаа"-г энэ онд үргэлжлүүлэн гүйцэтгэлээ. Энэ нь иргэний нийгмийн

зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих, дүн шинжилгээ хийх хамгийн анхны иж бүрэн оролдлого болсон юм. Улсын нийт төсвөөс Монголын боловсролын салбарт зарцуулж буй хувь хэмжээ нь бусад улс оронтой харьцуулахад ихээхэн өндөр байгаа атал энэ салбарын төсөв хөрөнгийн зарцуулалтын үр ашгийн талаар өнөөг хүртэл нарийвчлан авч үзээгүй, мөн салбарын төсвийг зохицуулах хууль өөрчлөгдсөн нь уг судалгааг хийх зайлшгүй шаардлага болсон юм. Сургууль, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн болон төрийн төв байгууллага зэрэг тодорхой төвшнийг харьцуулан судалснаар бодлого боловсруулах үйл явцыг бодит баримт мэдээллээр хангахын зэрэгцээ боловсролын салбарын төсвийн төлөвлөлт, зарцуулалтад хяналт тавих олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилтыг тавьсан болно.

Төрийн үйл ажиллагаанд төрийн бус байгууллагын зүгээс хяналт тавих, мониторинг хийх явдлыг дэмжих үүднээс төсөл сонгон шалгаруулах уралдаан зарлаж төсвийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт хийх дөрвөн төслийг шалгаруулав. Үүнд, “Нийгмийн Дэвшил, Эмэгтэйчүүд” хөдөлгөөн төсвийн хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлтэд, уг хөдөлгөөний Өвөрхангай аймаг дахь салбар зөвлөл хоёр сумын төсвийн үйл явц, сахилга хариуцлагыг олон нийтийн оролцоотойгоор хянах, “Төмөр Сан” нийгмийн халамжийн үйлчилгээнд, “Тул Хамгаалах Нийгэмлэг” байгаль хамгаалах сангийн зарцуулалтад тус тус мониторинг хийхээр боллоо.

Дээрх үйл ажиллагааны үр дүнд төсвийн үйл явц дахь иргэдийн оролцоо болон энэ сэдвээр сонин хэвлэлээр ярилцах явдал нэмэгдэж байна. Гэхдээ иргэдийн оролцоог илүү үр дүнд хүргэхийн тулд цаашид төсвийн дүн шинжилгээ хийдэг судлаачдыг бэлтгэх, нарийн судалгаанд тулгуурласан ярилцлага, мэтгэлцээнийг өрнүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

## **БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ТӨСВИЙН СУДАЛГАА**

Нээлттэй Нийгэм Форум Дэлхийн Банктай хамтран энэ судалгааны аргазүйг боловсруулж сургуулийн байршил хэмжээг харгалзан 118 сургуулийг тохиолдлын түүврийн аргаар сонгож, мэдээллийг хоёр үе шаттайгаар цуглуулав.

Эхний үе шатанд сургуулийн захирал, сургалтын менежер, багш, эцэг эх, сурагч, нягтлан бодогч нарын 1500 хүнээс асуулга авсны үндсэн дээр 2004 оны санхүүгийн жилийн төсвийн зарцуулалтыг сургууль, аймаг, төвийн төвшинд харьцуулалт хийх зорилгоор тоон мэдээлэл цуглуулав. Хоёр дахь үе буюу 2005 оны 8 дугаар сард Булган, Говь-Алтай аймгийн сургууль, Боловсрол, соёлын газар, Төрийн сангийн төсвийн мэргэжилтнүүдтэй уулзаж, чанарын мэдээллийг нэгтгэлээ.

Мэдээлэлд анализ, шинжилгээ хийсний үндсэн дээр нийт найман бүлэг тайлан боловсруулж, Монголын боловсролын салбарын статистик, төсөв, санхүүгийн хүрээний шинэчлэлийн тойм, төсвийн төлөвлөлт ба удирдлага, сургуулийн зардал, багш нарын цалин, орлогын асуудал зэрэгт дүгнэлт хийж, бодлогын зөвлөмж боловсруулав. Дүгнэлтийг 2005 оны есдүгээр сард боловсролын салбарын мэргэжилтнүүд, бодлого боловсруулагчид болон тус салбарын мастер төлөвлөгөөг боловсруулж байгаа ажлын хэсэгт танилцуулав.

## СОНГУУЛИЙН КАМПАНИТ АЖЛЫН САНХҮҮЖИЛТ

Сонгуулийн кампанийн санхүүжилтийн авилгалыг бууруулах, тэгш нөхцөл бүхий шударга сонгуулийг дэмжих, эрхзүйн орчин, зохицуулалтын хүрээг боловсронгуй болгох замаар сонгуулийн ил тод байдлыг бий болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор Нээлттэй Нийгэм Форум сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн асуудалд онцгой анхаарал хандуулан ажиллаж байна. 2003 оноос эхлэн нөхцөл байдлын судалгаа хийж улмаар олон нийтийн болон ТВ-ийн хэлэлцүүлэг хийсэн бөгөөд 2004 оны УИХ-ын сонгуулийн үеэр “Сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн мониторинг”-ийг Сонгогчдын Боловсрол Төв болон “Глоб Интернэшнл” ТББ-тай хамтран Будапештэд төвтэй Нээлттэй Нийгмийн Эрхзүйн Санаачилга байгууллагын аргачлал, техникийн туслалцаатайгаар хэрэгжүүлсэн юм.

Монголын парламент 2005 онд УИХ-ын сонгуулийн хуулийг шинэчлэх асуудлыг хөндөж хуулийн төслийг боловсруулах шинэ ажлын хэсгийг байгуулсантай холбогдуулан ННФ өмнөх онуудад хийсэн судалгаа, мониторингийн үр дүн, зөвлөмжийг ажил хэрэг болгоход түлхүү анхаарч ажиллалаа. Нэн ялангуяа сонгуулийн кампанийн санхүүжилтийг зохицуулах асуудлыг УИХ-ын сонгуулийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах, тэрчлэн уг хууль нь ардчиллын баталгааны суурь болдгийн хувьд олон улсын стандарт туршлагаас хуваалцах, тусгайлан олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахад үйл ажиллагаагаа төвлөрүүлэв. Энэ зорилгоор Будапештэд төвтэй Нээлттэй Нийгмийн Эрхзүйн Санаачилга байгууллага болон Олон Улсын Ардчилал болон Сонгуулийн туслалцаа /IDEA/ зэрэг байгууллагатай хамтран ажиллалаа. Эдгээр байгууллагаас хуулийн төсөл дээр дэлгэрэнгүй санал зөвлөмж ирүүлснийг УИХ-ын гишүүдэд хүргэсний зэрэгцээ энэ байгууллагын зөвлөхүүд Сонгуулийн хуулийг боловсруулах УИХ-ын ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, УИХ-ын гишүүдэд зориулан хэлэлцүүлэг уулзалт зохион байгуулав.

Нээлттэй Нийгэм Форум УИХ-ын ажлын хэсэгтэй хамтран УИХ-ын сонгуулийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийг олон нийтэд танилцуулах, санал авах зорилгоор цуврал хэлэлцүүлгийг “УИХ-ын сонгуулийн тогтолцоо”, “УИХ-ын сонгуулийн жендерийн тэгш байдал”, “Сонгуулийн санхүүжилт, сурталчилгаа, хуульзүйн баталгаа”, “Сонгуулийн төв байгууллага” зэрэг сэдвээр зохион байгууллаа. Цуврал хэлэлцүүлэгт төрийн болон төрийн бус байгууллага, улстөрийн нам, судлаачид, хэвлэл мэдээллийн байгууллагын 150 гаруй төлөөлөгч оролцож, санал, бодлоо илэрхийлжээ. Санал зөвлөмжийг олон нийтэд болон бодлого боловсруулагчдад хүргэх үүднээс өдөр тутмын сонинд хэвлүүлж, УИХ-ын гишүүдэд албан ёсоор хүргүүлжээ. Түүнчлэн УИХ-ын сонгуулийн тухай хуулийн төслөөр цахим хэлэлцүүлэг зохион байгуулан [www.forum.mn](http://www.forum.mn) вебсайт дээрээ байрлуулав.

Улмаар УИХ-ын сонгуулийн хуулийг парламент 2005 оны 12 дугаар сард шинэчлэн батлав. Энэхүү хуулинд ННФ-аас 2004 онд хийлгэсэн мониторингийн гол дүгнэлт, зөвлөмжид тусгасан зарим асуудал шийдэгдсэн юм. Тухайлбал, сонгуулийн хандив болон зарцуулалтын дээд хязгаарыг тогтоосон бөгөөд сонгуулийн кампанит ажлын үеэр төрийн эх үүсвэрийг ашиглах зарим хэлбэрийг хориглосон байна. Төрийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн өмч хөрөнгийг сонгуулийн сурталчилгаанд аливаа хэлбэрээр ашиглах, төрийн жинхэнэ албан хаагчийг татан оролцуулах, сонгогчдын саналыг татах зорилгоор хүлээн авалт, цайллага зэрэг сонгуулийн бус олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахыг



хориглосон болно. Мониторингийн үеэр ажиглагдсан гол зөрчил болох намуудын төлбөртэй сурталчилгааг ОНРТ-ээр явуулахыг хориглож, арилжааны телевизээр явуулах төлбөртэй сурталчилгаа нь тухайн радио, телевизийн нэвтрүүлгийн нийт хугацааны 10 хувиас хэтрэхгүй байхаар хуульчилсан байна. Сурталчилгаа нь Сонгуулийн ерөнхий хорооноос батлагдсан эрх тэгш хуваарийн дагуу явагдахаар заажээ. Энэхүү хуулиас гадна Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийг мөн баталсан бөгөөд түүнд санхүүжилтийг зохицуулах холбогдох заалтууд орсон юм.

2005 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль боллоо. Энэ сонгуулийн үеэр ННФ сонгуулийн тухай мэдээллийг олон нийтэд хүргэх зорилгоор портал сайт дээрээ ажиглалт явуулсны зэрэгцээ сонгуулийн орой өөрийн байран дээр студи ажиллуулан сонгуулийн дүнг шууд олон нийтэд хүргэлээ. Энэ студийг "Транспаренси Интернэншл" байгууллагын Монголын салбартай хамтран ажиллуулж, Ийгл ТВ-ээр шууд нэвтрүүлэн хэвлэл мэдээлэл, ТББ-ын төлөөлөгчдөд танилцуулга, мэдээлэл хийсэн. Дээрхтэй ижил сонгуулийн студийг 2004 оны УИХ-ын сонгуулийн үеэр явуулж байлаа.



## ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МОНИТОРИНГ

Сүүлийн жилүүдэд Монголд авилгал улам бүр газар авч буй тухай ойлголт нийгмийн бүхий л төвшинд бүрдсэн байгаа нь судалгаагаар тод томруун харагдах боллоо. 1996 онд батлагдсан Авилгалын эсрэг хууль, 2002 онд батлагдсан Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт туйлын хангалтгүй байгаагийн зэрэгцээ авилгалын эсрэг болон хууль эрхзүйн орчныг сайжруулах талаар ихэвчлэн олон улсын байгууллагын дэмжлэг, нөлөөний үр дүнд Засгийн газар зарим нэг арга хэмжээг авч байгаа ч дорвитой үр дүн гарахгүй байна.

Нөгөөтэйгүүр Монголд иргэний нийгмийн чухал бүрэлдэхүүн хэсэг болох төрийн бус байгууллагуудын /ТББ/ тоо нэмэгдсэн хэдий ч тэдгээрийн үйл ажиллагаа голчлон иргэдийн боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгаанд чиглэж байна. ТББ-уудын нэг гол үүрэг болох төр, засгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих асуудал эхлэл төдий байна. Энэ нь ТББ-уудын энэ чиглэлийн чадавхи, нөөц бололцоо хязгаардлагдмал, төр, засгийн үйл ажиллагааны ил тод байдал хангалтгүй байгаатай холбоотой юм.

Иймээс ННФ төрөөс иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний ил тод байдлыг хангах, төрийн бус байгууллагуудын хөндлөнгийн хяналт тавих чадавхийг бэхжүүлэх зорилгоор 2005 онд төрийн үйлчилгээний мониторингийн тэтгэлэгт хөтөлбөрийг ТББ-уудын дунд зарлалаа. Төрийн үйлчилгээний мониторинг нь төрөөс үзүүлж байгаа тодорхой үйлчилгээний ил тод байдал, иргэдийн эрх зөрчигдөж буй байдал, хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар баримт мэдээлэл цуглуулах, хуулийн цоорхой бий эсэх талаар эрхзүйн орчинд анализ хийх, өөрчлөн сайжруулах талаар санал зөвлөмж боловсруулах нөлөөллийн цогц үйл ажиллагаа юм.

Тэтгэлэгт хөтөлбөрийг нээлттэй зарлаж сонгон шалгаруулахад нийтдээ 37 байгууллага төслийн саналаа ирүүлснээс тодорхой шалгуурт үндэслэн 15 төрийн бус байгууллагыг сонгож мониторингийн үйл ажиллагаанд тэтгэлэг олгов. Тухайлбал, Хуульч Эмэгтэйчүүдийн Холбоо аж ахуйн зориулалтаар барилга байгууламж барих иргэн, аж ахуйн нэгжид газар олгох төрийн үйлчилгээнд, Нийгмийн Судалгааны Байгууллагуудын Хамтын Ажиллагааг Дэмжих Төв иргэдэд газар өмчлүүлэх, эзэмшүүлэх төрийн үйлчилгээнд, Монголын Худалдаа, Эд Хэрэглэгчийн Хоршооны Төв Холбоо нийтийн орон сууцны дэргэдэх хүүхдийн тоглоомын талбайн газар олголтод, Зориг Сан нь гаалийн албадын үйл ажиллагаанд, Эмэгтэйчүүдийн Холбоо тусгай зөвшөөрөл олголтод, Монголын Эм Найруулагчдын Холбоо эм барих лиценз олголтод, Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүдийн Хөдөлгөөн төсвийн хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлтэд, Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүдийн Хөдөлгөөний Өвөрхангайн салбар нь орон нутгийн төсөвт, Бэр Цэцэг Холбоо цэргийн дүрэмт хувцасны хангалтад, Төмөр Сан нийгмийн халамж үйлчилгээнд, Монголын Тул Хамгаалах Нийгэмлэг байгаль хамгаалах санд, Хүний

Эрх, Шударга Ёс Хөдөлгөөн эрүүгийн анхан шатны шүүх хуралдааны үйл ажиллагаанд, Хүний Эрх, Хөгжил Төв орон нутгийн шүүхийн үйл ажиллагаанд тус тус мониторинг хийхээр болсон байна.

Энэхүү тэтгэлэгт хөтөлбөрийн өөр нэг гол зорилго нь ТББ-уудын мониторингийн чадавхийг дээшлүүлэх, аргачлалын ур чадварыг бэхжүүлэх явдал юм. ННФ мониторингийн удирдамж, сургалт, ашиглах эх сурвалж бүхий аргачлалыг боловсруулж цуврал сургалт зохион байгууллаа. Анхан шатны мониторингийн сургалтыг Чехийн “Транспаренси Интернэшнл” байгууллагын зөвлөх, хоёр дахь шатны сэдэвчилсэн аргачлалын сургалтыг Латвийн Провидус төвийн сургагч



багш нар явууллаа. Зөвлөх багш нар нь сургалтаас гадна байгууллага бүртэй ганцаарчилан уулзаж, мониторинг хийхэд тулгарч буй бэрхшээлийг хэрхэн шийдэх талаар практик зөвлөмж өгөв.

Мониторингийн тайлангууд 2006 онд гарч, нөлөөллийн үйл ажиллагаа хийгдэх юм. Цаашдаа ННФ энэхүү тэтгэлэгт хөтөлбөрийг жил бүр зарлан явуулах бөгөөд хамрах чиглэл, хүрээг улам өргөжүүлэн, тодорхой хуулийн хэрэгжилтэд мониторинг хийх болно.

Авилгалтай тэмцэх бодлогын шинэчлэл хийгдэх гэж буйтай холбогдуулан ННФ “Монгол дахь авилгалын асуудалд холбогдох номзүй”- г Зориг сантай хамтран боловсруулж хэвлэлээ. Энэ бол Монгол дахь авилгалын асуудалд холбогдох бүх эх сурвалжийг багтаасан анхны номзүй бөгөөд тухайн сэдвээр судалгаа хийдэг гадаад, дотоодын эрдэмтэн судлаачид, төрийн болоод төрийн бус байгууллагын ажилтнууд, бодлого боловсруулагчид, хандивлагчдад зориулагдсан юм.

## **ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГА**

Эдүгээ Монгол Улс нөөц баялаг ихтэй улс орны тоонд нэгэнтээ оржээ. Энэ хэрээр уул уурхайн салбарын Монголын эдийн засагт гүйцэтгэх үүрэг улам бүр өсөн нэмэгдэж байна. Гэхдээ нөөц баялаг ихтэй хөгжиж буй олон улс орон тухайн салбараас хэт хамааралтай болж, цөөн тооны эрх мэдэлтнүүд орлогыг өөрсдийн мэдэлд төвлөрүүлж авилга, хээл хахууль цэцэглэж, зүй зохисгүй зарцуулсан жишээ их бий. Улмаар “голланд өвчин” тусах буюу боловсруулах салбар уналтад орж, цаашлаад ардчилал, эдийн засаг нь хямралд орсон улс цөөнгүй. Ийм нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, уг салбарын тогтвортой өсөн дэвжих нөхцлийг хангах зайлшгүй чухал нэг хүчин зүйл бол олборлох салбарын орлогын ил тод байдлыг хангах явдал юм.

Монголд уул уурхайн үйлдвэрлэл хурдацтай өсөхийн хэрээр лицензийн наймаа, авилгал газар авсан тухай мэдээлэл нийгэмд хүчтэй тархаж буй нөхцөлд уг салбарын ил тод байдлыг сайжруулах нь онцгой ач холбогдолтой хэмээн үзэж ННФ энэ чиглэлд түлхүү анхаарал хандууллаа. Их Британийн Засгийн газраас санаачлан хэрэгжүүлж буй Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай санаачилгад (ОҮИТБС) Монгол Улс нэгдэн орох боломжийг судалж бэлтгэл ажлыг хангахад Форум тодорхой хүчин чармайлт гаргав.

Энэ зорилгоор “Төлснөө нийтэл” ТББ-уудын эвсэл, Орлогын Ажиглагч хөтөлбөр, Дэлхийн банк, ОҮИТБС-ын нарийн бичгийн дарга нарын газар зэрэг байгууллагатай хамтран уг санаачилгын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэсний зэрэгцээ төрийн бус байгууллагуудыг уг санаачилгад идэвхтэй оролцуулах эхлэлийг тавьсан болно. Түүнчлэн ОҮИТБС-ын сурвалж бичиг, “Сайхан ярианы цаана” судалгааг орчуулж хэвлүүлээ.

Уг санаачилга бусад улс оронд хэрхэн хэрэгжиж буй талаарх тодорхой мэдээллээр бодлого боловсруулагчдыг хангахын хамт Засгийн газрын холбогдох албадын төлөөлөл бүхий багийг Киргизстан Улсад туршлага судлахад дэмжлэг үзүүлэв.

Түүнчлэн олборлох салбарын орлогыг ил тод, оновчтой захиран зарцуулах боломжийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой Байгалийн нөөцийн менежментийн тухай хууль боловсруулах хэрэгцээ шаардлагыг судлах зорилгоор, тогтворжилт хөгжлийн сангийн талаар төрийн байгууллагын төлөөлөгчдөд зориулсан семинарыг Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газартай хамтран зохион байгууллаа.

## МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Сайн засаглал, төрийн ил тод, хариуцлагатай байдлын гол үндэс суурь нь иргэдийн мэдээлэл олж авах, хүртэх эрхийн баталгаа, түүний хэрэгжилт байдаг. Монгол Улсын Үндсэн Хуулинд мэдээлэл авах эрхийг хуульчлан заасан боловч баталгаажуулж зохицуулсан тусгай хууль байдаггүйгээс иргэдийн төр, засгийн мэдэлд буй мэдээллийг олж авах, хүртэх боломжийг хязгаарлаж байна. Иймээс ННФ 2003 оноос Мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулах талаар идэвхтэй ажиллаж, бусад улс орны туршлагаас суралцан холбогдох мэдлэг, мэдээлэл түгээж, харьцуулсан судалгаа хийлээ. “Мэдээллийн эрх чөлөөний тухай”



хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг 2005 онд Хууль зүй, Дотоод Хэргийн сайдын тушаалаар байгуулж, ХЗДХЯ болон бусад агентлагийн мэргэжилтнүүд, “Глоб Интернэшнл” ТББ, Нээлттэй Нийгэм Форум оролцон ажиллаж байна. Ажлын хэсэг ННФ болон “Глоб Интернэшнл” ТББ-аас боловсруулсан “Мэдээллийн эрх чөлөөний тухай” хуулийн төслийг улам боловсронгуй болгох талаар ажиллаж байна.

Хуулийн төсөлд иргэд бүх шатны төрийн захиргааны байгууллага болон нийтэд үйлчилдэг хувийн өмчийн хуулийн этгээдээс аливаа мэдээллийг бичгээр эсхүл амаар биечлэн хүсэлт гаргаж хүлээн авах эрхтэй. Уг хүсэлтэд төрийн байгууллага шууд хариу өгөх боломжтой бол зохих хариуг өгөх, боломжгүй бол хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногт багтаан заавал хариу өгөх тухай тусгаад байна. Түүнчлэн хүний амь нас, эрүүл мэнд, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах үндэслэл байвал хариуг 48 цагийн дотор өгөх, хэрвээ хариу өгөхгүй бол иргэд Хүний Эрхийн Комисс болон шүүхэд гомдол гаргах эрхтэй байхаар тусгасан юм. Төрийн байгууллага бүр иргэдийг мэдээллээр хангах үүрэг бүхий ажилтантай байх, мэдээллийн сан байгуулах, тухайн төрийн байгууллагаас авч болох мэдээллийн жагсаалтыг нийтэд мэдээлэх, гаргасан шийдвэр, мэдээллийг хэвлэн нийтэлж байх үүргийг нарийвчлан тусгажээ.

Хуулийн төслийг олон улсын нийтлэг жишигт нийцүүлэн боловсруулах зорилгоор олон улсын байгууллагуудтай нягт хамтран ажиллаж байна. Нью-Йоркт байрладаг Нээлттэй Нийгэм Хүрээлэн, “19-р зүйл” байгууллага болон “Access Europe” зэрэг байгууллагаас хуулийн төсөл

дээр дүн шинжилгээ хийлгэн, санал зөвлөмж авлаа. Эдгээр зөвлөмжид мэдээллийн нууцлалын хязгаарлалтыг бууруулах, мэдээллийн эрх чөлөөний талаарх гомдлыг шийдвэрлэх болон иргэдийн гэгээрэл, төрийн ажилтнуудын сургалт зэрэг чиг үүргийг хариуцсан Мэдээллийн комиссар бий болгох талаар судлан авч үзэхийг санал болгожээ. Мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулан хангахын нэг гол ач холбогдол нь хөгжлийн асуудалд, ялангуяа бодлого боловсруулах шатанд иргэдийн идэвхтэй оролцоог бий болгох явдал юм. Энэ асуудлыг ННФ 2005 оны бодлогын тэтгэлэгт хөтөлбөртөө тусгасны үндсэн дээр “Шийдвэр гаргах явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь: Эрхзүйн орчин болон институтчилэл” сэдвээр МУИС-ийн Социологийн тэнхмийн багш Ч.Тамир бодлогын судалгаа хийлээ. Иргэдийн оролцоог ерөнхийд нь ихээхэн ярьж, бичиж, тунхаглаж байгаа ч яг тухайлсан, нарийвчилсан судалгаа төдийлөн хийгдээгүй байгаа өнөөгийн нөхцөлд энэ судалгаа нь иргэдийн оролцооны байдал, эрхзүйн орчинг үнэлэхэд дүн шинжилгээ хийснээрээ чухал ач холбогдолтой боллоо. Тэрчлэн шийдвэр гаргах үйл явцыг улам бүр нээлттэй, ил тод, иргэдийн оролцоотой болгоход чиглэсэн эрхзүйн таатай орчин бүрэлдүүлэх, түүнийг хэрэгжүүлэх тодорхой арга зам, механизмыг бий болгох бодлогын зөвлөмжийг боловсруулан гаргасан юм. Энэхүү бодлогын судалгааны тайланг бодлого боловсруулагчид болон иргэний нийгмийн байгууллагуудад үйл ажилаагаанд нь мэдээллийн эх сурвалж болох үүднээс хүргэх юм.

### **ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦАД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ ТАЛААРХ БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ЗӨВЛӨМЖӨӨС**

Бодлого боловсруулах үйл явц дахь иргэдийн оролцоонд ажилгүйдэл, ядуурал, газарзүйн алслагдмал байдал зэрэг объектив хүчин зүйлээс гадна төрөө дээдлэх монголчуудын уламжлалт үзэл, иргэдийн улстөрийн соёл, төр, засгийн байгууллагын хаалттай байдал, хууль боловсруулах үйл явцын талаарх иргэдийн мэдлэг боловсрол хангалтгүй, хуучны төвлөрсөн сэтгэлгээний инерци хадгалагдсан зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байна.

Хууль тогтоомжийн хувьд иргэдийн оролцоог зохицуулсан гол хуулийн заалтууд нь давхацсан, ихэнхдээ тунхаг төдий, өөр хоорондоо уялдаа холбоо багатай байна. Иргэдийн оролцоог зохицуулсан хуулийн заалтад хэрэгжүүлэх механизмыг нарийвчлан заагаагүй учраас хэн, хэзээ, яаж, ямар санхүүжилтаар хэрэгжүүлэх нь тодорхойгүй, журам гаргахаар заасан ч тэр нь гараагүй, гарсан ч олон зүйлийг нарийвчлан тусгаагүй байна. Үүнийг дагаад хэрэгжих механизм нь бүрэлдээгүйн зэрэгцээ хэрэгжүүлэгч субъектууд нь ихэвчлэн өөрийн үзэмжээр шийдвэр гаргаж хэвшжээ.

Иймээс хоёр гол хууль болох Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд өргөдөл гомдол гаргах тухай хууль, Хууль, бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийг шинээр өөрчлөн найруулах шаардлагатай байна. Түүнчлэн хуулийг хэрэгжүүлэх институцийн хувьд УИХ-ын Тамгын Газар болон Байнгын Хорооны ажлын албыг олон нийттэй харилцах талаар өргөжүүлэн бэхжүүлэх, ажилтнуудыг чадавхижуулах шаардлагатай байна.

## НУТГИЙН БОЛОН ТӨВЛӨРСӨН УДИРДЛАГА

Монгол Улсад социалист систем нуран унаснаас хойш төвлөрлийг сааруулах үйл явц эрчимтэй явагдаж байна. Энэхүү үйл явц нь дан ганц төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжихээс гадна, төрийн зорилго, чиг үүрэг, улстөр, захиргааны тогтолцоог ч мөн адил хамаарч байгаа юм. Эдийн засгийн төвлөрлийг сааруулах үйл ажиллагаа 1990-ээд оны эхэн үеэс улсын өмчийн орон сууц, мал, үйлдвэр аж ахуйн газрыг хувьчилсанаар эхэлсэн. Өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд хийгдсэн төрийн захиргааны шинэчлэл, төвлөрлийг сааруулах үйл явцаас харахад энэ нь угтаа



социализмын үед байсан төвөөс бүгдийг хянаж төлөвлөдөг тогтолцоог агуулгын хувьд өнөөг хүртэл хадгалж иржээ. Тухайлбал, орон нутгийн засаг захиргааны нэгжүүд нь төсвийн хувьд төвөөс бүрэн хамааралтай, төрийн албаны тогтолцоо нь төвлөрсөн, боловсон хүчнийг томилох, удирдах асуудал дээр орон нутгийн эрх мэдэл ихээхэн хязгаарлагдмал байна.

Цаашид төвлөрлийг сааруулах бодлогод ямар өөрчлөлт оруулбал зохих, төв ба орон нутгийн засаглал хоорондын эрх мэдэл, чиг үүргийн тэнцвэрийг хэрхэн хангах тухай асуудалд Нээлттэй Нийгэм Форум онцгой анхаарал хандуулж бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийнхөө хүрээнд “Үндэсний ба нутгийн удирдлагын чиг үүргийн зохистой хуваарилалт” сэдэвт судалгааны ажлыг хийлгэлээ. Судалгааны ажлыг 2004 онд эхлүүлж, 2005 онд түүний үндсэн үр дүн гарч олон нийтэд танилцууллаа. Монгол Улсын төв Засгийн газар болон орон нутгийн удирдлагын үүрэг, эрх мэдлийн хуваарилалт, төсвийн харилцааны өнөөгийн нөхцөл байдал, бэрхшээлийг тодорхойлж, тэдгээрийг олон улсын нийтлэг хандлагын дагуу өөрчлөх боломжийн талаар зөвлөмж боловсруулсан юм. Энэ бол тухайн чиглэлээр анх удаа хийгдсэн бодлогын судалгаа бөгөөд нутгийн удирдлагын ерөнхий тогтолцооных нь хувьд боловсролын үйлчилгээг түлхүү авч үзсэн байна.

## **ТӨРИЙН БА НУТГИЙН УДИРДЛАГА ХООРОНДЫН ЗОХИСТОЙ ТЭНЦВЭРИЙГ ХАНГАХ АСУУДЛААРХ БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖӨӨС**

Зөвлөмж болгоход төрийн болон нутгийн удирдлага хоорондын эрх мэдэл, үйлчилгээний чиг үүргийн болон орлогын хуваарилалтын хүрээнд тодорхой шинэчлэл хийх шаардлагатай байна. Тухайлбал:

### **Төрийн болон нутгийн удирдлага хоорондын эрх мэдэл, үйлчилгээний чиг үүргийн хуваарилалт:**

- Орлогын хуваарилалтын хариуцлагыг Засгийн газар, үйлчилгээний нийлүүлэлтэд орон нутгийн удирдлага хариуцлага хүлээдэг байх зарчмаар ажиллах нь зүйтэй.
- Засаг даргын албан тушаалыг улстөрийн бус захиргааны статустай болгож орон нутаг дахь захиргааны менежерийн үүргийг хэрэгжүүлдэг болгох хувилбарыг санал болгож байна.
- Ингэснээр Засаг дарга дөрвөн жил тутам сонгуулиар солигддог байдал өөрчлөгдөж, ажлын үр дүнгээс хамааруулан удаан ажиллуулах боломж бүрдэнэ.
- Газарзүйн хувьд ойролцоо олон сумыг нэгтгэж захиргааны болон үйлчилгээний давхар зардлыг хэмнэх шаардлагатай гэх зэрэг.

### **Төрийн болон нутгийн удирдлага хоорондын орлогын хуваарилалт:**

- Орон нутгийн төвшинд орлого олох санаачилгыг бий болгох,
- Орон нутгийг санхүүгийн хувьд бие даалгаж, өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллуулах,
- Бүх төвшний төсвийн байгууллагуудын тоог багасгаж, зарлагын үр ашигтай тогтолцоог бий болгох,
- Орон нутгийн өмчийн ашиглалтыг сайжруулах, ялангуяа газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах явдлыг түргэтгэх,
- Засгийн газраас орон нутагт олгож буй санхүүгийн тусламж, дэмжлэгийг тодорхой шалгуураар үнэлэн олгож байх нь зүйтэй байна.

## НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖ

Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг үнэлэн дүгнэх судалгаа, шинжилгээ туйлын хомс байгаа нь эдгээр үйлчилгээний чанарыг сайжруулах талаар олон нийтийн зүгээс хүчтэй шахалт, шаардлага гарахгүй байх үндсэн нөхцөл болж байна гэж үзэж, нөхцөл байдлыг тодруулж бодлогын хувилбаруудыг боловсруулан нийтийн хүртээл болгох үүднээс 2005 онд Нээлттэй Нийгэм Форум нийгмийн үйлчилгээний асуудлаар хоёр судалгааг хийж гүйцэтгэлээ.



Юуны өмнө Улаанбаатар хотын Сонгино-Хайрхан дүүргийн хүн амзүй, нийгмийн үйлчилгээнд хувь судлаачдаар судалгаа хийлгэсэн болно. Хөдөөнөөс хот руу шилжин суурьшигчид тус дүүрэгт олноор төвлөрснөөс хүн амын бүтэц нь нэлээд өөрчлөгдсөн тул энэ дүүргийг сонгон авч хүн амын амьдралын нөхцөл, төрийн болон нийгмийн үйлчилгээнд хамрагдаж буй байдал, боломжийг судаллаа. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тодорхой нэгжийн ерөнхий нөхцөл байдал, тулгарч буй салбарын шинжтэй асуудлуудыг тодорхойлсонд судалгааны гол ач холбогдол оршино. Судалгаагаар орон сууц, гэр хороолол хосолсон бүтэцтэй хороонуудын төрийн болон нийгмийн үйлчилгээний байгууллагууд, Засаг даргын Тамгын газар, хөдөлмөр, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн ажилтнууд, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн улирдлагаас өргөн хүрээтэй мэдээлэл цуглуулан дүгнэлт хийж тодорхой зөвлөмж боловсрууллаа.

Судалгаанаас үзэхэд Сонгинохайрхан дүүргийн иргэдийн тав орчим хувь нь албан ёсны бүртгэлгүй байгаагаас сургууль, цэцэрлэг, эмнэлгийн үйлчилгээг хүртэж чадахгүй байна. Хорооны ажилтнуудын ажлын уялдаа холбоо сулаас болж бүртгэл, мэдээлэл олдохгүй байх нь элбэг тохиолджээ. Хүн амын өсөлттэй холбоотойгоор сургууль, цэцэрлэг, эмнэлгийн байгууллагууд ачааллаа даахаа больж, сургууль л гэхэд анх төсөвлөгдсөн хүчин чадлаасаа хоёр дахин илүү ачаалалтай ажиллаж байна. Ядуурал, ажилгүйдлийн улмаас хүүхдээ сургууль, цэцэрлэгт хамруулахгүй байх тохиолдол ихэсчээ. Эмнэлгийн хүчин чадлыг төлөвлөхдөө төлбөртэй үйлчилгээ явуулдаг хувийн эмнэлгүүдийн орны тоог оролцуулан тооцдог тул улсын эмнэлгийн



ачааллыг бодитойгоор тооцсон төлөвлөлт хийгддэггүй ажээ. Ажилгүйчүүдийн ихэнх нь дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлээгүй, бүртгүүлэхийн ач холбогдлыг ч мэдэхгүй, итгэдэггүй болох нь харагджээ. Иргэдийн санааг зовоож байгаа өөр нэг асуудал бол аюулгүй амьдрах орчин хангагдаагүй, шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагын хамгаалалтыг авах боломж муу байгаа явдал юм. Мөн чөлөөт цагаа өнгөрөөх соёл, амралтын ямар нэг орчин, байгууллага байхгүйд иргэд сэтгэл дундуур байгаа нь судалгаанаас харагдлаа.



Нээлттэй Нийгэм Форумын Бодлогын Судалгааны Тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд "ME Consulting"-ийн судлаач Л.Золбаатар "Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суурь боловсрол эзэмших боломж" сэдэвт судалгааг 2005 онд хийлээ. Уг судалгаагаар хот хөдөөгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суурь боловсрол үнэ төлбөргүй заавал эзэмших эрх хэрхэн биелж буйг судлахад энэ нь нэн хязгаарлагдмал төдийгүй нийгмийн халамжийн хуулиар олгогдох ёстой тэтгэмж, нэмэлт үйлчилгээ хүртэх боломж нь тухайн хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн төрлөөр бус, харин өрхийн амьжиргааны төвшингөөр тодорхойлогдож байгаа нь учир дутагдалтай байна. Тэрчлэн хөдөө орон нутагт сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан эмнэлэг, оношилгоо, тусгай боловсролын үйлчилгээ бараг байхгүй, ерөнхий боловсролын багш нарт тусгай боловсролын чиглэлээр ажиллах мэдлэг, арга барил олгодоггүй байна. Хэдийгээр багш нар, сургуулийн удирдлагын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ялгаварлан гадуурхах тохиолдол бага байгаа ч өнөө үйлчилж буй дүрэм, журмын дагуу багшийн хөдөлмөрийн үнэлгээний нэлээд хэсгийг сурагчдын сурлагын үзүүлэлтээр хэмжин тогтоодог нь хөгжлийн бэрхшээлтэй, ялангуяа сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ангидаа авч сургахад тодорхой саад болдог гэж үзэх үндэслэлтэй байна. Уг судалгааны дүгнэлт, бодлогын зөвлөмжийг 2006 оны эхээр олон нийт болон бодлого боловсруулагчдад танилцуулан хэлэлцүүлэхээр бэлтгэж байгаа болно.

## ЭРХЗҮЙН ТУСЛАЛЦАА

Монголын хүн амын дунд ядуу иргэдийн эзлэх хувь өндөр, улмаар тэдгээр хүмүүс гэмт хэрэгт холбогдсон үед өмгөөлөгч авах боломж хомс байгаа тул төлбөрийн чадваргүй иргэдэд эрхзүйн туслалцаа үзүүлэх нь хүний эрхийг хангахад чухал үүрэгтэй юм. Хуулийн хэрэгжилт, туслалцаа үзүүлэх ажлын уялдаа сул, санхүүжилт хомс зэрэг олон шалтгаанаас үүдэн энэ нь нэн тулгамдсан асуудал болж байна. Иймээс төлбөрийн чадваргүй иргэдэд эрхзүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийг боловсруулахад Нээлттэй Нийгэм Форум дэмжлэг үзүүлж, ХЗДХЯ болон Будапештэд төвтэй “Нээлттэй Нийгмийн Эрхзүйн Санаачилга” байгууллагатай хамтран “Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх эрхзүйн туслалцаа” төслийг хэрэгжүүлж байна.

### Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх эрхзүйн туслалцаа

Энэ төслийн хүрээнд нийгмийн ядуу хэсэгт үзүүлэх эрхзүйн туслалцааны тогтолцоог боловсронгуй болгох, үндэсний тогтолцоог шинэчлэх санал боловсруулах Ажлын хэсгийг ХЗДХЯ-наас байгуулсан ба “Төлбөрийн чадваргүй иргэдэд эрхзүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн төслийг боловсруулан Засгийн Газраар батлуулах гэж байна. Хөтөлбөрийг боловсруулж буйтай холбогдуулан Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газрын болон ХЗДХЯ-ны төлөөлөгчид ННФ-ын дэмжлэгтэйгээр Унгар улсын Будапешт хотноо зохиогдсон “Эрхзүйн туслалцаа” олон улсын хуралд оролцон бусад улсын ололт амжилт, сургамжаас суралцлаа.

Сонгинохайрхан дүүрэг болон Хэнтий аймаг дахь төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн туслалцаа үзүүлэх туршилтын төвийг үргэлжлүүлэн ажиллуулж, тухайн дүүрэг болон аймгийн шүүхийн нийт шийдвэрлэж буй эрүүгийн хэргийн 97 гаруй хувийг өмгөөлсөн байна. Төвүүд нь тухайн дүүрэг, аймгийн цагдаа, шүүхтэй хамтын ажиллагааны журмын үндсэн хамтран ажилладаг. Энэхүү журмын дагуу аливаа сэжигтэн, яллагдагч нь төлбөрийн чадваргүй бол мөрдөн байцаах ажиллагаа эхлэхээс өмнө төвд мэдэгдэн өмгөөлөгч авдаг. Ингэснээр мөрдөн байцаах, шүүх үйл ажиллагаа өмгөөлөгчгүйгээс болж саатдаг, хугацаа алддаг байдал буурчээ.

Эрхзүйн туслалцаа төслийн хүрээнд иргэдэд зориулсан цуврал хөтөчийн нэг болох “Хуульзүйн туслалцаа хэрхэн авах вэ?” гарын авлагыг МУИС-ийн Хуульзүйн Дээд Сургуулийн “Хүмүүнлэг” хуульзүйн клиниктэй хамтран бэлтгэн гаргалаа. Гарын авлага нь өмгөөллийн үйлчилгээний асуудлаар иргэдэд чухал шаардлагатай мэдээллийг хялбаршуулсан хэлбэрээр хүргэж, төлбөрийн чадваргүй иргэдэд үйлчилгээ үзүүлэх боломжтой өмгөөлөгчдийн жагсаалт, эрхзүйн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын лавлагаа танилцуулгыг багтаасанаараа ач холбогдолтой юм.

### **Эрхзүйн мэдээлэл, үйлчилгээг орон нутагт нэвтрүүлэх нь**

ННФ орон нутаг дахь эрхзүйн боловсрол, мэдээлэл, зөвлөгөө лавлагааны тогтолцоог боловсронгуй болгох үүднээс “Эрхзүйн мэдээлэл, үйлчилгээг орон нутагт нэвтрүүлэх нь” төслийг ХЗДХЯ-тай хамтран 2005 оноос эхлэн хэрэгжүүлж эхэллээ. Төслийн хүлээж буй үр дүн нь анхан шатны эрхзүйн зөвлөгөө, боловсролыг төрийн үйлчилгээ болгон хэвшүүлж нутгийн удирдлагад институтчилэн бэхжүүлэх, улмаар хөдөө орон нутгийн иргэдийн эрхзүйн туслалцаа, иргэдийн эрхзүйн боловсролын төвшинг нэмэгдүүлэх явдал юм.

Эрхзүйн албан бус боловсрол, анхан шатны зөвлөгөөний аргачлал, стандартыг боловсруулан хэрэгжүүлэх, энэхүү үйлчилгээг явуулах төрийн албан хаагчдын чадавхийг сайжруулах зорилгоор аймаг дүүргийн Засаг Дарга, түүний Тамгын Газрын хуулийн ажилтнуудад зориулсан гарын авлага болон иргэдэд зориулсан анхан шатны хялбаршуулсан гарын авлагуудыг өдөр тутмын амьдралд тулгардаг дараахь сэдвээр бэлтгэн боловсрууллаа. Үүнд:

1. Монголын хууль тогтоомж ба эрхзүйн тогтолцоо
2. Эрхзүйн мэдээлэл, зөвлөгөө өгөх, сургалт явуулах чадвар
3. Альтернатив аргаар маргааныг шийдвэрлэх
4. Гэр бүлийн эрхзүй /гэр бүлийн хүчирхийлэл/
5. Эрүүгийн эрхзүй
6. Хөдөлмөрийн эрхзүй
7. Нийгмийн халамжийн эрхзүй
8. Иргэний эрхзүй
9. Захиргааны эрхзүй
10. Татварын эрхзүй
11. Газрын эрхзүй
12. Бизнесийн эрхзүй зэрэг ном багтаж байна.

Гадаадын зөвлөхүүдтэй хамтран эдгээр гарын авлагыг боловсруулахдаа шинэлэг аргазүй, аргачлалыг тусгасны зэрэгцээ гарын авлагын зохиогч нарт зориулан хоёр удаа сургалт зохион байгуулав.

Төсөл цаашид үргэлжлэх бөгөөд үр дүнд нь аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга болон түүний Тамгын газрын хуульзүйн хэлтсийн ажилтнуудын иргэдэд эрхзүйн анхан шатны зөвлөгөө, мэдээлэл өгөх аргачлал стандартыг боловсруулан нэвтрүүлэх юм.

### **Нөхцөл байдлын судалгаа**

ННФ 2005 онд НҮБХХ болон ХЗДХЯ-тай хамтран “Эрхзүйн мэдээлэл, сурталчилгаа, туслалцааны хүртээмжтэй байдал” нөхцөл байдлын судалгааг хийлээ. Судалгааг Хэнтий, Өмнөговь, Дархан-Уул, Хөвсгөл, Архангай, Ховд аймаг болон нийслэлийн Сонгинохайрхан, Сүхбаатар, Багануур, Налайх, Баянзүрх, Баянгол, Хан-Уул дүүрэгт явуулж, иргэдийн эрхзүйн мэдээлэл, сурталчилгаа түгээх, туслалцаа үзүүлэх

байгууллагуудын талаарх мэдлэг, үнэлэмж; итгэх итгэл; эрхзүйн туслалцааны бодит хэрэгцээ, шаардлага, төрийн болон төрийн бус байгууллагуудын зүгээс иргэдийн эрхийг хамгаалах талаар үзүүлж байгаа үйлчилгээний хүртээмж; иргэд хууль хяналтын болон бусад байгууллагад хандан асуудлаа шийдвэрлүүлэх боломжийн талаар тодорхой дүгнэлт гаргаж эрхзүйн туслалцааг илүү хүртээмжтэй, үр нөлөөтэй үзүүлэх цаашдын арга хэлбэрийг тодорхойлох зорилго тавьсан юм.

Судалгаанаас үзвэл иргэд эрхзүйн мэдээлэл, сурталчилгааны ач холбогдлын талаар харьцангуй сайн мэддэг боловч эдгээрийг түгээх байгууллагуудын үйл ажиллагааны талаарх мэдлэг төдийлөн хангалттай биш байна. Судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь хэдийгээр өмгөөллийн үйл ажиллагааны талаар хангалттай сайн мэддэггүй ч хэрэг маргаанаа шийдвэрлүүлэхэд өмгөөлөгчийн оролцоог харьцангуй өндрөөр үнэлжээ.

### **Стратегийн өмгөөлөл**

Нээлттэй Нийгэм Форум хүний эрхийг дэмжих, хамгаалах, түгээх, ялангуяа эрхзүйн туслалцаа үзүүлэх албан бус буюу ТББ-ын чадавхийг бэхжүүлэх төсөл дээр АНУ-д төвтэй “Глобал Райтс” олон улсын байгууллагатай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж, тус байгууллагын Өмнөд Африк улсад зохион байгуулсан ТББ-уудын хүний эрхийг хамгаалах стратегийн сургалтад Монголын ТББ-ын төлөөлөгчидтэй хамтран оролцов. “Глобал Райтс” олон улсын байгууллагатай хамтын ажиллагаагааны хүрээнд Женев дэх НҮБ-ын Хүний Эрхийн Комиссын 62 дугаар хуралд ННФ ажиглагчаар оролцож, хүний эрхийг хамгаалахад олон улсын буюу НҮБ-ын механизмыг ашиглах талаар мэдээлэл, туршлагаас суралцав. Түүнчлэн НҮБ-ын хүний эрхийн асуудлаарх тусгай элч болон институттэй холбоо тогтоож, НҮБ-ын Хүний Эрхийн Хорооны эрүү шүүлт тулгах асуудлаарх тусгай илтгэгч Манфред Новак Монголд айлчлах үеэр нь Нээлттэй Нийгэм Форум хүний эрхийн ТББ-уудын дунд уулзалт зохион байгууллаа. Манфред Новак НҮБ-ын Хүний Эрхийн Хорооны тусгай процедурын талаар дэлгэрэнгүй мэдээлэл хийж, Монголын ТББ-ууд энэхүү механизмыг хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаандаа хэрхэн ашиглаж болох талаар зөвлөмж өгсөн болно.

Тэрчлэн ННФ 2005 онд олон нийтийг төлөөлөн стратегийн өмгөөллийг хэрхэн хийх талаар Хүний Эрх, Хөгжил Төвтэй хамтран гарын авлага боловсрууллаа. Гарын авлагад стратегийн өмгөөллийн талаарх олон улсын ойлголт, стандарт, туршлага, Монголд стратегийн өмгөөлөл явуулах эрхзүйн орчин, тодорхой туршлага жишээнүүд болон стратегийн өмгөөлөл явуулах аргачлал, аргазүйн зөвлөгөөг багтаасан болно.

## ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ЭРХЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Эдүгээ Монголд төрийн бус салбар улам боловсронгуй болж хөгжлийн шинэ шатанд гарч байна. Манай улсын хувьд энэ төрлийн харилцааг зохицуулж буй гол хууль нь 1997 онд батлагдсан “Төрийн бус байгууллагын тухай хууль” юм. 2005 оны байдлаар энэ хуулийн дагуу байгуулагдсан 5000 гаруй төрийн бус байгууллага Хуульзүй, дотоод хэргийн яаманд бүртгэгджээ. Энэ хууль нь иргэний нийгмийн бүрдэл хэсэг болох сайн дурын үүсгэл санаачлагын байгууллагууд олноор үүсч төлөвшихөд зохих үүрэг гүйцэтгэсэн боловч эрхзүйн шинэтгэл эрчимтэй хийгдэж буй өнөөгийн нөхцөлд шинээр үүсч буй харилцааг зохицуулахад учир дутагдалтай байдал ажиглагдаж байна. Иймээс уг хуулийг бүхэлд нь эргэн судалж боловсронгуй болгох, чингэхдээ олон улсын чиг хандлага, жишиг загварт нийцүүлэх, сүүлд гарсан гол хуулиудтай /“Иргэний хууль”, “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль”/ уялдуулах шаардлага зүй ёсоор гарч ирлээ.

Нээлттэй Нийгэм Форум энэ хуулийн төслийг боловсруулах ХЗДХЯ-ны санаачилгыг дэмжин олон улсын жишигт нийцүүлэх, техникийн туслалцаа үзүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна. Ялангуяа энэ үйл явцын ил тод байдлыг хангах, хуулийн төслийг боловсруулахад ТББ-уудын оролцоог хангах, санаа бодлыг нь тусгах, төслийн чанарыг сайжруулах зорилгоор 2003 оноос эхлэн цуврал уулзалт, хэлэлцүүлгүүд зохион байгуулав. Тэрчлэн ТББ-ын төлөөлөл бүхий өргөтгөсөн ажлын хэсэгтэй хамтран олон улсын байгууллагын санал зөвлөмжийг авлаа. 2005 онд хуулийн төслийг олон нийтэд танилцуулан хэлэлцүүлэх уулзалт ярилцлагыг зохион байгуулж, ТББ-уудын санал, шүүмжийг хүлээн авах үйл ажиллагааг үргэлжүүлэв. Хуулийн төслийг [www.forum.mn](http://www.forum.mn) болон [www.open-government.mn](http://www.open-government.mn) веб сайтуудад байрлуулан олон нийтийн онлайн хэлэлцүүлэг өрнүүллээ.

Хуулийн төслийг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор Ашгийн Бус Байгууллагын Хуулийн Олон Улсын Төв, Иргэний Нийгмийн Хуулийн Олон Улсын Төв, АНУ дахь Нээлттэй Нийгэм Хүрээлэн зэрэг байгууллагаас дахин санал зөвлөмж авсан бөгөөд Иргэний Нийгмийн Хуулийн Олон Улсын Төвийн Ерөнхийлөгч, Төв Европын Их сургуулийн профессор, доктор Леон Айриш Монголд ирж хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгтэй хамтран ажиллалаа. Эдүгээ Ашгийн бус хуулийн этгээдийн тухай хуулийн төсөл УИХ-ын 2006 оны хэлэлцэх асуудлын жагсаалтад багтсан байна. ТББ-уудын дунд зохиосон олон удаагийн хэлэлцүүлгийн үр дүнд энэ хуулийн үйлчлэх хүрээ, ашгийн бус хуулийн этгээдийн тухай ойлголт, үндсэн шинж, хэлбэр, ангилал зэргийг хуулийн төсөлд шинээр нэмж тусгасны зэрэгцээ өөрчлөн байгуулах онцлог, татан буугдсаны дараахь эд хөрөнгийн зохицуулалт зэргийг илүү тодорхой тусгав. Дийлэнх улс орон ашгийн бус хуулийн этгээдэд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг зохих хэмжээгээр зөвшөөрдөг бөгөөд үүнийг тэдний бодитойгоор оршин тогтнох, үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцлийг хангахад чиглэсэн нэлээд чухал зохицуулалт гэж үздэг байна. Иймээс ашгийн бус хуулийн этгээд нь хууль буюу дүрэмд заасан зорилгодоо нийцсэн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж болохыг төсөлд тодорхой тусгасан ба үүнтэй уялдуулан тэдгээрийн орлого ямар эх үүсвэрээс бүрдэх, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангаа хэдийд гаргах, хэнд тайлагнах зэргийг илүү дэлгэрэнгүй тусгаж өгөв.

Төрийн бус байгууллагын тухай хуулийн дагуу байгуулагдаж, бүртгүүлсэн хуулийн этгээдийг “нийгэмд үйлчилдэг”, “гишүүддээ үйлчилдэг” гэж хоёр ангилдаг боловч ийнхүү ангилсаны ач холбогдол, үр дагавар харагдахгүй, зөвхөн ангилал төдий байна. Бусад орны энэ төрлийн хууль тогтоомжоос үзэхэд ангиллаас нь хамааран татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлдэг жишиг байгааг харгалзан зарим зохицуулалтыг төсөлд тусгалаа. Нийгэмд үйлчилдэг ашгийн бус хуулийн этгээдийг ямар шалгуураар тогтоох, энэ статусыг ямар байгууллага олгох, үйл ажиллагаанд нь ямар зорилгоор мониторинг хийх, төрөөс ямар дэмжлэг тусалцаа үзүүлэх зэргийг тодорхой тусгасан байна.

Энэхүү хуулийн төслийг боловсруулахад хэрэгцээтэй тоо, баримтаар хангах үүднээс ННФ 2005 онд “Монгол Улс дахь Төрийн Бус Байгууллагуудын мэдээлэл” судалгааг “Ардчиллын Боловсрол” ТББ-тай гэрээ байгуулан хийж гүйцэтгэлээ. Энэ бол ХЗДХЯ болон Татварын албадын бүртгэл тайлан дээр үндэслэсэн анхны тоон мэдээлэл бүхий судалгаа юм. Судалгаанд ХЗДХЯ-нд бүртгэлтэй 3720, Татварын албанд бүртгэлтэй 1042 ТББ хамрагдсан байна. Судалгааны тайлан [www.forum.mn](http://www.forum.mn) вебсайт дээр англи, монгол хэл дээр тавигдсан болно.

Төрийн бус байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх зорилгоор ННФ 2005 онд Дэлхийн Банктай хамтран жижиг тэтгэлэг олгох хөтөлбөрийг хэрэгжүүлжээ. Хөтөлбөрийн зорилго нь хөгжлийн үйл явцад иргэдийн оролцоог хангах, мэдээллийн солилцоо, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих, бодлогын хэрэгжилтийн хяналт, мониторинг, үнэлгээнд иргэдийн болон иргэний нийгмийн оролцоог хангах, ялангуяа нийгмийн эмзэг бүлгийнхнийг хамруулах, орон нутгийн төвшний санал, санаачилга, үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн юм. Энэ хүрээнд нийтдээ зургаан ТББ тэтгэлэг хүртэж, төрийн ил тод байдал, хариуцлага тооцох байдлыг дээшлүүлэх, нийгмийн эмзэг хэсгийнхний дуу хоолойг хөгжлийн хөтөлбөр, шийдвэрт тусгах чиглэлээр төсөл хэрэгжүүлж байна.

### **“МОНГОЛ УЛС ДАХЬ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН МЭДЭЭЛЭЛ” СУДАЛГААНЫ ДҮНГЭЭС**

ХЗДХЯ-нд бүртгүүлсэн ТББ-уудын тоог авч үзвэл, жилд дунджаар 560, сард 50, долоо хоногт 12 байгууллага бүртгүүлсэн байна. Тэдгээрийн 80 гаруй хувь нь нийгэмд үйлчилдэг, 20 орчим хувь нь гишүүддээ үйлчилдэг гэж бүртгүүлжээ. Нийт ТББ-уудын 77 хувь нь Улаанбаатар хотод байрладаг, 23 хувь нь хөдөө орон нутагт ажиллаж байна. Түүнчлэн 13,4 хувь нь хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, бизнес, 11,8 хувь нь спорт, аялал жуулчлал, чөлөөт цаг, 11 хувь нь нийгмийн салбарыг өөрийн үйл ажиллагааны үндсэн чиглэлээр тодорхойлжээ. Хүний нөөцийн хувьд нийт ТББ-ын ойролцоогоор 30 хувь нь хоёр үндсэн ажилтантай, 23,5 хувь нь таван ажилтантай, 17,6 хувь нь гурван ажилтантай байна.

Татварын албанд тушаасан ТББ-уудын тайлан мэдээллээс үндэслэж гаргасан тооцоогоор нийт ТББ-уудын 20 хүрэхгүй хувь нь идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг дүр зураг харагдаж байна. ТББ-уудын санхүүжилтийн байдлыг авч үзвэл 59.5 хувь нь гадаадын донор байгууллагууд, 27.9 хувь нь өөрсдийн үйл ажиллагааны орлого, 12.6 хувь нь хандив, дэмжлэг зэрэг эх үүсвэрээс бүрдсэн ажээ.

## ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

### ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ИНДЕКС

Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас татгалзаж, ардчилал, зах зээлийн эдийн засаг, эдийн засгийн эрх чөлөөг эрхэмлэсэн нийгэм рүү эргэлт буцалтгүй шилжиж эхлээд 15 жил боллоо. Энэ хугацаанд Монголын эдийн засгийг нээлттэй болгох, олон улсын худалдааг дэмжих, хувийн секторыг хөгжүүлэх, төрийн оролцоог багасгах, зах зээлд тулгуурласан зохицуулалтыг бий болгох олон чухал алхам хийгдсэн. АНУ-ын Херитэдж сангаас гаргадаг дэлхийн 155 орны эдийн засгийн эрх чөлөөний жагсаалтад Монгол Улс 2005 онд 50 дугаар байрт бичигджээ. Хэдийгээр энэ нь хөгжиж буй улсын хувьд



чамлахааргүй үзүүлэлт боловч өнөөдөр авилгал, нийтийг хамарсан ядуурал, эдийн засгийн эрх чөлөөг ил, далдаар боосон хүнд суртал байсаар байна. Энэ нь эдийн засгийн хөгжлийг удаашруулж, нөөцийн үр ашиггүй хуваарилалт, алдагдлыг бий болгож буй гол шалтгаан юм.

Нээлттэй Нийгэм Форум дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний индексийг тооцдог судалгааны томоохон институт болох Фрейзер Институтийн аргачлалд тулгуурлан Монголын эдийн засгийн эрх чөлөөг судалж бодитойгоор хэмжих, улс орны хөгжилд учирч байгаа бэрхшээл, асуудлыг ил тод, нийтээр хэлэлцэх зорилготойгоор энэ хөтөлбөрийг 2005 оноос хэрэгжүүлж эхэлсэн юм. Хөтөлбөрийн хүрээнд МУИС-ийн Эдийн Засгийн сургууль, Санхүү, Эдийн Засгийн Дээд Сургууль, Үндэсний Хөгжлийн Хүрээлэн, Монголын Банкуудын Холбоотой хамтран судлаачид, профессоруудаас бүрдсэн дөрвөн баг байгуулан ажиллаж, эдийн засгийн эрх чөлөөний индексийг чиглэл бүрээр тодорхойлон гаргалаа.

Тухайлбал, эдийн засаг дахь Засгийн газрын хувь хэмжээ, эрүүл мөнгө хүртэх боломж, олон улсын худалдааны эрх чөлөө, зээлийн зохицуулалтын талаар өргөн хүрээтэй судалгаа явуулж, судалгааны явц, үр дүнг мэргэжлийн хүмүүсийн дунд тогтмол хэлэлцүүлэв. Судалгааны эцсийн үр дүн буюу индекс, санал зөвлөмжийг бодлого боловсруулагчид, эдийн засагчид, санхүүгийн томоохон групп, компаниудын удирдлага, Засгийн газрын холбогдох байгууллагын албан тушаалтнууд, судлаачдыг оролцуулсан цуврал уулзалтаар хэлэлцүүлээ. Энэ нь эдийн засгийн эрх чөлөөний асуудалд олон


нийтийн анхаарлыг хандуулахад ихээхэн тус дэмтэй алхам болсон юм. Цаашдаа эдгээр асуудлаар улс орны хэмжээнд өргөн хүрээтэй мэтгэлцээн өрнүүлэх нь эдийн засгийн бодлогын хөгжил дэвшилд нөлөөлнө гэж Форум үзэж байна. Судалгаагаар сүүдэр эдийн засгийн ДНБ-д үзүүлэх нөлөө, хувийн хөрөнгө оруулалтын тооцоо, эдийн засгийн зарим үзүүлэлт Монголын нөхцөл байдалтай нийцэхгүй байгаа зэрэгт үндэслэн аргагүйн зөвлөмжүүд боловсруулаа.

Эдийн засгийн эрх чөлөөний асуудалд холбогдох бодлогыг сайжруулахад индексийг ашиглах явдал нь энэ хөтөлбөрийн бас нэг чухал хэсэг юм. ННФ нь эдийн засгийн эрх чөлөөний индексүүдэд тулгуурлан эдийн засгийн эрх чөлөөний тайланг жил бүр нийтлэн гаргах бөгөөд зөвхөн тухайн индексүүдийг хөрвүүлэн тайлбарлаад зогсохгүй эдийн засгийн гол тулгамдсан асуудлын шинжилгээг хийж, бодлого боловсруулагчдад зориулсан санал зөвлөмжөөр хангах юм.

Нээлттэй Нийгэм Форум 2005 онд Фрейзер институтын албан ёсны түнш байгууллага боллоо. Тус институтын гишүүн байгууллагуудын дунд зохиогддог "Олон улсын эдийн засгийн эрх чөлөө" сэдэвт хуралд ННФ анх удаа оролцон "Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний индекс, түүнийг боловсруулахад тулгарах бэрхшээл" сэдэвт илтгэлийг тавьж хэлэлцүүлсэн нь 2006 оноос эхлэн Монгол Улсын мэдээллийг энэхүү байгууллагын олон улсын индекст хамруулахад ихээхэн тус дэм болсон юм.

Түүнчлэн 2005 онд Монгол Улс анх удаа Дэлхийн Эдийн Засгийн Форум /ДЭЗФ/-аас эрхлэн гаргадаг Дэлхий нийтийн өрсөлдөх чадварын индекст хамрагдсан болно. Уг тайланг гаргахад АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагын санхүүжилттэй Эдийн Засгийн Бодлогын Шинэчлэл, Өрсөлдөх Чадварын төсөл /ЭЗБШӨЧ/ нь ДЭЗФ-ын гол түнш байгууллага болон ажилласан юм. Монгол Улсын дэлхий нийтэд өрсөлдөх чадварын индексийн үр дүнг танилцуулах уулзалтыг Форум ДЭЗФ, ЭЗБШӨЧ төсөлтэй хамтран бизнесийн болон хандивлагч байгууллагуудын дунд зохион байгуулав. 2006 оны Монгол Улсын өрсөлдөх чадварын индексийг боловсруулан гаргахад Форум нь ДЭЗФ-тай хамтран ажиллахаар боллоо.

Монгол Улсын зээлийн зохицуулалтын индекс





## СҮҮДЭР ЭДИЙН ЗАСГИЙН ҮҮРЭГ, РОЛЬ

Шилжилтийн үед сүүдрийн эдийн засгийн цар хүрээ тэлсээр байгаа ч түүний бодит хэмжээ, онцлогийн талаар мэдээлэл тун хомс байгаатай холбогдуулан Нээлттэй Нийгэм Форум Монгол дахь албан бус сектор, сүүдэр эдийн засгийн талаарх нарийвчилсан судалгааг 2004 онд эхлүүлсэн юм. “Албан бус секторын өрхийн судалгаа”-г 2005 онд бүрэн гүйцэтгэж тайланг олон нийтэд танилцуулсан бөгөөд уг салбарын талаар баримтлах бодлогыг боловсруулахад шаардлагатай мэдээллийн баазыг бүрдүүлж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар олон чухал санал зөвлөмжийг бодлого боловсруулагчдад хүргэлээ.



Энэ судалгааг Нээлттэй Нийгэм Форум АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн Эдийн Засгийн Бодлогын Шинэтгэл, Өрсөлдөх Чадвар төсөлтэй хамтран санхүүжүүлж, АНУ-ын Мэриландын Их Сургуулийн дэргэдэх Институцийн Шинэтгэл ба Албан Бус Секторын төвийн зөвлөхүүдийн боловсруулсан аргазүйд үндэслэн Үндэсний Статистикийн Газартай хамтран гүйцэтгэсэн болно. Судалгааг гүйцэтгэгч талуудад зориулан сургалтыг Мэриландын Их Сургууль болон Үндэсний Статистикийн Газарт зохион байгуулснаар ийм төрлийн судалгааг дотоодын мэргэжилтнүүд гүйцэтгэх чадвартай болсон төдийгүй судалгааны дүн шинжилгээг нэгтгэх, өгөгдлийг ашиглах чадавхийг бүрдүүлсэн юм.

Судалгааны дүнд үндэслэн албан бус секторын үйлдвэрлэлийг үндэсний тооцооны систем, дотоодын нийт бүтээгдэхүүнд нэгтгэн тооцоход шаардагдах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Үндэсний Статистикийн Газарт танилцууллаа. Тэрчлэн албан бус секторын талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулахад шаардагдах суурь мэдээлэл, тухайлбал ажил эрхлэлт, уг салбарт ажиллагсдын нийгмийн хамгаалал, татварын бодлого, санхүүгийн үйлчилгээ хүртэх боломж, эрсдэл хүлээх сонирхол зэрэг мэдээллийг ашиглан уг секторыг эдийн засгийн өндөр үр ашигтай хэсэг болгох бодлогыг боловсруулах боломжийг анх удаа бүрдүүлснээрээ энэхүү судалгаа ач холбогдолтой боллоо.

## АЛБАН БУС СЕКТОРЫН ӨРХИЙН СУДАЛГААНЫ ЗАРИМ ДҮНГЭЭС

Албан бус сектор дахь мал аж ахуй болон мал аж ахуйн бус үйлдвэрлэлийн тооцоо /тэрбум төгрөгөөр/								
Албан бус сектор дахь мал аж ахуйн бус үйлдвэрлэл			Мал аж ахуй			Бүгд		
Доод хэмжээ	Дундаж хэмжээ	Дээд хэмжээ	Доод хэмжээ	Дундаж хэмжээ	Дээд хэмжээ	Доод хэмжээ	Дундаж хэмжээ	Дээд хэмжээ
Дугтуйн аргаар								
391	<b>463</b>	535	189	<b>303</b>	417	632	<b>766</b>	899
Үржүүлэгчийн аргаар								
248	<b>369</b>	490	162	<b>215</b>	267	452	<b>584</b>	715
Эдгээр дүнтэй харьцуулах зорилгоор дараачийн хүснэгтэд ҮСГ-аас ДНБ-ийг тооцсон урьдчилсан дүнг үзүүлэв.								
2004 оны ДНБ-ийг тооцсон урьдчилсан дүн (тэрбум төгрөгөөр)								
Албан сектор, МАА-н бус үйлдвэрлэл	Албан бус сектор, МАА-н бус үйлдвэрлэл	Мал аж ахуй	Бүгд					
1,219	259	330	1,809					
Монгол дахь албан бус секторын мал аж ахуй болон мал аж ахуйн бус үйлдвэрлэлийг өнөөгийн албан ёсны тооцооны дүнтэй харьцуулсан тооцоо, судалгааны арга тус бүрээр /хувиар/								
МААБ /АБС <sup>АБСӨС</sup> / ДНБ – АБС <sup>Бик</sup>			МАА <sup>АБСӨС</sup> / МАА <sup>ҮСГ</sup>			АБС <sup>АБСӨС</sup> – АБС <sup>Бик</sup> – МАА <sup>ҮСГ</sup> / ДНБ		
Доод хэмжээ	Дундаж хэмжээ	Дээд хэмжээ	Доод хэмжээ	Дундаж хэмжээ	Дээд хэмжээ	Доод хэмжээ	Дундаж хэмжээ	Дээд хэмжээ
Дугтуйн аргаар								
25.2	<b>29.9</b>	34.5	57.1	<b>91.7</b>	126.4	-0.01	<b>9.7</b>	20.1
Үржүүлэгчийн аргаар								
16.0	<b>23.8</b>	31.6	49.1	<b>65.0</b>	80.9	-9.9	0.0	9.3
Судалгаанд оролцогсдын ихэнх нь Татварын хуулийг сахин мөрдөхгүй байх нь нийтлэг байгаа төдийгүй авилгалтай холбоотой зан үйлдэл түгээмэл тархсан гэж үзэж байна. Үүний цаад шалтгаан нь зохицуулалтын үр нөлөө гэж үзэж болох бөгөөд сүүдрийн эдийн засаг хүрээгээ тэлэх бас нэг нөхцөл болж байна. Албан бус сектор дахь санхүүжилттэй холбоотой асуудлаар харилцан адилгүй байр суурь, төсөөлөлтэй байна. Зээлийн барьцаа их өндөр байгаа нь бизнесийн үйл ажиллагааг ихээхэн боогдуулж байдаг хэдий ч тавигдах шаардлагууд нь албан бус секторын хувьд харьцангуй хөнгөрч байна. Гэхдээ л банкны зээлийн хүү өссөн хэвээр байна.								

Жич тайлбар: МААБ - мал аж ахуйн бус салбарын үйлдвэрлэлийн тооцоо, Бик-Бикалис нарын тооцоо, АБС - албан бус салбарын хэмжээний тооцоо, АБСөС - энэхүү судалгааны тооцоо, ҮСГ-үндэсний Статистикийн Газрын тооцоо.

## УУЛ УУРХАЙН САЛБАРЫН БОДЛОГЫН АСУУДАЛ

Сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарын Монголын эдийн засагт эзлэх байр суурь эрс нэмэгдэж, алт, зэс зэрэг гол экспортын бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнэ ханш өсч байна. Эдүгээ Оюу Толгой, Бороо зэрэг асар том хэмжээний зэс, алтны нөөцийг илрүүлэн, гадаадын хөрөнгө оруулагчдын хамтаар ашиглаж байгаа буюу ашиглахаар төлөвлөж байна. Ашигт малтмалын хайгуул, олборлолттой холбоотой янз бүрийн байр суурь, мэтгэлцээн, тэмцэл нийгэмд өрнөж эхэлжээ. Тухайлбал, уул уурхайн салбараас улсын төсөвт орох орлого ямар хэмжээ, хэлбэртэй байх, гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжихэд ямар бодлого баримтлах, байгаль орчинд үзүүлэх сөрөг үр дагаврыг хэрхэн зохицуулах, Монголын ард түмэнд өгөх үр өгөөж зэрэг асуудлаар эрс тэрс байр суурь давамгайлж байна. Уул уурхай бол Монгол Улсын өсөлтийн нэгэн эх сурвалж гэж хэн хүнгүй үзэх болжээ.

Ийм нөхцөлд уул уурхайн салбарын Монголын нийт эдийн засагт үзүүлэх үр нөлөөний талаар төрөөс баримталж буй бодлогод Нээлттэй Нийгэм Форум анхааралтай хандаж, зарим арга хэмжээг 2005 оноос хэрэгжүүлжээ. Юуны өмнө Форумын зүгээс баримт мэдээлэл, судалгаанд үндэслэсэн, хэлэлцүүлэг өрнүүлэх зорилт дэвшүүлэн ажиллалаа. Тухайлбал, "Форум" телевизийн нэвтрүүлгийн хүрээнд гадаадын хөрөнгө оруулагчдад үзүүлж буй татварын хөнгөлөлт чөлөөлөлт нь нийгэмд баялаг бүтээх зорилготой хэрхэн уялдаж буй байдал, лиценз олголт, түүнтэй холбоотой авилгал, хууль бус үйл ажиллагаа зэрэг хурц тулгамдсан асуудлыг хөндөн ярилцсан нь салбарын хөгжлийн бодлогыг нээлттэй, ил тод, олон талын байр суурийг тусгасан хэлбэрээр боловсруулахад чухал хувь нэмэр оруулав.

ННФ уул уурхайн салбар болон гадаадын хөрөнгө оруулагчдад холбогдох татварын асуудлаар УИХ, Засгийн газрын гишүүдтэй санал солилцож, Нью-Йорк хотноо төвтэй Орлогын Ажиглагч хөтөлбөрийн хамт боловсруулсан санамж бичгүүдээр дамжуулан өөрсдийн байр суурь, зөвлөмжөө өгсөн болно. Оюу Толгой орд газрыг нээн илрүүлж, цаашид ашиглахаар төлөвлөж буй "Айвенхоу Майнз" компаниас гаргасан орд ашиглалтын цогцолбор төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийж, Монголын Засгийн газарт уг орд газрын ашиглалтаас орох орлогын талаар өөрийн дүгнэлтийг гаргаж бодлого боловсруулагчид болон олон нийтэд хүргэлээ. Тэрчлэн энэ асуудлаар янз бүрийн байр суурьтай талуудын хооронд уулзалт ярилцлага зохион байгуулав. Дээрх дүн шинжилгээнүүдэд тулгуурлан Монгол Улсын Засгийн газар уул уурхайн компаниудтай гэрээ байгуулахад эдийн засгийн загвар ашиглан санхүүгийн дүн шинжилгээ хийж, улмаар татвар, нөөц ашигласны төлбөр зэргийг оновчтой тогтоох боломжтойг онцлов. Түүнчлэн томоохон гэрээ хэлэлцээр хийхэд гадаад, дотоодын өндөр төвшний мэргэжилтнүүдийн туслалцааг авахын ач холбогдлыг санууллаа.

Уул уурхайн холбогдолтой бодлогын баримт бичиг, мэдээ мэдээлэл, үзэл бодол зэрэг иж бүрэн мэдээллийг агуулсан буланг [www.forum.mn](http://www.forum.mn) вэб порталд нээн ажиллуулав. Эдгээр үйл ажиллагааг 2006 онд улам гүнзгийрүүлэн үргэлжлүүлэх юм.

## ГАЗРЫН ШИНЭТГЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Газрын шинэтгэлийн асуудлаар Нээлттэй Нийгэм Форум иж бүрэн үйл ажиллагааг өмнөх жилүүдэд явуулж ирлээ. 2005 онд газрын шинэтгэлийн явцад мониторинг хийх үйл ажиллагааг үргэлжлүүлж дүгнэлт хийснээс гадна газрын шинэтгэлийн эрхзүйн асуудлаар бодлогын судалгаа хийж гүйцэтгэлээ.

“Байгаль-21” төрийн бус байгууллагын 2004 онд эхлүүлсэн газрын мониторингийн төслийг дуусгаж, газрын шинэтгэлийн ололт амжилт, алдаа оноог харуулсан иж бүрэн мэдээллийг бүрдүүлэн дүн шинжилгээ



хийж, үр дүнг нь цуврал семинар, өдөр тутмын сонины тогтмол булан, ном товхимол зэргээр дамжуулан олон нийт болон бодлого боловсруулагчдад хүргэлээ. Түүнчлэн ННФ-ын вэб хуудаснаа мониторингийн явц, үр дүнгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэв. Мониторингийн үйл ажиллагааны нэгдсэн дүгнэлтүүдийг бодлого боловсруулагчдад зориулан зөвлөмж байдлаар боловсруулж тарааснаас гадна олон талын оролцоотой семинар зохион байгуулсан нь мониторингийн дүнг тал бүрээс нь хэлэлцэх боломжийг олгосон юм.

Түүнчлэн газрын шинэтгэлийн хууль, эрхзүйн асуудлаар хийсэн бодлогын судалгааг дуусгаж, үр дүнг нь УИХ-ын гишүүд, газрын албадын албан тушаалтнууд, бодлого боловсруулагчид, олон нийтэд танилцуулав. Судлаачийн зарим дүгнэлт, зөвлөмж газрын тухай хууль тогтоомжид орсон өөрчлөлтөд тусгалаа олсон болно. Газрын шинэтгэлийн чиглэлээр ажиллаж байсан хоёрдахь судлаачийн ажлын явц, үр дүн хангалтгүй төвшинд байсан учир судалгааны хөтөлбөрөөс хассан байна.

2005 оны 10 дугаар сард “Шилжилтийн улс орны газрын шинэтгэлийн бодлого” сэдэвт олон улсын бага хурлыг Газрын харилцаа, геодези, зурагзүйн газартай хамтран амжилттай зохион байгууллаа. Уг уулзалтыг зохион байгуулахад Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн Орон Нутгийн Засаглал, Төрийн Албаны Шинэтгэлийн Санаачилга ихээхэн дэмжлэг үзүүлж хамтран ажиллалаа. Хуралд Монгол Улсын Их Хурал, Засгийн

газрын төлөөлөгчид, газрын асуудал эрхэлсэн яам, агентлагийн албан тушаалтнууд оролцож, Армени, Герман, ОХУ, Румын, Украин, Литва, Швед зэрэг 10 гаруй улс орны мэргэжилтнүүдтэй туршлага солилцлоо. Ингэснээр цаашид газрын шинэтгэлийн бодлогыг боловсронгуй болгоход шаардлагатай мэдээлэл, мэдлэгтэй болсноос гадна бүс нутгийн хамтын ажиллагааны эхлэлийг тавьсан гэж хэлж болох юм. Хурлын илтгэл зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг ННФ-ын вэб портал дээр байрлуулснаас гадна ном товхимол болгон гаргах бэлтгэл ажлыг хийж байна.



### Газрын мониторингийн төслийн дүгнэлтээс

Шинээр батлагдсан газрын хууль тогтоомжийг хэрэгжүүлж эхэлснээс хойшхи хоёр жил гаруйн хугацаанд энэ чиглэлээр улс, орон нутгийн хэмжээнд нэлээд ажил хийгдэж, нааштай эхлэлүүд тавигдсан ч хэрэгжүүлэх үйл явц зарим талаар удаашралтай байна.

- Газрын хууль тогтоомжийн талаарх иргэдэд хүрсэн мэдлэг, мэдээлэл хангалтгүй байна.
- Хууль, тогтоомжийг амжилттай хэрэгжүүлэх хамгийн чухал шат болсон сум, дүүрэг, баг, хорооны ажил хариуцсан хүмүүсийн мэдлэг нимгэн, хүнд сурталтай, зохион байгуулалт, шуурхай байдал хангалтгүй байна.
- Улаанбаатар хот зэрэг хүн ам ихээр төвлөрөн суурьшсан хот суурин, дүүрэг, хороод дахь газрын албадын ачаалал хэт ихэссэн, шаардлагатай тооны мэргэжлийн боловсон хүчин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, зураг материалаар хангагдаагүй байна.
- Өнөөгийн мөрдөгдөж буй газрын тухай болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжуудад зохицуулагдаагүй орхигдсон зарим асуудлыг тусгаж хуульчлах шаардлагатай.

Газрын хууль, тогтоомжийг боловсронгуй болгож, түүний хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр дараахь санал зөвлөмжийг бодлого боловсруулагчид, хууль хэрэгжүүлэгчдэд санал болгож байна. Үүнд:

- Газрын тухай хуулиар:
  - Монгол Улсын аж ахуйн нэгж байгууллагад богино хугацаагаар газар ашиглуулах асуудлыг нарийвчлан авч үзэж тусгах;
  - Бэлчээрийн газрыг иргэдийн хамтлаг, нөхөрлөл, болон эрчимжсэн фермерийн аж ахуйд эзэмшүүлэх асуудлыг шийдвэрлэх;
  - Дуудлага худалдаа эсвэл төсөл шалгаруулахад ганц санал ирсэн тохиолдолд хэрхэн шийдвэрлэхийг тодорхой болгох;

- Газар өмчлөлийн тухай хуулиар:
  - Тусгай хамгаалалттай болон тусгай хэрэгцээний газарт байгаа төв суурин газарт газар эзэмшүүлэх болон өмчлүүлэх асуудлыг анхаарах;
  - Иргэд сайн дураараа суурьшиж, төвлөрөл үүсгэсэн газарт газар өмчлөх асуудлыг шийдэх;
  - Хөдөө сумын харъяалалтай тосгон, Нийслэл, төв суурин газрын харъяалалтай тосгонд газар өмчлүүлэх асуудлыг зааглан тусгах;
  - Иргэд заавал төв, суурин газарт газар өмчлөхөөр хуульд тусгасныг эргэн харах; Хэрэв тухайн иргэн хүсвэл газраа өмчилж, эзэмшиж болох эрхийг зарим талаар хязгаарласан заалт бүхий Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг бүхэлд нь эргэж харах;
  - Иргэнд гэр бүлийнх нь хэрэгцээнд өмчлүүлэх газрын хэмжээг ам бүлийнх нь тоог харгалзан тогтоох асуудлыг сайтар судлан үзэх шаардлагатай байна.

Зохион байгуулалтын хүрээнд:

- Хууль, тогтоомжийг амжилттай хэрэгжүүлэх хамгийн чухал шат нь хуулийн мөн чанар, утга учрыг түүнийг хэрэгжүүлэгч бүх шатанд ажиллаж буй төрийн захиргааны удирдах албан тушаалтан, ажил хариуцсан хүмүүс, иргэдэд нэгдсэн зөв ойлголттойгоор хүргэх явдал бөгөөд үүнд чиглэгдсэн сурталчилгаа, сургалт, семинарыг оновчтой бөгөөд үр дүнтэй хэлбэрээр зохион байгуулах;
- Хуулийг хэрэгжүүлэх албадыг мэргэжлийн боловсон хүчин, шаардлагатай техник хэрэгслээр хангах;
- Газрын харилцааг боловсронгуй болгох чиглэлээр гадаад орон, олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл, зээл тусламжийн үр өгөөжийг сайжруулах;
- Хууль хэрэгжүүлэхэд оролцож буй бүх шатны байгууллагуудын ажлын идэвх санаачилга, уялдаа холбоог сайжруулах;
- Газрын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхдээ аль болох иргэд, олон нийтийн санал хүсэлт, оролцоонд тулгуурлах;
- Газар төлөвлөлт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг иргэдэд нээлттэй болгох хэрэгтэй байна.

## **ХУВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН**

---

Монголын эдийн засгийн урт хугацааны тогтвортой хөгжил нь жижиг, дунд үйлдвэрийн өсөлтөөс ихээхэн хамааралтай билээ. Харамсалтай нь эдгээр хувийн хэвшлийнхэн санхүүжилтийн маш их бэрхшээлтэй тулгардаг. Хөгжиж буй улс орнууд дахь эдийн засгийн өсөлтийн эргэлтийг хөдөлгөдөг санхүүгийн эх үүсвэрүүд Монголд байхгүйн зэрэгцээ санхүүжилт авах гол эх үүсвэр болох банк, банк бус санхүүгийн байгууллагууд нь зээл олгохдоо маш хатуу нөхцөл шаарддаг. Компани эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийх санхүүгийн эх үүсвэрийн (тухайлбал, ивээн тэтгэгч, хувийн болон аз туршсан хөрөнгө оруулалтын сан, санхүүгийн бус хөрөнгө оруулагч, олон нийтийн хөрөнгө оруулалтын зах зээл зэрэг) орон зай хоосон хэвээр байна. Иймээс Форум нь “Эдийн Засгийн Бодлогын Өрсөлдөх Чадвар” төсөлтэй хамтран 2004 онд хувийн хөрөнгө оруулалтын сан байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг тодорхойлох анхан шатны судалгааг хийсэн юм. Энэхүү судалгааны зөвлөмжүүдэд тулгуурлан хувийн хөрөнгө оруулалтын санг Монголд байгуулах боломжийг тодорхойлох хоёр дахь шатны судалгааг 2005 онд явууллаа.

Судалгаагаар хувийн хөрөнгө оруулалтын уламжлалт санд хамрагдах боломжтой компанийн чанар, хэмжээг нарийвчлан тодорхойлох зорилгоор компанийн удирдлага, өгөөжийн шаардагдах хувь хэмжээ, гарц, хөрөнгө оруулагчийн оролцоо ба удирдах зөвлөлийн гишүүнчлэл, үүсгэн байгуулагчийн дэмжлэг, бизнесийн баримт бичиг зэрэг асуудлыг авч үзсэн юм. Судалгааны үр дүнгээс үзэхэд Монголд найдвар төрүүлэхүйц компаниуд байгаа хэдий ч “цэвэр” компани эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийдэг уламжлалт хөрөнгө оруулагчдын хатуу шалгуурыг давах компани нэг ч байхгүй нь харагдлаа. Иймээс компани эзэмшигчийн өмчид хийх уламжлалт хөрөнгө оруулалтаас өөр хувилбарыг хайх, улмаар түүнтэй адилтгах хөрөнгө оруулалт буюу “хувьцаа эзэмшигчийн зээлийн сан” нь Монголын хувьд хамгийн тохиромжтой байж болох тухай зөвлөмжийг гаргалаа.

Түүнчлэн судалгаанд хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээ, худалдааны банкны үйлчилгээ, зуучлалын бусад хэлбэр, аз турших буюу эрсдэлтэй лизингийн хэлбэр зэргийг судлах санал зөвлөмжийг тусгасан болно. Дээрх судалгааг удирдан явуулсан олон улсын зөвлөх Брюс Норлунд “Хувийн компани эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийх буюу аз турших капиталаар компанийн хөрөнгийг бүрдүүлэх нь” сэдэвт сургалтыг банк, бизнес болон олон улсын байгууллагын төлөөлөгчдөд зориулан явуулсан нь оролцогчдын мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх ач холбогдолтой болсон юм.

Судалгааны ажлын нэг чухал үр дүн нь бизнесийн санхүүгийн боломж олгоход чиглэсэн энэ төрлийн хувийн хөрөнгө оруулалттай компани байгуулагдсан явдал юм.



### Монгол Улсад хувийн хөрөнгө оруулалтын сан байгуулах төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг тодорхойлох хоёр дахь шатны судалгааны үр дүнгээс

Бид “хөрөнгө оруулалт хийх магадлал бүхий компани” буюу хөрөнгө оруулалт хийхэд нэлээд боломжийн компанийг хайсан бөгөөд тэд дараахь үндсэн шалгуур үзүүлэлтийг хангасан байх ёстой байв. Үүнд:

1. Менежментийн хүчирхэг баг
2. Хөрөнгө оруулагчид шаардагдах өгөөжийн хувийг олгож чадах бүтээгдэхүүн ба үйлчилгээний зах зээл
3. Төлөвлөсөн “гарц” (тодорхой)
4. Оролцоо ба удирдах зөвлөлийн гишүүнчлэл
5. Үүсгэн байгуулагчийн тогтвортой хичээл зүтгэл
6. Сайтар бэлдсэн санхүүгийн тайлан, баримт бичгүүд

Дүн шинжилгээгээ 24 компани дээр явуулсан бөгөөд эдгээрийн найм нь илүү эрчимтэй дүн шинжилгээ хийх хангалттай үндэслэлтэй байлаа. Судалгаанд хамрагдсан ихэнх компани хэмжээний хувьд тавьсан шаардлагад нийцэж байв. Компаниуд нэг сая долларын орлоготой бөгөөд тэдэнд 500,000 долларын капитал шаардлагатай байсан. Зарим компани энэ хязгаараас доогуур үзүүлэлттэй байсан ч бидний үзэж байгаагаар тэд хөрөнгө оруулалт хийх илүү их боломжтой байв.

Бидний судалсан компаниуд нь өнөөгийн байдлаар Монголд байгаа “дээд давхарга”-ын компаниудыг төлөөлж байна. Найман компаниас зөвхөн дөрвөн компанийн таамаглан тооцоолсон өгөөжийн хувь хэмжээ нь 25 хувь буюу түүнээс дээш гарсан.

Компанийн эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийдэг хатуу шаардлагатай хувийн хөрөнгө оруулагчийн үүднээс авч үзвэл бид судалгааныхаа үр дүнг дараахь байдлаар дүгнэсэн болно:

- 1. Компанийн удирдлага.** Зах зээл, бизнесүүд нь дөнгөж эхлэлийн үе шатанд байгаа ч бидэнтэй уулзсан олон компанийн удирдлагын баг болон компанийн эзэд сайхан сэтгэгдэл төрүүлсэн. Гэхдээ ихэнх компанийн удирдлага, эзэд мэдээлэл өгөх талаар бидэнтэй хамтран ажиллах хүсэлтэй байсан ч компанийн ил тод байдал, итгэл хүлээх чадвартай эсэхийг бүрэн тодорхойлохын тулд нэгээс илүү удаа уулзах шаардлагатай байлаа.
- 2. Өгөөжийн шаардагдаж буй хувь хэмжээ.** Компаниудын гаргаж өгсөн, гэхдээ бидний бие даан шалгаагүй мэдээллээс үзвэл иж бүрэн судалгааны дүн шинжилгээнд хамрагдсан 8 компанийн

Компани	ӨХХ
А	25%
Б	3%
В	41%
Г	байхгүй
Д	36%
Е	47%
Ж	21%
З	-2%

хувьд эзэмшигчийн өмчид оруулах хөрөнгө оруулалтын ирээдүйн өгөөжийн хувь хэмжээ (ӨХХ) нь -2%-иас 47% хүртэл хэлбэлзэж байна. Ирээдүй байгаа ч гэсэн уламжлалт “цэвэр” хувийн хөрөнгө оруулалтын хэрэгслэлд нийцэх ирээдүйн хэлцлийн тоо хангалтгүй байна.

- 3. Гарц.** Хөрөнгө оруулалтын өгөөжийг хүртэхийн тулд хөрөнгө оруулалтаас гарах арга зам буюу гарц олох асуудал нь Монгол шиг хөгжиж буй зах зээлийн нөхцөлд компани эзэмшигчийн өмчид хувийн хөрөнгө оруулалт хийхэд тавигддаг гол шаардлага болдог. Хөрөнгийн зах зээлээр дамжих гарц өнөөгийн байдлаар Монголд хэрэгжих боломжгүй байна. Ийм нөхцөлд компани эзэмшигчийн өмчид хийсэн хөрөнгө оруулалтаас гарах хувилбарууд хязгаарлагдмал, стратегийн хөрөнгө оруулагч олох, зээлээр худалдан авах зэргээс шалтгаалан хязгаарлалт эрсдлийг нэмэгдүүлдэг.
- 4. Хөрөнгө оруулагчийн оролцоо ба удирдах зөвлөлийн гишүүнчлэл.** Компанийн удирдлага, эздийн хандлагыг дүгнэхэд хөрөнгө оруулагчийн зүгээс компанийн хөгжлийн асуудалд оролцож, удирдах зөвлөлийн гишүүн байх шаардлагын талаар янз бүрийн санал сэтгэгдэл илэрхийлж байлаа. Хувийн хөрөнгө оруулагчийн зүгээс удирдлага заавар авах асуудлыг компаниудын ойролцоогоор хагас нь хүлээн зөвшөөрч байсан. Зарим нь техникийн ба санхүүгийн туслалцаа авах сонирхолтой байсан. Гэхдээ зарим компани хөрөнгө оруулагчийн оролцоог компанийн хэрэгт дайран орох явдал хэмээн үзэж хөрөнгө оруулагчийн хөрөнгөөс гадна авчрах үнэ цэнийг бүрэн ойлгохгүй байсан байж магадгүй юм.
- 5. Үүсгэн байгуулагчийн дэмжлэг.** Бидэнтэй уулзсан компаниудын олонх нь бүлэг компаниудын нэг хэсэг байсан. Хувийн хөрөнгө оруулагчид бүлэгт багтдаг компанид хөрөнгө оруулах сонирхолгүй байдаг бөгөөд тухайн бизнест өөрийнхөө хөрөнгийн ихэнхийг зориулсан үүсгэн байгуулагчтай шууд ажиллахыг илүү сонирхдог.
- 6. Бизнесийн баримт бичиг.** Зарим компани бизнесийн төлөвлөгөө, санхүүгийн тайлан тэнцэл зэрэг баримт бичгийг өгсөн боловч нэг нь ч хувийн хөрөнгө оруулагчийн шаардлагад нийцэхээргүй байсан. Зах зээл хөгжиж буй Монгол шиг оронд ийм зүйл тохиолддог.

## ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЯРИА ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Монгол орны хөгжлийн урт хугацааны үзэл баримтлал боловсруулахад хувь нэмэр оруулах зорилгоор ННФ “Хөгжлийн тухай яриа” байнгын хэлэлцүүлэг бий болгохыг зорьж байна.

2005 онд ННФ Монголын тэргүүлэх эдийн засагчид, бодлого боловсруулагчид, их, дээд сургуулиудтай хамтран цуврал лекц, ярилцлагыг зохион байгуулж эхэлсэн бөгөөд дэлхийд нэртэй хоёр эдийн засагчийн лекцийг зохион байгуулсан байна.



2005 оны тавдугаар сард Нобелийн шагналт эдийн засагч Роберт Манделлийн цуврал лекц, уулзалтыг Монгол Улсын Их Сургуультай хамтран зохион байгуулав. Дэлхийн тэргүүлэх макро эдийн засагчдын нэг Роберт Манделл тодорхой бүс нутгууд нэг мөнгөн тэмдэгтэд шилжих боломж болон дэлхийн эдийн засгийн гол чиг хандлагын талаар бодлого боловсруулагчид, судлаачид, эрдэм шинжилгээнийхэн, өргөн олон нийтэд зориулан хоёр лекц уншиж, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчидтэй ярилцлага өрнүүллээ. Тэрбээр мөн Монгол Улсын Ерөнхий сайдтай уулзсан. Роберт Манделл Монгол Улсын хөгжилд даяарчлалын гүйцэтгэх үүрэг, ялангуяа тус улсын хөрш Хятад улсын дэлхийн эдийн засгийн тавцанд өсөн нэмэгдэж буй үүрэг ролийн талаар үзэл бодлоо хуваалцлаа.

Нэрт эдийн засагчидтай хийсэн цуврал ярилцлага, лекцийн дараагийн зочин нь Нобелийн шагналт эдийн засагч Жозеф Штиглиц байлаа. Тэрбээр 2005 оны зургадугаар сарын 6-нд ННФ-аас зохион байгуулсан сэтгүүлчдэд зориулсан сургалтад видео бага хурлаар дамжуулан оролцож, Монголын хөгжилд хэвлэл, мэдээллийн гүйцэтгэх үүргийн талаар лекц уншсан юм. Түүний яриа Монголын хувьд хамгийн хурдацтай хөгжиж буй уул уурхайн салбар руу чиглэсэн бөгөөд “нөөц баялгийн хяслан”-гаас зайлсхийх, үр шимийг нь хэрхэн хүртэх тухай байлаа. Жозеф Штиглицийн лекцийг бид [www.forum.mn](http://www.forum.mn) портал сайтаараа дамжуулан олны хүртээл болгосон бөгөөд эдүгээ Монголын өдөр тутмын томоохон сонин болох “Зууны мэдээ” сонин түүний лекцээр эрдэмтэн судлаачдын дунд “Байгалийн нөөц баялаг ба хөгжил” сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлж байна.

2002-2004 онд олон талын оролцоотойгоор хөгжлийн сценари боловсруулах тодорхой аргазүйд тулгуурлан боловсруулсан Монгол Улсын эдийн засгийн 2015 он хүртэлх хөгжлийн ирээдүйн дүр төрхийг олон нийтэд илүү хүртээмжтэй болгох талаар ажиллалаа.

Форум нь эдийн засгийн хөгжлийн ирээдүйг дүрслэх, олон нийт ирээдүйнхээ талаар бодож эргэцүүлэх, хэлэлцэхийг хөхиүлэн дэмжих зорилгоор Монголын ирээдүйн хөгжлийн дөрвөн үндсэн дүр зургийн талаар холбогдох нийтлэл, зураг, баримт бичгийг багтаасан сэтгүүл хэвлэн нийтлүүлсэн бөгөөд дүр төрхүүдийн тухай сонирхсон хүмүүс онлайн хэлэлцүүлэг, мэтгэлцээн өрнүүлж байна. Мөн Форумын олон нийтэд хүрэх гол хэрэгсэл болох портал сайтаар дамжуулан барууны тэргүүлэх эдийн засагчдын бичсэн бодлогын асуудлуудаарх нийтлэлүүдийг орчуулан тавьж байна.

Үндэсний хөгжлийн яриа хэлэлцүүлэг өрнүүлэх энэ ажлын хүрээнд Нээлттэй Нийгэм Форум Дэлхийн Банктай хамтран жижиг, дунд үйлдвэрлэл ба бичил зээлийн хөгжлийн талаар хандивлагчдын үйл ажиллагааг уялдуулахад чиглэсэн сар тутмын уулзалтыг зохион байгуулсан болно.

## БУСАД

### **"АЛБАДАН АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛЫГ ХЭВШҮҮЛЭХ" ТӨСӨЛ**

Албадан ажил хийлгэх ял нь гэмт хэргийн улмаас учруулсан хор уршгаа ялтан нийгэмдээ нөхөн төлөх, нийгэм хамт олны дунд засран хүмүүжиж гэм буруугаа ухаарах, цаашид нийгэмд бие даан амьдрах чадвартай болох боломжийг бүрдүүлдэг. Гол давуу тал нь насанд хүрээгүй хүмүүс болон хөнгөвтөр гэмт хэрэг анх удаа үйлдсэн гэмт хэрэгтэн шоронд хоригдон нийгмээс тасрах, рецедив гэмт хэрэгтнүүдийн нөлөөнд автаж давтан гэмт хэрэг үйлдэх нөхцлөөс урьдчилан сэргийлэх явдал юм. Нөгөө талаар эдийн засгийн хүндрэлтэй байгаа манай улсад нэлээд дарамт авчирдаг шоронгийн өртөг зардлыг хөнгөлөх ач холбогдолтой юм. Иймээс энэхүү шинэ ял нь нийгэм, эдийн засгийн хувьд ихээхэн ач холбогдолтой төдийгүй эрүүгийн ял шийтгэлийн тогтолцоонд нийгэм, хамт олны оролцоог бүрдүүлэх шинэ хандлагыг бий болгож буйгаараа онцлог юм. Төслийн зорилго нь хөнгөвтөр гэмт хэрэг анх удаа үйлдсэн болон насанд хүрээгүй гэмт этгээдийг нийгэм, хамт олны дунд хүмүүжүүлэх, нийгэмд тустай ажил хийснээр учруулсан гэм хороо төлөх боломжийг бий болгох, гэмт хэрэг үйлдсэн хүнийг хүнд хөнгөнөөс нь үл шалтгаалан тусад нь хорих ёстой гэсэн нийгмийн хандлагыг өөрчлөх явдал юм.

ННФ нь МННХ-гээс санхүүжүүлэн хэрэгжүүлж байсан "Албадан ажил хийлгэх ялыг хэвшүүлэх" төслийг Шүүхийн Шийдвэр Биелүүлэх Ерөнхий Газартай хамтран хоёр дахь жилдээ хэрэгжүүлж байна. 2005 онд хийгдсэн үнэлгээний үндсэн дээр төслийн үр дүнг дүгнэж, цаашид энэхүү төслийг өргөжүүлэн зөвхөн нийслэлийн дүүргүүдийн хэмжээнд бус, улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр боллоо.

Төслийн хүрээнд албадан ажил хийлгэх ял оноох, эдлүүлэх, хянах ажиллагааг явуулах хуулийн байгууллагуудын ажилтнуудыг бэлтгэх, мэдээллээр хангах тогтмол сургалтыг зохион байгуулах, олон нийтэд мэдээллээр үйлчлэх зэрэг үйл ажиллагаа хийгдэж байна. Түүнчлэн ажлаар хангах байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллаж, уг ялаар шийтгэгдсэн хүмүүстэй хэрхэн харьцах, ажиллуулах талаар зөвлөгөө, сургалт зохион байгуулав. Ялантай ажиллах, нийгэмших, засрал хүмүүжилд нь нөлөөлөх үйл ажиллагааг нийгмийн ажилтнуудын туслалцаатайгаар хэрэгжүүлж, нийгэмд тустай ажлаар хангалаа.

## **ДОРНО ДОРНО: ХИЛ ХЯЗГААРГҮЙ ТҮНШЛЭЛ БҮСИЙН ХӨТӨЛБӨР**

---

Дорно дорно хөтөлбөр нь нээлттэй нийгмийг хөгжүүлэх, түүнийг бэхжүүлэх нөхцлийг бий болгоход чиглэсэн хүмүүсийн идэвх санаачилга, хамтын ажиллагаа, хил хязгааргүй түншлэлийг дэмждэг Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн бүсийн хөтөлбөр бөгөөд ННФ Монгол дахь үйл ажиллагааг нь хариуцан хэрэгжүүлж байна. Хөтөлбөр нь нээлттэй нийгмийн үзэл санааг бүсийн хэмжээнд бэхжүүлэхэд түлхэц болох шинэ санаа, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх явдлыг дэмжин хоёр буюу түүнээс дээш орныг хамарсан төслийг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлдэг.

Орон нутгийн нөхцөл байдлыг сайн мэдэрч дороос гарч ирсэн санаачилгуудад анхаарлаа хандуулж нээлттэй нийгэм хөгжүүлэхэд хүмүүс хил хязгаар харгалзахгүйгээр хүч хавсран ажиллах боломжийг нэмэгдүүлэх явдлыг урт хугацааны зорилго болгодог энэ хөтөлбөрийн хүрээнд бүсийн орнуудад зохиогдож буй шинэлэг санаа, арга туршлагаа хуваалцах зорилго бүхий арга хэмжээнд Монголын мэргэжилтэн, төлөөлөгчдийг хамруулах үйл ажиллагаа хийж байна.

2005 онд энэхүү хөтөлбөрийн хүрээнд болон санхүүжилтээр дараахь хүмүүс хурал зөвлөгөөнд оролцлоо. Тухайлбал:

Д.Биндэрья, Б.Эрдэнэбаатар нар “Боловсролын салбарын хариуцлагатай байдал болон чанарын баталгаа:шалгалтын тоон мэдээллийн боломжит хувь нэмэр” хуралд /Украин улс, 2005 оны 10 дугаар сарын 5-9/,

Б.Энхжин “Шорон дахь ДОХ/ХВДХ-ын чиглэлийн үйл ажиллагаа: урьдчилан сэргийлэх, эмчилгээ, дэмжлэг” хуралд /Украин улс, 2005 оны 11 дүгээр сарын 1-2/,

Н.Энхтуяа, Р.Банди нар “Боловсролын бодлогын шинэчлэл болон Бодлогын төвүүдийн гүйцэтгэх үүрэг” /Литва улс, 2005 оны 11 дүгээр сарын 11-12/,

Р.Нарангэрэл, М.Төрбаяр нар “Иргэний Нийгмийн Хуулийн дэлхийн чуулган” /Турк улс, 2005 оны 11 дүгээр сарын 17-19/ тус тус оролцжээ.

## ФОРУМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ:

### ХӨГЖЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТӨВ

Монгол Улсад ажиллаж буй донор байгууллагуудтай (Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн Банк, НҮБ) хамтран үйл ажиллагаагаа өргөжүүлсэн Хөгжлийн Мэдээллийн төв бодлогын болон хөгжлийн сэдвээр шинээр гарч байгаа ном, судалгааны тайлан, үнэлгээ, бодлогын баримт бичиг зэрэг цогц мэдээллийг нэг цэгээс хүргэхийн зэрэгцээ судлаачид, бодлого боловсруулагчид, төрийн болон ТББ, донор байгууллагын ажилтнууд олон нийттэй уулзалт хийдэг, шинээр гарч буй судалгаа, ном бүтээлээ танилцуулдаг түшиц газар болж эхэллээ. Ингэснээр хүмүүс хэрэгцээ шаардлагатай мэдээллээ үнэ төлбөргүй авч улс орны хөгжлийн



асуудлаар өрнөж буй уулзалт ярилцлагад илүү мэдлэг, мэдээлэлтэй оролцоход тус нэмэр болж байна.

Мэдээллийн төв нь зөвхөн мэдээллийн үйлчилгээ үзүүлээд зогсохгүй хөгжлийн бодлогын асуудлаар уулзалт ярилцлага өрнүүлэх, бусад улс орны онлайн номын сан болон мэдээллийн санг танилцуулах, сургалт явуулах, мэдээллийг хүртээмжтэй, энгийн, хялбар аргаар түгээх, олон улсын хөгжлийн агентлагуудаас эрхлэн хэвлэж байгаа чухал сэдвийн номыг өөрийн орны хэрэглэгчдэд хүргэх зэргээр үйл ажиллагаагаа улам өргөжүүлэхийг зорьж ажиллалаа.

Хөгжлийн Мэдээллийн төвд 2005 оны жилийн эцсийн байдлаар судалгааны тайлан, бодлогын баримт бичиг, донор байгууллагуудын гол хэвлэн нийтлэл, тайлан, статистик мэдээлэл, сүүлийн үед хэвлэгдэн олны анхаарал татаж байгаа ном зэрэг 3200 орчим эх сурвалж хэвлэмэл болон электрон хэлбэрээр ашиглагдаж байна. Түүнчлэн гадаад, дотоодын тогтмол хэвлэл, өдөр тутмын сонин зэрэг 20 гаруй төрлийн хэвлэлээр олон нийтэд үйлчилдэг. Төвд байгаа бүх ном, судалгааны тайлангуудыг Онлайн каталогийн [www.forum.mn/](http://www.forum.mn/) хайж захиалах боломжтой.

### Үйл ажиллагаа, үр дүн

Хөгжлийн Мэдээллийн төв нь судлаачид, бодлогын хүрээнийхэн, их дээд сургуулийн багш нар, төрийн болон ТББ-ын ажилтнууд, сэтгүүлчид, олон улсын байгууллагын ажилтнууд, УИХ-ын гишүүд, олон

нийтэд мэдээллийн үйлчилгээ үзүүлж ирсэн ба 2005 онд нийт 5100 орчим хүн уг төвд хандан үйлчилгээ авчээ. Үүнээс 3500 гаруй хүн ном, судалгаааны материалыг гэрээр авч ашигласан байна.

Мөн хөдөө орон нутгийн номын сан, мэдээллийн төвүүд, их дээд сургуулийн номын сан, УИХ-ын болон Засгийн газрын гишүүд, ТББ-уудад 11700 гаруй ном түгээж, Дэлхийн Банкнаас эрхлэн гаргаж байгаа номыг хөнгөлөлттэй үнээр захиалан нийлүүлдэг боллоо. 2005 онд төвийн мэдээллийн сан 400 орчим ном, 80 гаруй шинэ судалгаааны тайлан, үнэлгээ, 30 гаруй CD- ээр нэмэгджээ.

Түүнчлэн судлаачид, зохиогчид, Засгийн газрын агентлаг болон донор байгууллагын ажилтнуудыг урьж олон нийттэй чөлөөтэй ярилцах боломжийг олгохын зэрэгцээ тус төвийн онлайн каталоги, Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банкны онлайн мэдээллийн сан, Кэмбриджийн онлайн сэтгүүлүүд, Оксфордын лавлах номуудыг хэрхэн ашиглах талаар зааварчилга-сургалт, шинээр хэвлэгдэн гарч байгаа судалгаа болон орчуулгын номын нээлт зэрэг нийтэд зориулсан 20 орчим арга хэмжээг зохион байгууллаа.

Төвийн үйлчлүүлэгчид Интернэт ашиглан судалгаа хийх, мэдээлэл хайх, электрон мэдээлэл ашиглах боломжоор хангагддаг. 2005 онд хараагүй болон сул хараатай иргэд ашиглах тусгай компьютер, техник технологийг бий болгосон юм. Тайлант хугацаанд нийтдээ 500 орчим хүн 2000 орчим цаг Интернэт ашигласан байна.

2005 онд Хөгжлийн Мэдээллийн төв нь үйл ажиллагааны хувьд төлөвшиж бусад улс оронд ажилладаг ижил төрлийн мэдээллийн төвд болдог арга хэмжээг олон нийтэд хүргэхийг зорьж, үйлчилгээгээ зөвхөн мэдээллийн төвд төдийгүй боломжит үйлчилгээг онлайнаар хүргэсэн нь үр дүнгээ өгч, бодлогын хүрээнд ажиллаж буй хүмүүс хэрэгцээ шаардлагатай мэдээллээ захиалдаг болж байна. Түүнчлэн хамтран ажиллаж байгаа хөгжлийн агентлаг, судалгаааны төв, Засгийн газрын болон ТББ-ууд нь зөвхөн хэрэглэгч-үйлчлүүлэгч байх төдийгүй ном, судалгаааны тайлан, бодлогын баримт бичиг зэрэг мэдээлэл нийлүүлж хувь нэмрээ оруулж байна.



## ТЕЛЕВИЗИЙН ХӨТӨЛБӨР

Бодлого боловсруулах үйл явц, түүний хэрэгжилтэд иргэдийн идэвхтэй оролцоог хангахад дөхөм үзүүлж, улс орны хөгжлийн болон бодлогын өргөн хүрээтэй асуудлаар мэдлэг, мэдээлэл түгээх зорилготой Нээлттэй Нийгэм Форумын телевизийн хөтөлбөр 2005 онд тус бүр нь нэг цагийн үргэлжлэл бүхий 30 удаагийн “Форум” шууд нэвтрүүлгийг бэлтгэн Монголын үндэсний телевизээр орон даяар дамжууллаа. Нэвтрүүлэгт янз бүрийн ажил мэргэжлийн 1000 орчим хүн биеэр оролцож байр сууриа илэрхийлэн мөн хэдэн мянган үзэгч нэвтрүүлгийн сэдвүүдээр утсаар саналаа өгсөн юм.

Монгол орны нийгэм, эдийн засаг, улстөрийн амьдралын тулгамдсан асуудлууд, шийдвэрлэх арга замуудыг сонирхогч олон талын оролцоотой хэлэлцүүлдэг “Форум” нэвтрүүлгийн сэдэв, агуулга их өргөн байлаа. Тухайлбал, иргэдийн шууд оролцоо бүхий нээлттэй засаглал, иргэний хөдөлгөөн, төрийн ой санамж, хариуцлагатай төр, сонгуулийн тогтолцоо, татвар, нийгмийн даатгалын тогтолцоо, мэдээллийн эрх чөлөө болон хэвлэл, мэдээллийн өөрийн зохицуулалт, авилгын индекс, сонирхлын зөрчил, Монголын өрсөлдөх чадавхийг ахиулах тэргүүлэх салбарууд - уул уурхайн болон аялал жуулчлалын хөгжлийн асуудлууд, ядуурал, монгол хүний орлого зэрэг олон талт сэдвийг хөндлөө. “Форум” нэвтрүүлгийн дэвшүүлсэн асуудлууд нь нийгмийн анхаарлыг нэлээд татаж, иргэний нийгмийн төлөвшилт, бодлого боловсруулагчдын төвшинд зохих нөлөө үзүүлж эхэллээ гэж дүгнэж болохоор байна.

Ялангуяа Монголын говьд шинээр нээгдсэн зэс, алтны дэлхийд томоохонд тооцогдох орд газрын ашиглалт, алтны шороон ордуудын олборлолтоос эдийн засагт үзүүлж байгаа үр ашгийн төвшин, уул уурхайн олборлолтоос үүдсэн экологийн сүйрлийг хөндсөн цуврал нэвтрүүлэг нийгмийг ямар нэг хэмжээгээр цочроож, байгаль хамгаалах, газрын хэвлийн баялгийг оновчтой ашиглах чиглэлийн иргэний үүсгэл санаачилгын хэд хэдэн хөдөлгөөн бий болж, идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхлэхэд зохих түлхэц болсон юм.

Монголын Хэвлэлийн Хүрээлэнгээс нийт телевиз үзэгчдийн дунд тогтмол явуулдаг санал асуулгын дүнгээр “Форум” нэвтрүүлэг 2005 оны телевизийн улстөр, нийгмийн шилдэг нэвтрүүлгээр шалгарч өндөр чансаатай нэвтрүүлгийн нэг боллоо.

## Нээлттэй Нийгэм Форумын 2005 оны нэвтрүүлгүүдийн товч танилцуулга

1	2005 оны 1-р сарын 5.	<u>“2016 ОНЫ МОНГОЛ: ГОЧООГИЙН 4 ТАВИЛАН”</u> Жил гаруйн өмнө МННХ-ээс боловсруулж “Шинэ эрин” сэтгүүлд нийтэлсэн 2016 оны Монголын хөгжлийн сценари буюу зураглалын дөрвөн хувилбарыг хэлэлцлээ.
2	2005 оны 1-р сарын 12.	<u>“ХАРИУЦЛАГАТАЙ ТӨР”</u> Улсын Их Хурлаас 1998 онд баталсан Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, УИХ-ын тогтоолоор РТХЭГ-ыг татан буулгаж үндэсний нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болгон зохион байгуулахаар заасан атал хэрэгжүүлэлгүй зургаан жил болсон төр, засгийн хариуцлагын тухай нэвтрүүлэг.
3	2005 оны 1-р сарын 19.	<u>“МОНГОЛЫН АЛТ”</u> Алтны уурхайнууд өнөөдөр улс орны эдийн засагт ямар хувь нэмэр оруулж байгаа болон байгаль орчныг хэрхэн сүйтгэж нөхөн сэргээлт хийхгүй байгаа талаар хэлэлцэв.
4	2005 оны 1-р сарын 26.	<u>“ЯДУУРЛЫН ЭСРЭГ ДАЙНЫ БАЙДАЛ”</u> 2004 оны намар Монгол Улсын Ерөнхий сайд Ц.Элбэгдорж “Засгийн газар ядууралд дайн зарлаж байна” хэмээн албан ёсоор мэдэгдсэн. Ингээд Засгийн газар ядууралтай хэр сайн “байлдаж” байгаа талаар дүгнэн ярилцав.
5	2005 оны 2-р сарын 2.	<u>“НҮҮХ ҮҮ?”</u> Орон нутгаас бэлтгэсэн “Форум” нэвтрүүлгийн анхны дугаар бөгөөд Монгол Улсын 331 сумыг төлөөлүүлж Архангай аймгийн Батцэнгэл сумын жишээн дээр хөдөөд малчдын тоо жил бүр цөөрч, хөдөөгөөс хот, суурин газар руу шилжигсдийн тоо буурахгүй байгаагийн шалтгаан, цаашдын чиг хандлагыг малчдын оролцоотойгоор хэлэлцлээ.
6	2005 оны 2-р сарын 16.	<u>“МОНГОЛ БӨХ - СУМО”</u> Сүүлийн үед монголчуудын хамгийн үзэх дуртай болсон японы мэргэжлийн сумогийн барилдаан ба монголын үндэсний бөхийг харьцуулан ярилцаж монгол бөхөд хавтгайрсан нутаг нугын үзэл, “начны найраа” зэрэг сөрөг үзэгдлүүдийг хэрхэн даван туулах тухай нэвтрүүлэг.
7	2005 оны 2-р сарын 23.	<u>“УЛСТӨРИЙН ШИНЭ НӨХЦӨЛ БАЙДАЛ”</u> Монголд хоёр нам хэт давамгайлж байснаа улстөрийн зөвшилцлийн үр дүнд хүчтэй сөрөг хүчин байхаа больсон шинэ нөхцөл байдал, үр дагаврын тухай нэвтрүүлэг.
8	2005 оны 3-р сарын 2.	<u>АВИЛГЫН ИНДЕКС</u> Монгол дахь авилгын нөхцөл байдал улам бүр муудсаар байгааг тодорхойлоод байдлыг эрүүлжүүлэх арга замуудыг шүүн хэлэлцлээ.
9	2005 оны 3-р сарын 9.	<u>ХОТ ТӨЛӨВЛӨЛИЙН БОДИТ БАЙДАЛ</u> Улаанбаатарт орон сууцны дэргэдэх хүүхдийн тоглоомын талбай, сургуулийн биеийн тамирын талбай, явган зам, зүлэг, цэцэрлэгийн дээр баригдсан, баригдаж буй барилгуудыг тойрсон “газрын маргаан” нэртэй зөрчил тэмцлийн тухай нэвтрүүлэг юм.
10	2005 оны 3-р сарын 16.	<u>МОНГОЛД АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ЯМАР ЧИГЛЭЛЭЭР ХӨГЖИХ ВЭ?</u> Зөвхөн сайхан орон, байгаль нутаг нь онгон төрхөөрөө, хүн ард нь нөхөрсөг, хөдөө нутагтаа нүүдлийн соёл иргэншлийг хадгалж үлдсэн гээд улиг болсон сурталчилгаагаар хол явахгүй талаар санал солилцов.

## Нээлттэй Нийгэм Форумын 2005 оны нэвтрүүлгүүдийн товч танилцуулга

<b>ОЮУТОЛГОЙ БИДЭНД ЮУ ӨГӨХ ВЭ?</b> Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт дэлхийд томд орох алт, зэсийн орд илрүүлсэн Канадын "Айвенхоу Майнз" компанийн эзэн ноён Роберт Фридландтай Засгийн газрын байгуулах гэж байгаа тогтвортой байдлын гэрээ Монголчуудын эрх ашигт хэр нийцэж байгаа талаар ярилцав.	2005 оны 3-р сарын 23	11
<b>ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ӨӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ</b> Монголын хэвлэл, мэдээллийг эрүүлжүүлэх алхмуудын талаар сэтгүүлчид болон улстөрчид, үзэгч, уншигч, сонсогчдийн төлөөллөөр хэлэлцүүлээ.	2005 оны 3-р сарын 30	12
<b>СУРАХ БИЧГИЙН ҮНЭ</b> Сурах бичгийг үнэтэй болгох тухай төрийн байгууллагуудын шийдвэр, үүнээс гарах үр дагаврын талаар яам, хэвлэх үйлдвэрийн захирлууд, эцэг эхчүүдийн оролцоотойгоор хэлэлцлээ.	2005 оны 4-р сарын 6	13
<b>2008 ОНЫ "ТОГЛООМЫН ДҮРЭМ"</b> УИХ-ын сонгуулийн хуулийг өөрчлөх хувилбаруудыг хэлэлцэв.	2005 оны 4-р сарын 13	14
<b>МЭДЭХ ЭРХ</b> Манай төр, засаг иргэддээ хаалттай учраас авилгал хавтгайрч, дээд ба дунд шатны албан тушаалтнууд дураараа дургиж байгааг дүгнээд мэдээллийн эрх чөлөөний хуулийн төслийг хэрхэн бэлтгэж байгаа талаар хэлэлцэв.	2005 оны 4-р сарын 20	15
<b>ОЛИМПИЙН НАЙДВАР</b> 2008 онд өмнөд хөршийн маань нийслэлд болох олимпоос бид аварга төрнө гэж найдах эрхтэй юу? Ямар төрлөөр, хэн Монголын анхны олимпийн аварга гэсэн алдрыг хүртэх вэ? Энэ талаар Монголын нэртэй тамирчид, дасгалжуулагчид, ивээн тэтгэгч, бизнесийнхэн ярилцав.	2005 оны 4-р сарын 27	16
<b>МОНГОЛЫН НОГООН ХЭРЭМ</b> "Ногоон хэрэм" бол 2005-2035 он хүртэлх 30 жилийн хугацаанд Монгол орны баруун зүүн тийш 12 аймгийг хөндлөн өнгөрөх 2500 км урт ойн үндсэн зурвас, бас 1200 км-ээс доошгүй урттай туслах зурвас байгуулах асар их бүтээн байгуулалт юм. Энэ бүтэх үү?	2005 оны 05-р сарын 04	17
<b>МАРГААШИЙН ТЭТГЭВЭР</b> Өнөөдөр манай улсын хэмжээнд 170 гаруй мянган хүн өндөр насны тэтгэвэр авдаг. Жилд 74 орчим тэрбум төгрөг зарцуулдгийн 70 тэрбум нь одоо ажил хөдөлмөр эрхлэж байгаа хүмүүсийн ирээдүйд авах тэтгэвэртээ төлсөн мөнгө. Үлдсэн 4 тэрбум гаруйг нь л улсын төсвөөс гаргадаг байна. Монгол Улсын нийгмийн даатгал, тэтгэврийн тогтолцоо аль зүгт явж байна вэ?	2005 оны 5-р сарын 11	18
<b>ТАТВАР</b> УИХ-ын чуулганаар Монгол Улсын татварын хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулна. 100 сая төгрөгөөс дээш орлоготой компаниуд 30 хувийн татвар төлдөг байсан босгыг 500 сая төгрөг болгож нэмэгдүүлнэ. Тэгвэл 100 гаруй томоохон компанийн татвар 15 хувь болж буурна. Энэ асуудлыг Сангийн сайдын оролцоотойгоор хэлэлцлээ.	2005 оны 5-р сарын 25	19
<b>ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨН</b> Иргэдийн хөдөлгөөний тавьж байгаа шаардлагыг албан тушаалтнууд хэрхэн хүлээж авдаг вэ, иргэдийн тэмцэл үр дүнд хүрдэг үү?... Голуудын цутгалд алт олборлохыг эсэргүүцсэн хөдөлгөөн бараг аймаг бүхэнд байгуулагдсан, гэвч тэдний тэмцэл алт олборлохыг бүрмөсөн зогсоох эцсийн зорилгоо биелүүлж чадахгүй байгаагийн шалтгааныг хэлэлцлээ.	2005 оны 6-р сарын 08	20

## Нээлттэй Нийгэм Форумын 2005 оны нэвтрүүлгүүдийн товч танилцуулга

21	2005 оны 6-р сарын 15	<b>НЭГ УДААГИЙН МОНГОЛ</b> Олон хүний нэрлэж заншсанаар төрийн хар хайрцагны бодлого буюу төрийн ой санамж, залгамж чанар Монголын төрд хангалтгүй байгаа талаар ярилцав.
22	2005 оны 6-р сарын 22	<b>"МОНГОЛЧУУД ЭРГЭЖ ИРЭХ ҮҮ?"</b> 1990-оноос хойш Монголын аль ч төр, Засгийн газар иргэдээ гадаад руу цагаачлахыг уриалж байгаагүй атал хэдэн арван мянгаараа гадагшаа гараад суурьчихсан. Цаашдаа юу болох вэ?
23	2005 оны 11-р сарын 2.	<b>АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ: ЧИНГИСИЙН МОНГОЛ</b> Ядаж Чингис хааныхаа нэрээр бид жуулчдыг татаж чадаж байна уу? Үүнийг яаж манай аялал жуулчлалын том брэнд болгох вэ гэсэн асуулт тавьж ярилцав.
24	2005 оны 11-р сарын 9.	<b>СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ</b> Энэ сэдвийг анх удаа хөндөн ярилцаж төр, засгийн ажил, төрийн албан тушаалтнуудын үйл ажиллагаанд хэм хэмжээ суларч, дүрэм журам, хууль ёс алдагдаж авилгалын үүд нээгдэж байна гэсэн дүгнэлт хийлээ.
25	2005 оны 11-р сарын 16.	<b>ӨРСӨЛДӨХ ЧАДВАР: АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ</b> Монгол Улс энэ онд дор хаяж 500 мянган жуулчин авах зорилт хэрэгжихгүй болжээ. Аялал жуулчлалын салбарын бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэх арга замыг эрэлхийлсэн нэвтрүүлэг.
26	2005 оны 11-р сарын 23.	<b>МОНГОЛ ХҮНИЙ ОРЛОГО</b> Монголчууд бид ахуй амьдрал, амьжиргааны төвшнөөрөө яалт ч үгүй бие биенээсээ илт ялгардаг болсон. Баян чинээлэг хэсэг нь хүн амын 20 хувь, үгээгүй ядуу нь 80 хувьд хүрсэн ч гэж ярьж байгаа. Энэ тухай илэн далангүй ярилцлаа.
27	2005 оны 11-р сарын 30.	<b>ГАЗРЫН МАРГААН</b> Улаанбаатар хотын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө, газрын бүртгэл, кадастр, хэн ямар газрыг эзэмшдэг, аль газрыг хэзээ ямар журмаар олгох тухай мэдээллийг иргэдэд өгдөггүй хэвээрээ байгааг шүүмжлэн ярилцав.
28	2005 оны 12-р сарын 07.	<b>МОНГОЛД ЭРҮҮ ШҮҮЛТ БИЙ ЮУ?</b> Сэжигтнийг мөрдөн байцаах болон урьдчилан хорих явцад дарамт шахалт, зодуур, эрүү шүүлт хамгийн их гардаг ноцтой асуудлыг хэрхэн шийдэх арга замыг хэлэлцлээ.
29	2005 оны 12-р сарын 14.	<b>ШАГНАЛ</b> Монгол Улсын Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ дагуу иргэддээ олгодог төрийн шагналын систем өнөөгийн нийгмийн үнэлэмжид нийцэхээ больж хоцрогдсоныг олон талаас хөндөн ярилцав.
30	2005 оны 12-р сарын 21.	<b>ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗ: АНХНЫ АЛХАМ</b> Олон Нийтийн Радио, Телевизийн тухай хууль хүчин төгөлдөр болсноос хойш өөрчлөлт ажиглагдахгүй, харин хувийн арилжааны телевизүүд илүү шинэлэг, санаачилгатай ажиллаж өрсөлдөөнд давж гараад байгааг анхааруулсан нэвтрүүлэг.

### "www.forum.mn" ПОРТАЛ САЙТ

Монгол дахь бодлого боловсруулах болон хэрэгжүүлэх үйл явц, бодлогын шийдвэрийн талаарх мэдээллээр олон нийтийг хангах, бодлогод хяналт тавих, үнэлэх зэрэг чиглэлд түлхүү анхаарах зорилттой "www.forum.mn" портал сайт нь 2005 онд өмнө нь эхлүүлсэн ажлыг үргэлжлүүлэхийн зэрэгцээ зарим нэг буланг шинээр үүсгэж мэдээлийн баазаа өргөжүүллээ. Ийм шинэлэг эхлэлийн нэг нь 2005 оны 11 дүгээр сараас ажлуулсан **"News headlines"** булан юм. Энэ нь тухайн өдрийн Монголын улстөр, эдийн засгийн онцлох үйл явдлын талаарх тойм мэдээллийг олон нийтэд хүргэх зорилготой бөгөөд өдөр тутмын сонин хэвлэлүүдийн мэдээлэлд үндэслэн өдөр бүр байнга шинэчилдэг. Өнгөрсөн хугацаанд нийт 40 орчим мэдээллийг монгол, англи хэлээр бэлтгэн толилуулсан нь портал сайтын олны анхаарлыг татсан чухал хэсэг боллоо.

2005 онд Монголын уул уурхайн салбарын хувьд ихээхэн онцлогтой жил болж өнгөрсөн. Энэхүү онцлогийг энэ салбарын хөгжлийн хурдацтай холбоотойгоор олон нийтийн үүсгэл санаачилгын үндсэн дээр орон нутгийн болон газар шорооны төлөөх иргэдийн хөдөлгөөнүүд олноор байгуулагдан нэгдэн нягтрах үйл явц өрнөсөнтэй холбон ойлгож болох юм. Чухам энэ үед бидний 2004 оны 12 дугаар сарын 20-нд эхлүүлсэн **"Уул уурхай ба хөгжил"** сэдэвт ажиглалт цаг үеийн чухал мэдээллийг нэг дороос үзэх боломжийг олгосноороо ач холбогдолтой боллоо. Улс орны хэмжээнд хөрөнгө оруулалтаар хамгийн өндөрт орж байгаа уул уурхайн салбарын Монгол Улсын хөгжилд оруулж буй төлөв байдалд ажиглалт хийж, мэдээллээр тогтмол баяжуулахыг эрмэлзсний үндсэн дээр тайлант хугацаанд тус салбарын талаарх судалгаа, тайлан үнэлгээ, томоохон төслүүд, тэдгээрт холбогдох гэрээ, баримт бичиг, хууль тогтоомж, хэрэгжилтийн тухай баримт, тогтмол мэдээлэл зэрэг 70 гаруй мэдээллийг цуглуулсан байна. Монгол Улсын Засгийн Газар, "Айвенхоу Майнз Лимитед" болон "Айвенхоу Майнз Монголия ИНК" ХХК-ийн хооронд байгуулах тогтвортой байдлын гэрээний төслийг Санхүү, Эдийн Засгийн Яамнаас боловсруулж Улсын Их Хурлын олонхийн бүлэгт танилцуулсантай холбогдуулан уг гэрээний төслийг сайтад тавьж, сар гаруй хугацаанд олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэхэд нийт 90 хүн санал бодлоо илэрхийлсэн байна.

Монгол Улс дахь жижиг, дунд бизнесийн салбарын мэдээллийг олон нийтэд хүргэхээр 2005 оны дөрөвдүгээр сараас эхлэн **"Жижиг, дунд бизнес"** сэдвийн дор ажиглалтын буланг мөн шинээр нээлээ. Одоогийн байдлаар холбогдох хууль тогтоомж, хандивлагчдын үйл ажиллагаа, энэ салбарын талаарх судалгаа, тайлан, үнэлгээ зэрэг 20 орчим мэдээллийг энд багцлан оруулаад байна.

2004 онд эхлүүлсэн бусад тогтмол ажиглалтыг мөн үргэлжлүүллээ. Тухайлбал, Улсын Их Хурлын болон Орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит **"Сонгуулийн ажиглалт"**-ыг

үргэлжлүүлэн явуулж, эдгээр сонгуулийн үр дүнд бий болсон улстөрийн нөхцөл байдал /Их эвслийн Засгийн газар байгуулагдсан/, шинэ парламентын өмнө тулгарч буй хүндрэл бэрхшээлүүд /сонгуулийн нэг субъект болох “Эх орон-Ардчилал” эвсэл задарсан зэрэг/, Эвслийн Засгийн газрын үйл ажиллагаа, мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх нийтдээ 110 гаруй мэдээ, мэдээллийг нийтэллээ. Мэдээллийг багцлахдаа намуудын амлалт Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хүрээнд хэрхэн хэрэгжиж буй байдлыг илүүтэй харгалзсан. Тэрчлэн бодлогын асуудлаар улстөрчдийн хэлсэн үг, байр суурийг харуулсан “Хэн юу хэлэв” буланг тогтмол ажиллуулав.

2005 оны тавдугаар сард болсон Ерөнхийлөгчийн сонгуулийн кампанит ажлын явцыг ажиглаж, үйл явдлыг дэлгэрэнгүй мэдээллээ.

**“Ерөнхийлөгчийн сонгууль-2005”** ажиглалтын хүрээнд сонгуульд нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрүүд, тэдгээрийг харьцуулсан тойм өгүүллийг сэтгүүлчид, мэргэжлийн хүмүүсээр бичүүлсний зэрэгцээ нэр дэвшигчдийн рейтингийн судалгаа, хэвлэл, мэдээллийн мониторинг, сонгуулийн кампанит ажлын явцын мэдээлэл, сонгуулийн үр дүн зэргийг тогтмол мэдээлэв. Нийт 140 орчим мэдээллийг олон нийтэд хүргэсэн байна.

Портал нь 2004 оноос эхлэн **“Төсвийн үйл явц”-ын** талаарх багц мэдээллүүдийг тогтмол толилуулдаг болсон. Тайлант хугацаанд 2005 оны улсын төсвийн тодотгол, тухайлбал, төсөв ерөнхийлөн захирагчдын зарлага, орлого, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, гадаад зээлийн ашиглалт, төлбөр зэрэгт холбогдох нийт 40 гаруй мэдээ, мэдээллийг түгээлээ. Тэрчлэн Монголд анх удаа 2004 оны улсын төсвийн гүйцэтгэл, болон Засгийн газрын жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит, 2006 оны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг бүрэн эхээр нь веб сайтад байрлуулж, олон нийтийн санал бодлыг нь хүлээн авч эхлэв. Монгол Улсын татварын тогтолцоог боловсронгуй болгох үүднээс татварын багц хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулахаар шинэчилсэн найруулгын төслийг бэлтгэж татвар төлөгчид болон бизнес эрхлэгчдээс санал авч буйтай холбогдуулан Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн төсөл, Онцгой албан татварын хуулийн төсөл, Хүн амын орлогын албан татварын хуулийн төсөл, Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн төсөл, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн төсөл зэрэг бичиг баримтыг сайтад байруулан санал авч эхэлсэн байна.

Монголын хөгжлийн талаарх олон янзын байр суурийг агуулсан дүн шинжилгээ бүхий өгүүллийг толилуулдаг **“Нийтлэл”** хэсэгт 2005 онд шинээр 50 өгүүлэл нэмэгджээ. Өмнөх онд улстөр, төсөв, мэдээллийн эрх чөлөөний тухай асуудлууд түлхүү тусгагдсныг харгалзан бусад сэдвийг тодорхой хэмжээгээр хөндөхийг зорьсны үр дүнд эдгээрээс гадна татвар, байгаль орчин, гадаад, дотоод бодлого, даяаршлын асуудлыг хөндсөн нийтлэлээр баяжсан бөгөөд эрдэмтэн судлаач, багш, сэтгүүлч, төрийн албан хаагч, улстөрч зэрэг давхардсан тоогоор

40 гаруй хүн нийтлэл, өгүүллээ нийлүүлжээ. 2005 онд “Орчуулгын нийтлэл” сэдвийн дор гадаадын нэр хүнд бүхий нийтлэлч, сэтгэгчдийн 14 гаруй бүтээлээс монгол хэлнээ хөрвүүлэн олны хүртээл болгов. Тухайлбал, Ромын хоёрдугаар хамба лам Ионн Паул, Френсис Фукуяама, Билдад Кагей, Марк Скаузен, Жорж Папендреу, Партха Дасгупта, Жеймс Гуартний, Роберт Манделл, Раи Човдури нарын нийтлэл, өгүүллийг монгол уншигчдад хүргэсэн байна.

**“Бодлогын асуудал”** буланд 2005 онд Татварын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслүүд, УИХ-ын сонгуулийн хуулийн төсөл, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн төсөл, Мэдээллийн технологийн тухай хуулийн төсөл, Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл, Ашгийн төлөө бус байгууллагын тухай хуулийн төсөл, Улстөрийн намын тухай хуулийн төсөл, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн төсөл, Ашигт малтмалын хуулийн шинэчилсэн найруулгын төсөл зэрэг баримт бичгүүд, тэдгээртэй холбоотой судалгаа, санал зөвлөмжийг багцлан толилуулсан байна. Тэрчлэн “Улстөрийн намуудын тухай” болон “Олон нийтийн радио, телевизийн тухай” хуулиудыг Монголын парламент хэрхэн хэлэлцэж баталсан талаарх мэдээ мэдээлэл, тойм өгүүллийг толилууллаа. Энэ буланд 2005 он гарсаар тайлант хугацаанд 40 гаруй мэдээллийг шинээр оруулсан бөгөөд эдгээр асуудлаар нийт 100 гаруй хүн санал бодлоо илэрхийлжээ.

2005 онд Монголын нийгэм, эдийн засгийн хөгжлийн сэдвээр донор байгууллагууд болон бусад судалгааны төвийн хийсэн 70 орчим шинэ судалгааг **“Эх сурвалж”** хэсэгт бүрэн эхээр нь pdf форматаар байрлуулав. Мөн бодлогын асуудлаар хэвлэгдэж буй ном товхимол, гарын авлагуудыг танилцуулжээ.

2005 онд манай сайтад нийт 180 гаруй мянган хүн, өдөрт дунджаар 500 орчим хүн нэвтэрч, 800 гаруй мэдээллээр порталын мэдээллийн сан арвижсан болно.

## БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

ННФ-ын Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр нь 2003 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд дотоодын бодлого судлаачдын хүчин чадлыг бэхжүүлэх, чанартай бодлогын шинжилгээ, судалгаагаар дамжуулан бодлого боловсруулагчид болон олон нийтэд мэдээлэл хүргэх, нөлөөлөх ажлыг эрчимжүүлэх зорилготой юм. Энэ хөтөлбөрт хамрагдах тухайн жилийн судалгааны сэдэв, шалгаруулалтад бүрдүүлэх материал, судлаачдад тавигдах ерөнхий шаардлага зэргийг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, өөрийн веб сайтаар дамжуулан 1- 1,5 сарын туршид зарлан мэдээлж, судлаачдыг ирүүлсэн материалын үнэлгээ, ярилцлага гэсэн хоёр үе шаттайгаар сонгон шалгаруулдаг. Хөтөлбөрт хамрагдсан судлаачдын судалгааны ажлын үр дүн, бодлогын зөвлөмжийг хэвлэн нийтэлж, уулзалт хэлэлцүүлгээр дамжуулан олны хүртээл болгож байна.

2005 онд Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрт нийт 50 гаруй судлаач хамрагдах хүсэлт ирүүлснээс зургаан судлаач шалгарч, 2005 оны тавдугаар сараас эхлэн дараахь судалгааг хийж гүйцэтгэж байна. Тухайлбал:

- Л. Золбаатар** “Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суурь боловсрол эзэмших боломж”,
- Г.Жаргал** “Орон нутгийн болон үндэсний татвар: Орон нутаг илүү бие даах боломжтой юу?”,
- О.Мөнхбат** “Төрийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдаж авах нь”,
- З.Батболд** “Зүүн Хойд Азийн зах зээл дэх Монголын стратегийн байр суурь”,
- Ч.Тамир** “Шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь: Эрхзүйн орчин болон институтчилэл”,
- Д.Дэлгэрцогт** “Засаг, захиргааны нэгжийн шинэтгэл ба төрийн хийгээд нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж”.

Хөтөлбөрийн хүрээнд бодлогын судалгаа, шинжилгээний аргагүй, бодлогын баримтыг бичиж боловсруулах аргачлал, нөлөөллийн үйл ажиллагааны стратеги гэсэн гурван сэдвээр сургалт зохиож, дотоод, гадаадын мэргэжилтнүүдийг зөвлөхөөр сонгон, судлаачидтай хамтран ажиллуулж байна. Судлаачид хөдөө орон нутагт судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг гүйцэтгэж, судалгааны дунд шатны үр дүнгээр олон нийтийн дунд хэлэлцүүлэг явуулж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр асуудал хөндсөн өгүүлүүд бичиж нийтлүүлдэг уламжлал тогтлоо. Дунджаар есөн сарын хугацаатай хэрэгжих эдгээр судалгаа нь 2006 оны гуравдугаар сард дуусах юм.



## ХЭВЛЭН НИЙТЛЭЛ

Нээлттэй Нийгэм Форумын үйл ажиллагааны нэг чухал хэсэг нь хэвлэн нийтлэл юм. Бодлого боловсруулах болон хэрэгжүүлэх явцад иргэд оролцох, хянах явцыг мэдээллээр хангахад хувь нэмэр оруулах зорилгоор бодлогын судалгаа шинжилгээний тайлан, иргэдэд зориулсан гарын авлага, номзүйн болон лавлагааны цуврал, орчуулгын ном зэргийг хэвлэн нийтэлж олны хүртээл болгож байна.

Шинээр хэвлэгдэн гарч буй ном товхимол нь хөдөө, орон нутгийн болон их, дээд сургуулийн номын сан, мэдээллийн болон судалгааны төв, ТББ, Засгийн газрын агентлаг, УИХ-ын гишүүд, донор байгууллагуудад түгээгдэж байна. Мөн Форумын хүрээнд зохиогдож буй олон нийтийн хэлэлцүүлэг, уулзалт ярилцлагын үеэр оролцогсдод тардаг болно.

### Үйл ажиллагаа үр дүн

Форумаас эрхлэн нийтдээ 57 нэрийн ном хэвлэснээс 27-г нь 2005 онд гаргажээ. Түүний дотор иргэдэд зориулсан гарын авлага, бодлогын судалгааны тайлан, номзүйн цуврал зэрэг номууд шинээр хэвлэгдэн гарсан байна.

### Иргэдэд зориулсан гарын авлага

- Хууль хэрхэн бүтдэг вэ (англи хэл дээр)
- Газрын харилцааны шинэтгэл (англи хэл дээр)
- Мэдээллийн эрх чөлөө
- Иргэн ба татвар (англи хэл дээр)
- Улсын төсвийн үйл явц
- Орон нутгийн төсвийн үйл явц
- Эдийн засаг, бизнесийн асуудлаар бичих нь – 1,2
- Хуульзүйн туслалцаа хэрхэн авах вэ
- Газрын тосны тухай бичихүй
- Та хотын хүн боллоо (шилжин суурьшигчдад зориулсан гарын авлага)
- Олборлох Салбарын Ил Тод Байдлын Санаачилга: Сурвалж бичиг

### Судалгааны тайлан

- Соёл, урлагийн салбарын хувьчлал (англи хэл дээр)
- Эрүүл мэндийн салбарын хувьчлал (англи хэл дээр)
- Боловсролын салбарын хувьчлал (англи хэл дээр)
- Мал аж ахуйд төр, засгийн үүрэг
- Хөгжлийн албан ёсны тусламж – хөдөөгийн хөгжилд
- Төрийн эрх мэдлийг урвуулан ашиглахын эсрэг авах арга хэмжээ
- Монгол Улсын газрын шинэтгэлийн асуудал
- Үндэсний ба нутгийн удирдлагын чиг үүргийн зохистой хуваарилалт
- Сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн мониторинг
- Монгол Улсын албан бус секторын хамрах хүрээ, төлөв байдал (англи, монгол хэл дээр)

### Лавлагаа, ном зүйн цуврал

- Монгол дахь ядуурлын асуудалд холбогдох номзүй
- Монгол дахь авилгалын асуудалд холбогдох номзүй

Түүнчлэн Нээлттэй Нийгэм Форум Монсудар хэвлэлийн газартай хамтран орчуулгын төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд гадаад хэл дээр хэвлэгдэн гарсан нийгэм, эдийн засаг, улстөр, хөгжлийн сэдэвтэй дэлхий нийтээр уншиж байгаа зохиол бүтээлийг орчуулан нийтэлж уншигчдад хүргэхийг зорьж байна. Уг төслийн хүрээнд 11 ном сонгон орчуулж хэвлэхээр тохиролцсон ба одоогоор дараахь номууд хэвлэлтээс гарч уншигчдын гарт хүрчээ.



- Майкл Фейрбенкс, Стэйс Линдсей “Далайг хагалах нь: Эдийн засгийн хөгжлийн нуугдмал боломжийг ашиглах нь”
- Самуэл Хантингтон “Иргэншил хоорондын мөргөлдөөн, шинэчлэгдэн буй дэлхийн дэг журам”
- Дэвид Боаз “Либертарианизм”
- Айзек Азимов “Эхлэлийн эхлэл”
- Даниел Ж . Бурстин “Америк орон: Ардчиллын туршлага”
- Франсис Фукуяма “Төрийг байгуулах нь”
- Карл Поппер “Нээлттэй Нийгэм, түүний дайснууд”
- Жоорж Оруэлл “1984”

Орчуулгын төслийн хүрээнд хэвлэгдэн гарч байгаа номуудаас бизнесийн ашиг олохыг зориогүй ба орлогоороо зарлагаа нөхөж дараа дараагийн хэрэгцээ шаардлагатай номуудыг монгол хэлнээ орчуулан хэвлэх сан бий болгоход чиглэж буй юм. Иймээс уг ажил нь иргэдийн танин мэдэхүй, мэдлэг боловсролыг дээшлүүлэх, нийгмийн сэтгэлгээний цаашдын хөгжилд түлхэц өгч, дараа дараагийн ном орчуулагдан хэвлэгдэх эрэлт хэрэгцээг бий болно гэж үзэж байна.

## ХАВСРАЛТ

## САНХҮҮГИЙН ТАЙЛАН

<b>НИЙТ ЗАРЦУУЛАЛТ</b>			
\$ доллар			
Хөтөлбөр	Үйл ажиллагааны зардал	Бусад байгууллагад олгосон тэтгэлэг	Нийт зардал
<b>ЗАСАГЛАЛ</b>	<b>204,780</b>	<b>323,849</b>	<b>528,629</b>
Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө	37,314	47,493	84,807
Нээлттэй ил тод төсөв	11,970	1,451	13,421
Боловсролын салбарын төсвийн зарцуулалт	44,317 <sup>1</sup>	-	44,317
Сонгуулийн кампанит ажлын санхүүжилт	24,150	-	24,150
Төрийн үйлчилгээний мониторинг	20,985	131,641	152,626
Мэдээллийн эрх чөлөө ба иргэдийн оролцоо	2,890	6,676	9,566
Нутгийн болон төвлөрсөн удирдлага	8,933	14,290	23,223
Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж	11,832	5,580	17,412
Эрхзүйн туслалцаа	19,486	75,968	95,454
Төрийн бус байгууллагын эрхзүйн зохицуулалт	22,903	750	23,653
Боловсрол	-	40,000	40,000
<b>ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>	<b>132,761</b>	<b>56,546</b>	<b>189,307</b>
Эдийн засгийн эрх чөлөөний индекс	57,370	23,590	80,960
Сүүдэр эдийн засгийн үүрэг, роль	13,029 <sup>2</sup>	-	13,029
Уул уурхайн салбарын бодлогын асуудал	11,025	16,576	27,601
Газрын шинэтгэлийн хэрэгжилт	32,209	-	32,209
Хувийн хөрөнгө оруулалтын сан	12,397 <sup>3</sup>	-	12,397
Хөгжлийн бодлогын яриа хэлэлцүүлэг	6,731	16,380	23,111
<b>БУСАД</b>	<b>-</b>	<b>9,378</b>	<b>9,378</b>
Дорно дорно хөтөлбөр	-	9,378	9,378
<b>ФОРУМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЯВУУЛАХ АРГА ХЭРЭГСЭЛ</b>	<b>244,808</b>	<b>-</b>	<b>244,808</b>
Хөгжлийн мэдээллийн төв	35,013	-	35,013
Телевизийн хөтөлбөр	73,625	-	73,625
Портал сайт	49,755	-	49,755
Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр	47,778	-	47,778
Олон нийтийн хэлэлцүүлэг	28,963	-	28,963
Хэвлэн нийтлэл	9,674	-	9,674
<b>ЗАХИРГАА</b>	<b>285,090</b>	<b>-</b>	<b>285,090</b>
<b>НИЙТ ДҮН</b>	<b>867,439</b>	<b>389,773</b>	<b>1,257,212</b>

**Тайлбар тэмдэглэл:** <sup>1</sup> Дэлхийн банктэй хамтарч хэрэгжүүлсэн;

<sup>2,3</sup> АНУ-ын ОУХА-ийн санхүүжилттэй Эдийн засгийн бодлогын шинэчлэл, өрсөлдөх чадварын төсөлтэй хамтарч хэрэгжүүлсэн.

<b>ТЭТГЭЛГИЙН НИЙТ ЗАРЦУУЛАЛТ</b> (төрлөөр)						
\$ доллар						
<b>Хөтөлбөр</b>	<b>Нийт</b>		<b>Байгууллага</b>		<b>Хувь хүн</b>	
	<b>Тоо</b>	<b>Дүн</b>	<b>Тоо</b>	<b>Дүн</b>	<b>Тоо</b>	<b>Дүн</b>
<b>ЗАСАГЛАЛ</b>	<b>38</b>	<b>323,849</b>	<b>20</b>	<b>279,510</b>	<b>18</b>	<b>44,339</b>
Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө	5	47,493	2	41,135	3	6,358
Нээлттэй ил тод төсөв	1	1,451			1	1,451
Боловсролын салбарын төсвийн зарцуулалт						
Сонгуулийн кампанит ажлын санхүүжилт						
Төрийн үйлчилгээний мониторинг	15	131,641	15	131,641		
Мэдээллийн эрх чөлөө ба иргэдийн оролцоо	1	6,676			1	6,676
Нутгийн болон төвлөрсөн удирдлага	2	14,290			2	14,290
Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж	1	5,580			1	5,580
Эрхзүйн туслалцаа	11	75,968	2	66,734	9	9,234
Төрийн бус байгууллагын						
эрхзүйн зохицуулалт	1	750			1	750
Боловсрол		40,000	1	40,000		
<b>ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>	<b>9</b>	<b>56,546</b>	<b>3</b>	<b>30,154</b>	<b>6</b>	<b>26,392</b>
Эдийн засгийн эрх чөлөөний индекс	2	23,590	1	16,500	1	7,090
Сүүдэр эдийн засгийн үүрэг, роль						
Уул уурхайн салбарын бодлогын асуудал	5	16,576	1	5,654	4	10,922
Газрын шинэтгэлийн хэрэгжилт						
Хувийн хөрөнгө оруулалтын сан						
Хөгжлийн бодлогын яриа хэлэлцүүлэг	2	16,380	1	8,000	1	8,380
<b>БУСАД</b>	<b>8</b>	<b>9,378</b>				
Дорно дорно хөтөлбөр	8	9,378			8	9,378
<b>НИЙТ ДҮН</b>	<b>55</b>	<b>389,773</b>	<b>23</b>	<b>309,664</b>	<b>24</b>	<b>80,109</b>

<b>БАЙГУУЛЛАГАД ОЛГОСОН ТЭТГЭЛЭГ</b>		<b>\$ 309664</b>		
\$ доллар				
<b>Тэтгэлэг хүртэгсэд</b>	<b>Зорилго</b>	<b>Хугацаа</b>	<b>Нийт санхүүжилт</b>	
<b>ЗАСАГЛАЛ</b>				
<b>ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ</b>				
1	Глоб интернэшнл	Мэдлэг бол хүч	2005 оны VI.28-VII.5	<b>1,775</b>
2	Глоб интернэшнл	Үзэл бодлоо илэрхийлэх зөрчлийн мониторинг	2005 оны X.21- 2006 оны I.30	<b>39,360</b>
<b>ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МОНИТОРИНГ</b>				
3	Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо	Тусгай зөвшөөрлийн мониторинг	2005 оны XII 1- 2006 оны IV.30	<b>5,379</b>
4	Нийгмийн халамж - Хамтын ажиллагаа сан	Баянхонгор, Дорнод аймгууд дахь улсын асрамжийн газрын нөхцөл байдлын үнэлгээ	2005 оны XII.1- 2006 оны VI.30	<b>6,200</b>
5	Хүний Эрх Хөгжил Төв	Орон нутгийн шүүхийн үйл ажиллагаанд мониторинг хийх	2005 оны XII.1- 2006 оны VI.30	<b>7,310</b>
6	Хүний Эрх Шударга Ёсны Төлөө Хөдөлгөөн	Анхан шатны шүүх хуралдааны мониторинг	2005 оны XII.1- 2006 оны VI.30	<b>11,160</b>
7	Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөн	Төсвийн хүү торгуулийн орлогын бүрдүүлэлтийн мониторинг	2005 оны XII.1- 2006 оны VI.30	<b>13,300</b>
8	Нийгмийн Судалгааны Байгууллагуудын Хамтын Ажиллагааг Дэмжих Төв	Төрөөс иргэдэд газар өмчлүүлэх (эзэмшүүлэх ашиглуулах) үйлчилгээнд хийх мониторинг	2005 оны XII.1- 2006 оны V.30	<b>13,150</b>
9	Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөний Өвөрхөнгөй аймгийн салбар	Орон нутгийн төсөв дэх иргэдийн оролцоо	2005 оны XII.1- 2006 оны VI.30	<b>13,400</b>
10	Бэр цэцэг холбоо	Цэргийн дүрэмт хувцасны хангалтанд мониторинг	2005 оны XII.1- 2006 оны V.30	<b>5,341</b>
11	Монголын Хуульч Эмэгтэйчүүдийн Холбоо	Барилга байгууламж барих зорилгоор иргэр аж ахуйн нэгжид газар олгох төрийн үйлчилгээнд мониторинг хийх	2005 оны XII.1- 2006 оны VIII.30	<b>5,722</b>
12	Зориг сан	Гаалийн мониторинг	2005 оны XII.1- 2006 оны V.30	<b>10,220</b>
13	Монголын Тэргэнцэртэй Иргэдийг Дэмжих "Төмөр сан"	Нийгмийн халамжийн үйлчилгээнд мониторинг хийх	2005 оны XII.1- 2006 оны VI.30	<b>8,600</b>
14	Эмэгтэйчүүдийн Үндэсний Сүлжээний Багануур дахь Салбар	Газрын харилцаа ба иргэд	2005 оны XII.1- 2006 оны VIII.30	<b>8,900</b>
15	Монголын Эм Найруулагчдын Холбоо	Эм барих лицензийн олголт	2005 оны XII.1- 2006 оны V.30	<b>8,096</b>
16	Монголын Худалдаа Эд Хэрэглэгчийн Хоршооллын Төв Холбоо	Орон сууцны дэргэдэх хүүхдийн тоглоомын талбайн газар олголт, эзэмшлийн байдалд хийх мониторинг	2005 оны XII.1- 2006 оны ?.30	<b>6,715</b>
17	Монголын Тул Хамгаалах Нийгэмлэг	Байгаль орчныг хамгаалах сангийн үйл ажиллагаанд хийх мониторинг	2005 оны XII.1- 2006 оны VIII.30	<b>8,148</b>
<b>ЭРХЗҮЙН ТУСАЛЦАА</b>				
18	Хууль Зүй Дотоод Хэргийн Яам	ЗДТГ-ын хуулийн хэлтсийн эрх зүйн сургалт сурталчилгаа хариуцсан ажилтнуудын чадавхийг сайжруулах буюу Паралегал төсөл	2005 оны IX.5- 2006 оны XII.31	<b>50,827</b>
19	Хууль Зүй Дотоод Хэргийн Яам	Сонгинохайрхан дүүрэг болон Хэнтий аймаг дахь төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн тусалцаа үзүүлэх туршилтын үйл ажиллагаа	2003 оны XII.25- 2006 оны X.30	<b>15,907</b>
<b>БОЛОВСРОЛ</b>				
20	Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг	Үйл ажиллагааг дэмжих	2005 оны I.1-XII.30	<b>40,000</b>
<b>ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>				
<b>ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ИНДЕКС</b>				
21	МУИС-ийн Эдийн Засгийн Сургууль	Эдийн засгийн эрх чөлөөний тайлан	2005 оны XII.27- 2006 оны VI.10	<b>16,500</b>
<b>УУЛ УУРХАЙН САЛБАРЫН БОДЛОГЫН АСУУДАЛ</b>				
22	Онги Голынхон Хөдөлгөөн	Онги голынхон хөдөлгөөний үйл ажиллагааг дэмжих	2005 оны IX.1-2006 оны II.28	<b>5,654</b>
<b>ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЯРИА ХЭЛЭЛЦҮҮЛЭГ</b>				
23	МУИС-ийн Эдийн засгийн сургууль	Хөгжлийн бодлогын яриа хэлэлцүүлэг R.Mundell - Монгол дахь айлчлал	2005 оны V.2-VI.30	<b>8,000</b>

<b>ХУВЬ ХҮНД ОЛГОСОН ТЭТГЭЛЭГ</b>		<b>\$ 80109</b>			
\$ доллар					
<b>Тэтгэлэг хүртэгсэд</b>	<b>Байгууллага</b>	<b>Зорилго</b>	<b>Хугацаа</b>	<b>Нийт санхүүжилт</b>	
<b>ЗАСАГЛАЛ</b>					
<b>ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ</b>					
1	У. Дөлгөөн	Мэдээлэл харилцаа холбоо технологийн газар	Сараева хотод Хэвлэлийн эрх чөлөөний тухай олон улсын бага хурал	2005.V.11-13	<b>2,005</b>
2	Д.Зумбэрэлхам	Глоб интернэшнл	Сараева хотод Хэвлэлийн эрх чөлөөний тухай олон улсын бага хурал	2005.V.11-13	<b>2,005</b>
3	Д.Сарангэрэл	Монголын Чөлөөт Сэтгүүлчдийн холбоо	Люксембург хотод болсон AIPCE - ийн Их хурал	2005. IX.28-X.2	<b>2,348</b>
<b>НЭЭЛТТЭЙ ИЛ ТОД ТӨСӨВ</b>					
4	Р.Бурмаа	Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүдын Хөдөлгөөн	Казакстан улсад зохиогдсон төсвийн зарцуулалтын анализ ба төсвийн байгууллагуудын үйл ажиллагаа	2005.IV.19-20	<b>1,451</b>
<b>МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО</b>					
5	Ч.Тамир	МУИС	Шийдвэр гаргах төвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	2005.IX.1- 2006.III.1	<b>6,676</b>
<b>НУТГИЙН БОЛОН ТӨВЛӨРСӨН УДИРДЛАГА</b>					
6	Г.Жаргал	Удирдлагын Академи	Орон нутгийн эдийн засгийг бие даан хөгжүүлэх арга зам, боломж	2005.XI.15-2006.VII.15	<b>7,800</b>
7	Д.Дэлгэрцогт	Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн шинэчлэлт ба төрийн болон нийгмийн үйлчилгээний асуудал		<b>6,490</b>
<b>НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖ</b>					
8	Л.Золбаатар	ME зөвлөх компани	Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суурь боловсрол эзэмших боломж	2005.V.9-XII.9	<b>5,580</b>
<b>ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА</b>					
9	Ц.Цолмон	Хууль Зүй Дотоод Хэргийн Яам	Унгар улсад зохиогдсон Эрхзүйн туслалцааны хүртээмж бага хурал	2005.II.24-26	<b>916</b>
10	Ш.Солонго	Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар	Унгар улсад зохиогдсон Эрхзүйн туслалцааны хүртээмж бага хурал	2005.II.24-26	<b>916</b>
11	Л.Гарамжил	Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газар	Киргиз улсад зохиогдсон согтууруулах ундаа, хар тамхины эсрэг Атлантук бүсийн уулзалт	2005.V.9-12	<b>1,205</b>
12	Б.Даваасүрэн	Хууль Зүй Дотоод Хэргийн Яам	Киргиз улсад зохиогдсон согтууруулах ундаа, хар тамхины эсрэг Атлантук бүсийн уулзалт	2005.V.9-12	<b>1,205</b>
13	Ч.Лхамсүрэн	Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газар	Польш улсад зохиогдсон согтууруулах ундаа, хар тамхины эсрэг Атлантук бүсийн уулзалт	2005.VI.9-44	<b>1,107</b>
14	Б.Энхцогт	Архидалт мансуурлын эсрэг нийгэмлэгийн Өвөрхангай дахь салбар	Польш улсад зохиогдсон согтууруулах ундаа, хар тамхины эсрэг Атлантук бүсийн уулзалт	2005.VI.9-44	<b>1,107</b>
15	П.Эрдэнэцэцэг	Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын Харьяа 411 анги	Польш улсад зохиогдсон Хамгаалал ба хүчирхийлэл сэдэвт сургалт	2005.IX.16-20	<b>926</b>
16	С.Баасанбат	Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв	Польш улсад зохиогдсон Хамгаалал ба хүчирхийлэл сэдэвт сургалт	2005.IX.16-20	<b>926</b>
17	О.Пүрэвсүрэн	Албадан хөдөлмөр хийлгэх төсөл	Польш улсад зохиогдсон Хамгаалал ба хүчирхийлэл сэдэвт сургалт	2005.IX.16-20	<b>926</b>

<b>ХУВЬ ХҮНД ОЛГОСОН ТЭТГЭЛЭГ</b>		<b>\$ 80109</b>		
\$ доллар				
<b>Тэтгэлэг хүртэгсэд</b>	<b>Байгууллага</b>	<b>Зорилго</b>	<b>Хугацаа</b>	<b>Нийт санхүүжилт</b>
<b>ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ</b>				
18 Н.Чимэг	Шинжлэх Ухааны Академи	Израил улсад зохиогдсон Иргэний нийгэм дэх эмэгтэйчүүдийн манлайлал судалгааны курс	2005.II.7-III.3	<b>750</b>
<b>ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ИНДЕКС</b>				
19 О.Мөнхбат	МУИС	Төрийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тогтолцоог боловсронгуй болгох	2005.V.2-2006.I.3	<b>7,090</b>
<b>УУЛ УУРХАЙН САЛБАРЫН БОДЛОГЫН АСУУДАЛ</b>				
20 Г.Цогтсайхан	Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар	Киргиз улсын EITI салбарыг судлах	2005.X.23-29	<b>2,670</b>
21 Ц.Дамиран	УИХ	Киргиз улсын EITI салбарыг судлах	2005.X.23-29	<b>2,704</b>
22 Р.Бадамдамдин	УИХ	Киргиз улсын EITI салбарыг судлах	2005.X.23-29	<b>2,671</b>
23 Л.Дэлгэрдалай	Ашигт Малтмал Газрын Тосны Хэрэг Эрхлэх Газар	Киргиз улсын EITI салбарыг судлах	2005.X.23-29	<b>2,877</b>
<b>ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЯРИА ХЭЛЭЛЦҮҮЛЭГ</b>				
24 З.Батболд	Проспер компани	Монгол Улс Зүүн Хойд Азийн бүсчлэлийн хэрэгцээ, шаардлагад тээврийн дэд бүтцээ тохируулан хөгжүүлэх арга замууд	2005.VI.9-2006.II.9	<b>8,380</b>
<b>БУСАД</b>		<b>ДОРНО ДОРНО ХӨТӨЛБӨР</b>		
25 Б.Эрдэнэчулуун	Мэргэжлийн Хяналтын Газар	Украин улсад болсон Болосролын чанар ба хариуцлагын асуудал сургалт	2005.X.5-9	<b>912</b>
26 Д.Биндэрьяа	Боловсролын Үнэлгээний Газар	Украин улсад болсон Болосролын чанар ба хариуцлагын асуудал сургалт	2005.X.5-9	<b>912</b>
27 Б.Энхжин	Эрүүл Мэндийн Яам		2005.XI.1-2	<b>734</b>
28 Р.Банди	Боловсролын Яам	Литва улсад болсон Боловсролын бодлогын шилжилт ба боловсролын бодлогын төвүүд сургалт	2005.XI.11-12	<b>1,104</b>
29 Н.Энхтуяа	Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг	Литва улсад болсон Боловсролын бодлогын шилжилт ба боловсролын бодлогын төвүүд сургалт	2005.XI.11-12	<b>1,104</b>
30 М.Төрбаяр	Хууль Зүй, Дотоод Хэргийн Яам	Турк улсад болсон Иргэний нийгмийн хуулийн Форум	2005.XI.17-19	<b>1,810</b>
31 Р.Нарангэрэл	Иргэдийн боловсрол төв	Турк улсад болсон Иргэний нийгмийн хуулийн Форум	2005.XI.17-19	<b>1,810</b>
32 Л.Гантулга	Дундговь аймаг	Киев хотод Нээлттэй сүлжээний бодлого семинар	2006.II.20-25	<b>992</b>

**АЖИЛТНУУД****Нээлттэй Нийгэм Форумын Удирдах зөвлөл:**

Ж.Нарантуяа	<a href="mailto:narantuya@mail.parl.gov.mn">narantuya@mail.parl.gov.mn</a>
Д.Жаргалсайхан	<a href="mailto:djargal@yahoo.com">djargal@yahoo.com</a>
Саха Меяанатан	<a href="mailto:smeyanathan@worldbank.org">smeyanathan@worldbank.org</a>
Ц.Ариунаа	<a href="mailto:ariunaa@artscouncil.mn">ariunaa@artscouncil.mn</a>
П.Цэнгүүн	<a href="mailto:ptsenguun@altantaria.mn">ptsenguun@altantaria.mn</a>
Л.Төр-Од	<a href="mailto:turod@undp.org">turod@undp.org</a>

**Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал:**

<b>П.Эрдэнэжаргал</b>	<b><a href="mailto:jargal@soros.org.mn">jargal@soros.org.mn</a></b>
-----------------------	---

**Нээлттэй Нийгэм Форумын ажилтнууд:**

М.Амарбаяр	TV хөтөлбөрийн редактор	<a href="mailto:amarbayar@soros.org.mn">amarbayar@soros.org.mn</a>
Д.Аюуш	Нягтлан бодогч	<a href="mailto:ayush@soros.org.mn">ayush@soros.org.mn</a>
Р.Бадамрагчаа	ННФ-ын захирлын туслах	<a href="mailto:badmaa@soros.org.mn">badmaa@soros.org.mn</a>
Д.Балжид	Мэдээллийн менежер	<a href="mailto:baljid@soros.org.mn">baljid@soros.org.mn</a>
Т.Батбаатар	Веб мастер	<a href="mailto:batbaatar@soros.org.mn">batbaatar@soros.org.mn</a>
Ж.Баярцэцэг	ННФ-ын менежер	<a href="mailto:bayar@soros.org.mn">bayar@soros.org.mn</a>
Н.Дорждарь	ННФ-ын менежер	<a href="mailto:dorjdari@soros.org.mn">dorjdari@soros.org.mn</a>
Д.Гантуяа	Порталын ерөнхий редактор	<a href="mailto:gantuya@soros.org.mn">gantuya@soros.org.mn</a>
Ц.Ганболд	TV хөтөлбөрийн ерөнхий менежер	<a href="mailto:ganbold@soros.org.mn">ganbold@soros.org.mn</a>
Ш.Ганчимэг	Захиргааны туслах ажилтан	<a href="mailto:ganaa@osf.org.mn">ganaa@osf.org.mn</a>
А.Гэрэлмаа	ННФ-ын менежер	<a href="mailto:gerelmaa@soros.org.mn">gerelmaa@soros.org.mn</a>
Д.Жавхлан	Санхүүгийн захирал	<a href="mailto:javkhlan@soros.org.mn">javkhlan@soros.org.mn</a>
Б.Ичинхорлоо	ННФ-ын туслах ажилтан	<a href="mailto:ichka@soros.org.mn">ichka@soros.org.mn</a>
Б.Мөнхсоёл	ННФ-ын менежер	<a href="mailto:soyoloo@soros.org.mn">soyoloo@soros.org.mn</a>
Б.Нарантуяа	TV хөтөлбөрийн менежер	<a href="mailto:naraa@soros.org.mn">naraa@soros.org.mn</a>
Ш.Цог	Порталын англи хэлний редактор	<a href="mailto:tsog@soros.org.mn">tsog@soros.org.mn</a>
Д.Цэрэнжав	TV хөтөлбөрийн редактор	<a href="mailto:tseren@soros.org.mn">tseren@soros.org.mn</a>
Т.Цэцэгдарь	Мэдээллийн төвийн туслах ажилтан	<a href="mailto:daria@soros.org.mn">daria@soros.org.mn</a>
Д.Өлзийбадрах	Мэдээлэл сүлжээний зохицуулагч	<a href="mailto:ulzii@soros.org.mn">ulzii@soros.org.mn</a>
Т.Отгонбаяр	Захиргааны туслах ажилтан	<a href="mailto:reseption@soros.org.mn">reseption@soros.org.mn</a>
Ч.Саруул	Жолооч	<a href="mailto:saruul@soros.org.mn">saruul@soros.org.mn</a>
Б.Баатар	Жолооч	<a href="mailto:baatar@soros.org.mn">baatar@soros.org.mn</a>
Г.Цэдэвхүү	Жолооч	<a href="mailto:cedev@soros.org.mn">cedev@soros.org.mn</a>

**Байгууллагын имэйл:****[osf@soros.org.mn](mailto:osf@soros.org.mn)**